


15TH
ANNIVERSARY
since 2008

IRIM
INDEPENDENT
RESEARCH
INSTITUTE OF
MONGOLIA

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022/2023

Тусгай дугаар



Хараат бус

Чанар

Үр нөлөө

АГУУЛГА

Бүлэг 1

ХАРААТ БУС СУДАЛГАА 15 ЖИЛД 3

1	Өмнөх үг.....	4
2	Бидний тухай.....	6
3	Бидний үзүүлдэг үйлчилгээ.....	7
4	IRIM тоогоор.....	8
5	IRIM-ийг үүсгэн байгуулсан түүх.....	10
6	Үе үеийн Гүйцэтгэх удирдлагуудын дурсамжаас.....	11
7	IRIM-чуудын түүхээс.....	18
8	Он цагийн товчоо.....	21
9	Зургийн цомог.....	22

Бүлэг 2

IRIM 2022 ОНД 29

10	2022 онцлох мэдээ.....	30
11	IRIM-ийн брэнд төслүүд.....	35
	1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2022.....	35
	2. Монголчуудын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа 2022.....	38
12	Засаглал.....	41
	3. Монгол улс дахь иргэний орон зайн тэсвэртэй байдал: Цар тахлын сургамж.....	41
	4. Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа 2022.....	45
	5. “Залуучуудын дуу хоолой” Судалгаа.....	49
13	Тогтвортой байдал.....	52
	6. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголчуудын мэдлэг, хандлага, хэвлэл мэдээллийн хэрэглээний судалгаа.....	52
	7. Тойрог эдийн засаг ба бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ.....	56
	8. Олборлох үйлдвэрлэлийн салбарын олон нийтэд мэдээлэл түгээх, орон нутагтай хамтрах хүрээнд хийсэн болон хийж буй ажлуудын үнэлгээ.....	58
	9. “Австралийн Улаан Загалмайн Олон Улсын хөтөлбөр 2019-2024”-ийн дунд шатны үнэлгээ.....	60
	10. Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн COVID-19 цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээний үнэлгээ.....	62
	11. Монгол Улсын усан хангамжийн нийлүүлэлтийн Техник Эдийн Засгийн Үндэслэл.....	64
	12. “Миний Минийх” аяны хүрээнд хийгдэх контентын үр нөлөөг үнэлэх судалгаа.....	66

14	Боловсрол	69
	13. Улаанбаатар хотын эцэг, эх бага насны хүүхдүүдийн унших зан үйлийн судалгаа...	69
	14. “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх” төсөл	72
15	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээл	74
	15. Малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын талаарх зан үйлийн судалгаа	74
	16. Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын хүрээнд хэрэгжиж буй “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн зах зээлийн судалгаа”	77
	17. COVID-19-ийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хянах өрхийн утсан судалгаа	80
	18. “COVID-19 цар тахлын үеийн Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих нь” техникийн туслалцааны төсөл	83
	19. Жижиг Дунд Бизнесийн тогтвортой хөгжил, ил тод байдлыг сайжруулах (BEST) хөтөлбөрийн дунд шатны үнэлгээ	87
	20. Монголын хөдөө орон нутаг дахь хөдөлгөөнт эрүүл мэндийн үйлчилгээний үнэлгээ	90
16	Жендэр ба хөгжлийн бэрхшээл	92
	21. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн үнэлгээ	92
	22. Сүхбаатар аймаг дахь зөрчил, гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа	95
17	Бусад төслүүд	98
	23. “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежментэд нийгмийн шинжлэх ухааныг ашиглах нь” сургалт	98
	24. Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөл: Судалгааны арга зүйн сургалт	98
	25. Олон нийтийн санал бодлын судалгаа 2022	98
	26. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын 2021-2025 оны стратеги, төлөвлөлтөд хийсэн хүний эрхийн магадлан шинжилгээ	99
	27. Монгол Улсад цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын чадавхын хэрэгцээ тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулалт	99
	28. “Монгол ногоо” төслийн дунд шатны үнэлгээ	99

Бүлэг 1

ХАРААТ БУС СУДАЛГАА 15 ЖИЛД

- Өмнөх үг
- Бидний тухай
- Бидний үзүүлдэг үйлчилгээ
- IRIM тоогоор
- IRIM-ийг үүсгэн байгуулсан түүх
- Үе үеийн Гүйцэтгэх удирдлагуудын дурсамжаас
- IRIM-чуудын түүхээс
- Он цагийн товчоо
- Зургийн цомог

ӨМНӨХ ҮГ



Онц бөгөөд бүрэн эрхт элчин
сайд, IRIM-ийн Ерөнхийлөгч
Х.Бэхбат



Гүйцэтгэх захирал
Л.Цэлмэгсайхан

Анх 2008 онд эхэлсэн IRIM-ийн аялал 15 жилийн турш тасралтгүй үргэлжилж, өнөөдөртэй золгоод байна. Бид өөрийн эрхэм зорилгоо дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа, зөвлөх үйлчилгээг хүргэдэг Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болох хэмээн тодорхойлон ажиллаж ирлээ. Хөгжил, түүн дотроо засаглал, боловсрол, нийгмийн хамгаалал, тэгш хүртээмж, жендэр, тогтвортой хөгжлийн чиглэлд хоёр болон олон талт хөгжлийн түншүүд, төрийн байгууллага, иргэний нийгэм, орон нутгийн байгууллагуудтай хамтран **судалгаа, үнэлгээ, нөлөөллийн** төслүүдийг хэрэгжүүлж байна.

Өнөөдөр манай байгууллага 25 үндсэн ажилтан, 50 гаран зөвлөхтэйгөөр 100 гаруй түншүүдтэй хамтран 300 гаруй судалгаа, зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжүүлж, 21 аймгийн 330 гаруй суманд очиж, 210 мянга орчим иргэдтэй уулзаж санал, дуу хоолойг нь сонсож, шийдвэрт тусгахад хувь нэмэр оруулаад байна. Түүнчлэн Төв Ази, Зүүн өмнөд Азийн орнуудад өөрсдийн хуримтлуулсан туршлага, мэдлэгтээ тулгуурлан төсөл хэрэгжүүлээд байна.

Өнгөрөгч 2022 онд бид **COVID-19-ийн нийгмийн бүлгүүдэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн судалгааны ажилд төвлөрчээ.** Мөн Монгол Улсад иргэний орон зай, ардчиллыг хамгаалах чиглэлд багагүй хүчин чармайлт гаргаж, судалгаа, нөлөөллийн

төслүүд хэрэгжүүлээ. Уламжлалынхаа нэг хэсэг болсон, өөрсдийн санаачлан, санхүүжүүлэн хэрэгжүүлдэг "Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс", "Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа" зэрэг бие даасан брэнд судалгаагаа тасралтгүй хийсээр байна.

Өнгөрсөн 15 жилийн түүхээ эргэн харахад гурван үечлэлд хувааж болох юм. 2008-2012 оны эхний таван жилд хөл дээрээ тогтох, чадавхаа бэхжүүлэхэд анхаарч, 2013-2017 оны хоёрдугаар үе шатанд байгууллага илүү институтчилэгдэж, нийгэмдээ танигдаж, 2018-2023 оны сүүлийн таван жилд судалгааны хэрэглээ, үр нөлөөг нэмэгдүүлэх, бодлогод нөлөөлөх, бүс нутагтаа Монгол Улсын хөгжлийн туршлагаас хуваалцахад анхаарч байна.

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд хөгжилд оруулсан хувь нэмрээ дор онцолж байна.

Монголын нийгмийн бодит байдлын талаарх мэдлэгт нийгмийн өнцгөөс хувь нэмрээ оруулсаар байна. Нийгмийн эв нэгдэл, итгэлцэл нь үндэсний болон олон нийтийн түвшинд урт хугацааны хамтын ажиллагаа, тогтвортой хөгжлийг хангах гол түлхүүр гэдэгт бид итгэдэг. Тиймдээ ч Монголын нийгмийг судлах эдийн засаг, статистикийн судалгааны ажлууд ихээхэн хийгддэг өнөөгийн нөхцөлд бид нийгмийн судлагдаагүй, орхигдсон өөр өөр өнцгийг олж илрүүлэн, олон төрлийн онол, баримжаагаар

судлахыг зорьж байна. Энэ хүрээнд “Нийгмийн сайн сайхан байдал”-н асуудлыг Монголын онцлогт тохируулан анхлан судалж, олон нийтэд таниулж байна.

Нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад нөлөөлөн ажиллаж байна. Бидний гүйцэтгэсэн судалгаа, үнэлгээний үр дүнгүүд нь төрөөс хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн актууд болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийн талаарх хүн амын ойлголт, хандлага болон хүлээлтийг тодорхойлж байдаг. Үүний нэг тод илрэл нь сайн засаглалыг дэмжих зорилгоор 2010 оноос төрийн цахим ил тод байдлын индексийг (DTI) судлах стандарт аргачлал боловсруулан, үнэлж байна.

Ардчиллыг судлах, хамгаалах зорилгоор IRIM нь 2020 оны 10-р сард **Азийн Ардчиллын Судалгааны Сүлжээнд гишүүнээр элссэн.** Швейцарийн Дэлхийн Нийгмийн Сантай Нийгэмлэгтэй хамтран 2018 онд Ардчиллын олон улсын бага хурлыг Улаанбаатар хотдоо зохион байгуулж, 2022 онд “Ардчиллын тэмцэл, сорилтын жилүүдэд Монгол ба Дэлхийн Улс орнууд туршлагажиж эхэлсэн нь” нэрийн дор эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхэтгэн ном болгон хэвлүүлж, мэдлэг бүтээлцэж байна.

Үндэсний үнэлгээний тогтолцоог бий болгож, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд манлайллаа харуулсаар байна. 2015 онд “Үндэсний үнэлгээний хүрээ” санаачилгыг гаргаснаас хойш IRIM нь Ази Номхон далайн бүсийн үнэлгээний нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, Монгол Улс болон бүс нутгийн хэмжээнд үнэлгээний тогтолцоо, чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Түүнчлэн Монгол Улсын хөгжлийн салбарт чиглэн хэрэгжиж буй олон улсын байгууллагууд, улсын суурь салбарын стратеги боловсруулах, гүйцэтгэлийг үнэлэхэд гар бие оролцон ажиллахын сацуу тогтолцооны түвшинд нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын соёлыг бий болгох, аливаа үндэсний бодлого, хөтөлбөрүүдэд салбар дундын асуудлууд болох нас, жендэр, нийгмийн бүлэг зэргийг харгалзан үзсэн дүн шинжилгээ, төлөвлөлт, хяналт хийдэг жишгийг бий болгоход ихээхэн эрмэлзэн ажиллаж байна.

Хамтарсан, оролцсон, ажилласан бүх талуудад чадавх бэхжүүлэх идэвхтэй, тогтвортой тал байсаар ирлээ. Бидний гүйцэтгэсэн 300 орчим төсөл нь өнгөрсөн 15 жилийн хугацаанд

Монголд бий болсон аливаа өөрчлөлтийг тасралтгүй баримтжуулан, түүнийг илэрхийлэх нотолгоог бүрдүүлэх боломжийг бий болгосон. Үүнээс гадна, хамгийн чухал нь судалж, үнэлж буй аливаа ажлуудын хүрээнд тухайн салбар чиглэлд ажиллаж буй талуудыг илрүүлэх, дундын асуудлуудыг таниулах, хэлэлцүүлэх, холбох үүргийг амжилттай, үр дүнтэй гүйцэтгэж, оролцогч талуудын мэдлэг, чадавхыг тогтмол дээшлүүлж байна.

Монгол Улсаа бүс нутгийн болон олон улсын тавцанд төлөөлөн ажиллаж байна. Дэлхий дахины, бүс нутгийн түвшин дэх мэргэжлийн болон салбар чиглэлийн сүлжээ, холбоодод нэгдэн орж, идэвхтэй байр суурьтайгаар ажиллаж байна. Гишүүнчлэлээ идэвхтэй хадгалдгийн хувьд Монгол Улсаа болон ажиллаж буй салбараа төлөөлөн туршлага, байр суурийг илэрхийлэх, асуудал дэвшүүлэх, шийдлүүдийг хэлэлцүүлэх, тухайлсан асуудалд олон улсын анхаарлыг татах, хамтран ажиллах боломжийг нээхийг эрмэлзэн ажиллаж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед “Өөрчлөлтийн төлөөх инновац” (I4C) сүлжээний гишүүнчлэлээрээ дамжуулан Төв Азийн таван оронд иргэний орон зай, бүс нутгийн интеграцийг сайжруулах төслүүд хэрэгжүүллээ.

Цаашид ч хараат бус, бодит судалгаа мэдээллээр талуудыг хангах замаар шийдвэр гаргалтыг илүү оновчтой, хүртээмжтэй болгоход хувь нэмэр оруулж ажиллах болно. Монголын хөгжлийн асуудлаар хэн бүхэнтэй хамтарч ажиллах сонирхолтой чиглэлүүд:

- Монголын нийгмийн талаарх судалгааны санаачилгууд (Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа)
- Засаглал, боловсрол, тэгш хүртээмж, жендэр, уул уурхай, тогтвортой хөгжлийн салбар дахь бодлого, хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлэх
- Засаглалын асуудал цаашид ухрахаас сэргийлэх, Үр дүнд суурилсан менежмент, үндэсний үнэлгээний чадавхыг бэхжүүлэх, иргэний орон зай, ИНБ-ыг дэмжих чиглэлээр.
- COVID-19-ийн олон нийт, нийгмийн зорилтот бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах санаачилгууд

Цаашид, биднийг тодорхойлогч **Хараат бус, Чанар, Үр нөлөө** гэсэн үндсэн зарчмуудаа тууштай баримталж Монгол Улсын хөгжлийн асуудлаар дуу хоолойгоо хүргэсээр байх болно.

БИДНИЙ ТУХАЙ



ISO-оор баталгаажсан, хүний эрхийг дээдэлсэн, жендерийн мэдрэмжтэй хамт олон

IRIM судалгааны хүрээлэн нь 2008 онд дөрвөн хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааныхаа гарааг эхэлж байсан бол өдгөө 15 жилийн ойн босгон дээрээ нийт 25 үндсэн ажилтантай, 300 гаруй үндэсний болон олон улсын гэрээт зөвлөх, судлаачдын багтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Бид төслийн удирдлага, сургалт, судалгаа, үнэлгээний чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмрээ оруулахыг зорьж ажилладаг.

Энэ хугацаанд бид өөрийн орны онцлогийг тусгасан, үр дүнг чухалчилсан, үйлчлүүлэгч төвтэй төслийн менежментийн шийдлүүдийг санал болгохоос гадна нотолгоонд суурилсан **чанартай** мэдээлэл бий болгох, **хараат бус**, хөндлөнгийн байр суурийг хадгалах, нийгэмд үзүүлэх **үр нөлөөгөө** дээшлүүлэх зарчмыг үргэлж баримталсаар ирсэн. Уг зорилтынхоо хүрээнд олон улсын Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилладаг.

IRIM судалгааны хүрээлэн нь үүсгэн байгуулагдсан цагаасаа нийгмийн бүхий л салбарт жендерийн тэгш эрхийн зарчмыг хангуулахад өөрсдийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй судалгааны ажлуудаараа дамжуулан иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөл, дуу хоолой болохыг зорьж ирсэн. Улмаар байгууллагын дотоод соёл институтчилэл, менежментийн бүх түвшинд жендерийн эрх тэгш байдлыг хангах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллагын онцлогт тулгуурласан “Ажлын байрны бэлгийн дарамт, хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх бодлого”-ыг боловсруулан нэвтрүүлээд байна.

Үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлэх зорилгоор 2013 онд MIRIM Консалтант (Marketing and Innovation Research Institute of Mongolia) компанийг үүсгэн байгуулж маркетинг, инновацын судалгааны чиглэлээр мөн үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ Зүүн Өмнөд болон Төв Азийн улс орнуудад судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлэн олон улсад үйл ажиллагаагаа тэлсээр байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа, зөвлөх үйлчилгээ хүргэдэг Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болно.

ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

СУДАЛГАА: Бид нийгмийн тулгамдсан асуудлыг судлахдаа тоон болон чанарын судалгааны шинэлэг арга, аргачлалыг боловсруулж, мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын дэвшилтэт арга техникүүдийг тасралтгүй нэвтрүүлэхийг зорин ажилладаг. Бидний нийт хэрэгжүүлсэн төслийн 50 орчим хувийг судалгааны төслүүд эзэлдэг бөгөөд судалгаагаар дамжуулан нийгмийн олон талт бүлэгт хүрч, тэдний дуу хоолойг судалгаагаар дамжуулан төсөл, хөтөлбөр, төрийн шийдвэр гаргалтад хүргэхийг зорин ажиллаж байна. Энэ явцад бид судалгааны ёс зүй, нууцлал, олон талын байр суурь зэргийг харгалзан мэргэжлийн байдлаа тасралтгүй хадгалахад анхаарч ажиллаж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ: Хяналт шинжилгээ үнэлгээ нь бидний хамгийн чадавх бүхий, үндсэн үйлчилгээний нэг бөгөөд нийт хэрэгжүүлсэн төслийн 30 гаруй хувийг эзэлж байна. Бусад төслүүдээс ялгаатай нь ХШҮ-ний төслийг хэрэгжүүлэхэд хараат бус, хөндлөнгийн байр сууринаас, баримт нотолгоонд бүрэн суурилж, найдвартай, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт гаргахыг зорьж ажилладаг. Энэ хүрээнд IRIM судалгааны хүрээлэн мэргэжлийн үнэлгээчдийн 10 гаруй холбоо, сүлжээнд идэвхтэй гишүүнчлэлтэй байж, хамтын ажиллагаа, сүлжээгээр дамжуулан баг, мэргэжилтнүүдийнхээ ХШҮ-ний чадавхыг тасралтгүй сайжруулсаар байна.

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ: Бид мэргэжлийн судалгаа, үнэлгээний ажлаас гадна байгууллага, төсөл хөтөлбөр болон бодлогын түвшний ажлуудад зөвлөх үйлчилгээг үзүүлдэг ба манай үйлчилгээний 10 орчим хувийг эзэлдэг. Зөвлөх үйлчилгээгээр дамжуулан хувь хүн, байгууллагыг чадавхжуулахаас эхлээд, олон улсын хөгжлийн хөтөлбөр болон төрийн байгууллагын шийдвэр гаргагчдад нөлөөлөх бодлогын түвшинд хүртэл өргөн хүрээнд хүрч ажилладаг. Зөвлөх үйлчилгээг хүргэхдээ баримт нотолгоонд суурилдаг нь илүү үр нөлөөтэй шийдвэрүүдийг гаргах, бодлого хөтөлбөр хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Бид зөвхөн захиалгат үйлчилгээг хүргэхээс илүүтэй нийгмийн хариуцлагын хүрээнд ТББ-ыг чадавхжуулах, эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг мөн хэрэгжүүлдэг.

СУРГАЛТ: Бид өөрсдийн үйл ажиллагаа, мэдлэг туршлагадаа тулгуурлан харилцагч, захиалагч байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих болон сайжруулахад чиглэсэн сургалтын үйлчилгээг үзүүлж байна.

Сургалт, чадавх бэхжүүлэх төслүүд нь манай үйлчилгээний 10 гаруй хувийг эзэлдэг. Бид сургалтын хөтөлбөр, концепцийг харилцагч бүрийн хэрэгцээ, зорилгод нийцүүлэн боловсруулдаг тул сургалтын үр дүн, өгөөж, оролцогчдын сэтгэл ханамжийг тогтмол өндөр түвшинд хангаж чаддаг. Өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан харилцагч хамтрагч байгууллагуудын судалгааны ур чадвар, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

ТУРШЛАГА:

141 төсөл

- Бодлогын судалгаа
- Санал бодлын судалгаа
- Нийгэм-эдийн засгийн судалгаа
- Сэдэвчилсэн судалгаа
- Мэдлэг хандлага, дадлын судалгаа
- Үйлд суурилсан судалгаа

105 төсөл

- Мониторинг
- Үр нөлөөний үнэлгээ
- Үнэлэгдэхүйц байдлын үнэлгээ
- Түргэвчилсэн үнэлгээ
- Нэгтгэн дүгнэх үнэлгээ


36 төсөл

- Нөлөөллийн ажил
- Хэлэлцүүлэг зохион байгуулах
- Контент бүтээх

23 төсөл




- Судалгаа, үнэлгээний арга зүй,
- Тоон болон чанарын шинжилгээний програм хангамжийг ашиглах,
- Төсөл бичих, боловсруулах арга зүй, аргачлал

IRIM ТООГООР



2008 ОНЫ
4 сар

2023 ОНЫ
4 сар



214,635
Респондент



103
Захиалагч



159
Хамтрагч

ГАЗАР ЗҮЙН ТУРШЛАГА

Хэрэгжүүлсэн төслийн тоо

ТӨВ АЗИ

- 2 Афганистан
- 2 Казакстан
- 2 Киргизстан
- 1 Пакистан
- 2 Тажикистан
- 1 Туркменистан
- 1 Узбекистан


МОНГОЛ

- | | |
|---------------|-----------------|
| 46 Архангай | 65 Өмнөговь |
| 40 Баян-Өлгий | 53 Өвөрхангай |
| 55 Баянхонгор | 49 Увс |
| 31 Булган | 38 Сүхбаатар |
| 49 Говь-Алтай | 53 Сэлэнгэ |
| 30 Говьсүмбэр | 47 Төв |
| 55 Дархан-Уул | 67 Ховд |
| 52 Дорнод | 57 Хөвсгөл |
| 45 Дорноговь | 47 Хэнтий |
| 39 Завхан | 203 Улаанбаатар |
| 49 Орхон | |

ЗҮҮН ӨМНӨД АЗИ

- 1 БНХАУ-ын Эрээн хот
- 1 Зүүн-Тимор
- 1 Бангладеш

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД



- Олон улсын байгууллага
- Төрийн байгууллага
- Төрийн бус байгууллага
- Бусад

Олон улсын байгууллага



Төрийн байгууллага



Академик байгууллага



БИДНИЙ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ БА ГИШҮҮНЧЛЭЛ



Ази номхон далайн улс орнуудын “Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээ” байгууллагын гишүүнээр 2010 оноос хойш ажиллаж байна.



Олон Улсын Социологичдын Холбоонд (ISA) 2010 оноос эхлэн Монгол Улсаас албан ёсны гишүүн бөгөөд тус байгууллагаас батлан гаргасан “Ёс зүйн дүрэм”-ийг чанд сахин ажилладаг.



IRIM нь Монголын үнэлгээний сүлжээг байгуулах санаачилгыг эхлүүлсэн бөгөөд энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус, ОУ-ын байгууллагын мэргэжилтэн, зөвлөхүүдийг эгнээндээ нэгтгэсэн. Одоогоор сүлжээний гишүүдтэйгээ хамтран Үндэсний үнэлгээний стандартыг Монголдоо нэвтрүүлэн ажиллаж байна.



2016 оны 8 сард “Ази-Номхон далайн Үнэлгээний Холбоо”-нд албан ёсоор нэгдэн орсон Монголын анхны байгууллага юм. Мөн 2017 оноос тус холбооны ТУЗ-ийн гишүүн байгууллагаар сонгогдон ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэн нь 2016 оноос “Сайн сайхан байдлын судалгаа”-г жил бүр санаачлан хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сард “Азийн Субъектив сайн сайхан байдлын олон улсын консорциумд”-д Монгол Улсыг төлөөлөн гишүүнээр нэгдэн орсон.



Монгол Улсын Жендерийн Үндэсний Хорооны орон тооны гишүүнээр 2017 оноос ажиллаж байна. Энэ хүрээнд нийгмийн бүхий л салбарт жендерийн тэгш эрхийг хангуулах, төрийн бодлогод жендерийн тэгш эрхийн зарчмыг хангуулах тал дээр иргэний нийгэм, хувийн хэвшлийг төлөөлөн ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэн 2018 оноос Innovation for Change Төв Азийн бүс нутгийн сүлжээнд нэгдэн орсон бөгөөд мөн тус онд ТУЗ-ийн гишүүн байгууллагаар сонгогдсон. Одоогоор иргэний нийгмийн байгууллагуудын эрхийг хамгаалах, түүнд тулгарч буй бэрхшээлийг даван туулах арга замыг бий болгох зорилго дор сүлжээний гишүүдтэй хамтран ажиллаж байна.



IRIM судалгааны хүрээлэн нь Give2Asia олон улсын хандивын сүлжээнд 2019 онд гишүүнээр элссэн. Тус сүлжээ нь Азийн хөгжиж буй улс орнуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой орон нутгийн иргэдийн төсөл, хөтөлбөрийг дэмжих хөрөнгө босгох чиглэлээр үйл ажиллагаагаа Азийн 23 оронд явуулдаг АНУ-д төвтэй ашгийн бус байгууллага юм. Уг сүлжээнд нэгдсэнээр бид Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн төслүүдийг санаачлан, хэрэгжүүлж байна.



IRIM судалгааны хүрээлэн Азийн ардчиллын судалгааны сүлжээнд 2020 онд гишүүнээр элссэн. Уг сүлжээ нь 2013 онд байгуулагдсан бөгөөд Ази тивд ардчилсан засаглал, хүний эрхийг дэмжих чиглэлд судалгаа, шинжилгээ хийдэг байгууллага юм. Өдгөө 14 орны голлох 21 think thank-ууд гишүүнчлэлтэй, Азийн Барометрийн судалгаагаараа олон улсад танигдсан байдаг.



Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институтын 11 гишүүн орны нэг нь Монгол Улс бөгөөд IRIM судалгааны хүрээлэн 2022 онд гишүүнээр элссэн. Тус институт нь Төв Азийн орнууд болон хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагаагаар дамжуулан хөгжлийг дэмжин, эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, ядуурлыг бууруулах чиглэлд үйл ажиллагаа явуулдаг.

IRIM-ИЙГ ҮҮСГЭН БАЙГУУЛСАН ТҮҮХ



Ч.Тамир

*IRIM судалгааны хүрээлэнгийн
Удирдах Зөвлөлийн Дарга бөгөөд
үүсгэн байгуулагчдын нэг.
1999 оноос эхлэн эрдэм шинжилгээ,
зөвлөх үйлчилгээний салбарт
тасралтгүй ажиллаж байна.*

Хараат бус судалгааны үр дүн, зөвлөх үйлчилгээ нь шинэ мэдлэгийг бүтээх бий болгох, төр засгийн шийдвэр гаргалтад туйлын чухал байдаг ч тухайн үед манайд энэ чиглэлээр ажилладаг байгууллага цөөн байв. Тиймээс анх судалгаа хийдэг төрийн бус байгууллага байгуулсан ч, Монголд ТББ-ын үйл ажиллагааг тогтвортой авч явах хөрөнгө, хүний нөөцийг урт хугацаанд ажиллуулахад хангалтгүй юм байна гэж үзээд компани ба ТББ хоёуланг нь байгуулж байсан. Насны хувьд ахмад, идэр залуу гэсэн туршлага мэдлэгтэй ба хүч энерги, эрмэлзэлтэй, хүмүүсээс багаа бүрдүүлж ажиллаж эхэлсэн.

Анх байгуулахдаа социологи, нийгмийн ухааны салбараар төгсөж байгаа оюутнууд нийгмийн салбарт бие даан судалгаа үнэлгээ хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэргээр сурсан мэдсэн зүйлээ ашиглаж өөрсдөө баялаг бүтээж, мэдлэгийг бий болгож, тэр туршлагаараа шат ахиж дэвшиж байх судлаачийн карьерын тогтолцоог бий болгохыг зорьсноороо онцлог. Ингээд Монголд бий болгосон салбарын мэдлэг, туршлагаа олон улсад танилцуулан экспортлох мэдлэгийн төв болон хөгжих замын зураг удалгүй бий болсон.

Одоо IRIM нь дээр дурдсан зүйлсийг тодорхой хэмжээгээр бүтээж, тодорхой шатанд гарч, бүх талуудад танигдсан чухамдаа олон улсын талбарт өрсөлдөх бэлтгэлээ хангаж байгааг дурдахад сайхан байна.



IRIM-ийн үе үеийн Гүйцэтгэх захирлууд Социологи, нийгмийн ажлын тэнхим үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн үеэр, 2021 он

ҮЕ ҮЕИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГУУДЫН ДУРСАМЖААС



Г. Цогтбаатар

IRIM судалгааны хүрээлэнгийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 2008 онд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

Одоо Австралийн Засгийн газрын тэтгэлгээр Мельбурнийн Их сургуульд суралцаж байна.

БИЕ ДААСАН БАЙХ ГЭДЭГ УТГААРАА ЗАХ ЗЭЭЛД БАЙР СУУРИА ТОГТВОРЖУУЛАХ НЬ ЧУХАЛ БАЙСАН

Миний хувьд IRIM-ийн эхний хоёр жил орчимд Гүйцэтгэх захирлаар ажилласан. Их сургуулиа төгсөөд дөнгөж нэг жил ажилласан туршлагатай байхдаа энэ байгууллагыг үүсгэн байгуулахад гар бие оролцоод удирдлагын үүргийг хүлээн авсан. Их сургуулийн багш нар болох Ц.Болд, Ч.Тамир болон ангийн анд З.Зоригтсайхан нартай хамтраад 2008 оны 4 сарын 4-нд IRIM-аа байгуулж байлаа. Тухайн үед би Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны албанд ахлах судлаачаар ажиллаж байсан ч мэргэжлээрээ судалгааны шинэ компани үүсгэн байгуулж, хамтран ажиллах саналыг нь талархан хүлээн авсан.

Үүсгэн байгуулагдаад удаагүй байсан болохоор байгууллага ажиллуулахтай холбоотой бүх төрлийн ажлыг анхнаас нь гар бие оролцох хэрэгтэй байлаа. Байгууллагын нэр, лого, анхны оффисын түрээс, ширээ сандал, брошюр, веб сайт, анхны ажилтнууд, анхны төслүүд гэх мэт бүх зүйлд өөрийн туршлага, холбоо сүлбээ, анги хамт олноо дайчилж байлаа.

Жишээ нь, байгууллагын нэр сонгох "Independent Research Institute of Mongolia" – гэдгээс Хараат бус, Бие даасан судалгааны байгууллага гэсэн утгатай. Энэ утгаараа аль нэг нам, улс төрийн

бүлгээс хамааралгүй цэвэр мэргэжлийн байх, нөгөөтээгүүр "Бие даасан" байх гэдэг утгаараа байгууллага өөрөө тодорхой зах зээлийн туршлага авч, санхүү болоод эд материалын хувьд хөл дээрээ бэхжих, байнгын буюу тогтмол үйл ажиллагаатай болох нь чухал байсан. Тиймээс ямартай ч байнгын ажилтай байлгахын тулд бүх л судалгааг хийнэ гээд л гүйнэ. Байгууллагын туршлагагүй тул бага зардалтай, их ажилтай төслүүд л олддог байлаа. Маш олон төсөлтэй тул харих завгүй ажилладаг байсан. Зоригоо бид хоёр бол сонин дэвсээд ажил дээрээ хонодог үе зөндөө. Цалинтай, цалингүй дэмжих хүмүүс хэрэгтэй учраас хамгийн анх ангийнхныгаа цуглуулаад ажилладаг байжээ.

Удирдлагаар ажиллаж байх үеийн ололт, дэвшлийг гурван зүйлээр тодорхойлж болох юм. Эхлэх нь ажлын тал нь гэдэг шүү дээ. Тиймээс байгууллагаа үүсгэн байгуулсан нь том алхам. Үүний дараа байгууллага гэдэг анхны хэлбэрээ олж, тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн туршлага, хүний нөөц, материаллаг баазын суурийг тавьсан. Мөн бид энэ маягаар дуртай ажлаа бизнес болгож болох юм байна гэсэн итгэлийг олж авсан нь хамгийн чухал ололт байсан гэж бодож байна.



Ц. Болд

IRIM судалгааны хүрээлэнгийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 2009-2010 оны хооронд Гүйцэтгэх захирлын албыг хашиж байсан.

Одоо IRIM судалгааны хүрээлэнгийн ТУЗ-ийн гишүүн, МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимд багшаар ажиллаж байна.

САЛБАРТАА ТАНИГДАХ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ НЬ ГОЛ ЗОРИЛТ БАЙЛАА

Анх байгуулагдсанаас хойш 8 сарын дараа Гүйцэтгэх захирлын ажлыг шахалтаар авч байлаа. Захирлаас гадна гуравхан судлаачтай, хийж гүйцэтгэсэн ажлын туршлага, түүх байхгүй байгууллагын хувьд бусдад танигдах, хүлээн зөвшөөрөгдөх нь том сорилт байсан. Эргэн тойрны хүмүүс, хамтран ажиллагчид нүүрэн дээр шоолдог, басамжилдаг, илтэд үл тоодог байв. 12м.кв түрээсийн жижигхэн өрөөнд багтаж ядан эхэлсэн.

Социологич мэргэжлээр олон мэргэжилтэн бэлтгэж төгсгөдөг, төгссөн мэргэжилтнүүд мэргэжлээрээ ажиллаж, сонирхолтой дуртай ажлаа хийж болдог гэдгийг үзүүлье гэж зориглосон. Улс төрөөс хараат бус, санхүүгийн хувьд бие даасан, хүссэн сонирхсон чиглэлээрээ дуртай судалгаагаа хийх боломжийг бүрдүүлэхийг зорьсон. Зорилгоо биелүүлэх гэж одоо ч хичээж ажиллаж байна.

Юун түрүүнд, төгсөгчдийнхөө итгэлийг төрүүлж, хамтран ажиллах судлаачдаар эгнээгээ бэхжүүлэх, урт хугацаанд ойлголцож тогтвортой ажиллах бүтцийг бий болгож шаардлагатай байсан. Түүний эхлэлийг тавьсан. Судлаачдынхаа тоог нэмэхийн тулд байрны багтаамжаа нэмэгдүүлэх, тэр хэрээр гарах зардлаа санхүүжүүлж чадах хэрэгтэй болсон. Шинэ үүссэн байгууллагын өсөлтийн бэрхшээл бүгд л тулгарч байлаа.

Салбартаа танигдах, хүлээн зөвшөөрөгдөх нь хамгийн гол бэрхшээл байсан. Үүний тулд байгууллагаараа тогтвортой 2-3 жил ажилласан туршлага, түүх үүсгэх хэрэгтэй байв. Байгууллагын хувьд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль дүрмийн хүрээнд шударгаар ажиллах, санхүүгийн тайлан гаргадаг, НӨАТ төлөгч, судлаачдын НДШ, ХХОАТ-ыг төлдөг байгууллага болгож институтийн хувьд бэхжүүлэх зорилтыг тухайн үед шийдвэрлэсэн.

Олон улсын байгууллагуудын шаардлагад нийцэхүйц төслийн санал боловсруулж, хүлээн зөвшөөрөгдөхийн тулд зүтгэцгээсэн, хамтрагчидтайгаа гар нийлж, тэдэнд итгэснээр болохгүй зүйл байхгүйг нотолцгоосон. Одоо олон улсын зөвлөх байгууллагуудтай өрсөлдөж, Монголд хийгдэж буй томоохон төслүүдийг гүйцэтгэх чадавхыг бэхжүүлэх, судлаач, мэргэжилтэн, зөвлөхүүдийн шилдэг баг бүрдүүлэхийг хүсдэг.

Шилдэг мэргэжилтнүүдийн багаар мэдлэг бүтээх, мэдлэгийн төв үүсгэх, хараат бус судалгааны үр дүнд бодлогын шийдлүүдийг санал болгож, хөгжилд өөрсдийн боломжоор нөлөөлөхийг бид эрхэм зорилгоо болгосон, үүнийхээ төлөө ажилласаар байна.



М.Ариунтунгалаг

2008 оноос IRIM судалгааны хүрээлэнд судлаачаар ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2010-2011 оны хооронд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Одоо Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллагад Ази номхон далайн бүсийн төсөл хөгжүүлэх багийн зөвлөхөөр ажиллаж байна.

УУЛЗАЛТЫГ ХЭН МЭДЭЭЛЭЛТЭЙ НЬ УДИРДДАГ

IRIM судалгааны хүрээлэн нь 2010-2011 оны үед 12-13 ажилтантай, байгууллагын танилцуулга, лого, байгууллагын туршлага зэрэг нь тодорхой хэмжээнд бэлтгэгдчихсэн байсан. Тухайн үед Гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа байгууллагын гадаад харилцаанд илүү анхаарч, мэргэжлийн гэж нэрлэгдэх байр сууринд аваачихыг хүссэн. Тиймдээ ч Олон Улсын Социологичдын Холбоонд албан ёсны гишүүнчлэлтэй болсон, Australian Volunteers хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн, нийгмийн хариуцлагын талаарх ойлголтыг Монголын хөрсөнд нутагшуулах, хөрвүүлэх төсөл болон төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс хийж эхэлсэн зэрэг ач холбогдолтой олон ажлын эхлэл тавигдаж байжээ. Институтийн хувьд том төслүүд рүү (Мянганы сорилтын сан, Азийн хөгжлийн банк) өөрсдийгөө сорьж үзэх зорилготойгоор байгууллагаа бэлдэх дээр нэлээдгүй анхаарч ажилласан. Учир нь урт хугацаанд хэрэгжих төслүүд нь олон төрлийн туршлага, сургамжийг олж авах боломжийг бүрдүүлж өгсөн гэж боддог. Олон төсөл зэрэг хэрэгжих үед бүх төслийн мэдээллийг төдийлөн сайн мэдэхгүй байх тохиолдол байдаг. Тэр үед Болд багшийн “Мэдээлэлтэй хүн уулзалтыг

удирддаг” гэж хэлсэн үгийг одоо ч гэсэн уулзалтад орохдоо санадаг. Эргээд бодоход Болд, Тамир хоёр багш маань юу хийхийг заадаггүй ч гэсэн одоогийн хэлдгээр миний хувьд сайн ментор байсан санагддаг.

Онцлууштай зүйл нь IRIM-ийн “мэргэжлийн байх” зарчим нь эхлэлээсээ надад таалагддаг байсан. Энэ зарчмыг ямар ч цаг үед алддаггүй. Тухайн үед иргэний нийгмийн байгууллагууд одоогийнхтой харьцуулахад хангалттай мэргэжлийн байгаагүй. IRIM энэ орон зайд дата, нотолгоо, баримтад суурилан бодлогын нөлөөлөл хийх боломжтойгоор шинэ өнгө нэмж чадсан. Хараат бус судалгааны хүрээлэн (Independent Research Institute of Mongolia) гэх нэрийг сонсох үед хараат бус байдлыг олж хардаг байгаасай гэж хүссэн. Энэ мэргэжлийн бөгөөд нотолгоонд суурилсан, хараат бус байгаа байдлаа одоог хүртэл хэвээр хадгалж байгаа нь их бахархуштай. Хамтарч ажиллаж буй байгууллагууд ч чанартай судалгаа хийдэг, хийнэ гэсэн хүлээлттэй байдаг. Энэ үнэт зүйлийг би өвөлж авсан, өвлүүлж өгсөн. Үүнийг брэнд болгохыг ажиллаж байх хугацаандаа зорьж байсан.



Л. ЦЭЛМЭГСАЙХАН

2009 оноос IRIM судалгааны хүрээлэнд анх судлаачаар ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2011-2012 онд Гүйцэтгэх захирлаар ажилласан.

ЖИЖИГ БАЙГУУЛЛАГЫН ХУВД ЗАХИАЛАГЧИЙН ШААРДЛАГА ӨНДӨРТЭЙ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭ ИХТЭЙ ТӨСӨЛД ХҮЧЭЭ ҮЗЭХ, ТУРШЛАГА ХУРИМТЛУУЛАХ НЬ ЧУХАЛ БАЙСАН

МУИС-ийн Социологийн ангийг 2009 онд төгсөөд, эзэмшсэн шинэ тутам мэргэжлээрээ ажиллахаар шийдэж, ангийнхаа таван хүүхдийн хамт тухайн үед дөнгөж байгуулагдаад байсан IRIM-д ажлын гараагаа эхлүүлж байлаа. Ажлын талбарт гарсан эхний жилүүдийг эргээд харвал, бие биедээ хань болж, шинэ байгууллагын уур амьсгал, соёлыг хамтдаа бүтээлцсэн он жилүүд байсан гэж боддог. Байгууллагадаа ажиллаад дөнгөж 2 жил гаран болж байхад Гүйцэтгэх захирлаар ажиллах санал гэх үү, даалгавар гэх үү үүргийг ТУЗ-өөс өгч, 2011 оны 9 сард ажил хүлээж авч байсан. Тухайн үед IRIM маань байгуулагдаад дөнгөж 3 жил болж байсан учир сайн албажаагүй, үндсэн хүний нөөц цөөнтэй, төслөөс төсөлд чадавхаа бэхжүүлж байсан. Ажил аваад, хоёр зүйл дээр голлон төвлөрч ажиллаж дээ гэж одоо боддог юм.

Нэгдүгээрт байгууллагын үйл ажиллагааг илүү албажуулахад анхаарсан. Анхлан албан хэрэг хөтлөх заавар гэгчийг боловсруулж, түүний дагуу тогтоол, тушаал, журам, гэрээ, ирсэн явсан бичгийн бүрдэл, хөтлөлтийг нэвтрүүлж, цэгцэлсэн. Түүнчлэн “Гүйцэтгэх захирлын Даваа гаригийн захиа”, бүх судлаачдын “Өргөтгөсөн хурал” гэх мэт одоог хүртэл байгууллагад маань институтчилэгдэж үлдсэн, төлөвлөлт, мэдээлэл урсгалын механизмуудыг санаачилж эхлүүлж байлаа.

Хоёрдугаарт, жижиг байгууллагын хувьд чадавх бэхжүүлэхэд захиалагчийн шаардлага өндөртэй, үйл ажиллагааны цар хүрээ, төсөв сайтай төслүүдийг хэрэгжүүлэх явдал чухал байсан. Тиймээс тухайн үед томоохон төсөл босгохын төлөө үүсгэн

байгуулагчид маань гүйцэтгэх багтай маш ойр ажилладаг байсан. Түүний хүчинд 2011 оны намар Азийн хөгжлийн банк, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны захиалгатай 3 аймгийн 33,000 өрхөөр нэг бүрчлэн зочилж мэдээлэл цуглуулах, өрхийн амьжиргааны мэдээллийн сан бүрдүүлэх том төсөлд шалгарч чадсан. Төсөл босох нэг хэрэг, амжилттай хэрэгжүүлж дуусгана гэдэг тун чухал байсан. Чанар өөрөө байгууллагын цорын ганц маркетинг байсан учраас. Уг төслийг хэрэгжүүлэхийн тулд Улаанбаатар хотоос хоёр фургон машинтай, 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгууд руу 2012 оны 1 сард идэр эс эхэлсэн өвөл гараад, 7 сарын эхэн наадмын өмнөхөн төслөө дуусгаад орж ирж байсан. Хотдоо үндсэн нэг, хөдөө явуулын нэг оффистой болсон байсан даа. Энэ төслөөр дамжуулан томоохон хэмжээний мэдээлэл цуглуулалтыг удирдах арга зүй, хөдөө орон нутгийн иргэд, төрийн байгууллагатай ажиллах ур дүй, олон улсын захиалагчид тайлагнах, өгөгдлийн сан үүсгэх, чанарын хяналт хийх зэрэг олон чухал чадавхад суралцаж, материаллаг баазын хувьд ч байгууллага маань нэг шат ахисан байдаг. Бас нэг онцлох зүйл нь, энэ төсөлд ажилласан баг маань тухайн үедээ бүгдээрээ 25 нас ч хүрээгүй, голдуу 2009, 2010, 2011 оны төгсөгчид байсан. Хэдий залуу, ажлын туршлага бага ч, багийн сэтгэл зүй сайтай, ажлынхаа чанарыг нэгт тавьдаг, тулгарсан асуудалд бүтээлчээр шийдэл гаргах гэж эрмэлздэг байсан. Эдгээр эерэг хандлага, суралцагч чанар одоо ч IRIM-ийн маань онцлох давуу тал байдаг.



А. Долгион

2009 оноос IRIM судалгааны хүрээлэнд судлаач, төслийн менежерээр ажлын гараагаа эхэлж, 2012-2017 оны хооронд Гүйцэтгэх захирлын албыг хашиж байсан. 2018 оноос төслийн зөвлөх, удирдах зөвлөлийн гадаад харилцаа хариуцсан гишүүнээр ажиллаж байна.

ЯМАР Ч ЖИЖИГ АЖИЛ БАЙСАН ТУХАЙН АЖИЛД БҮРЭН ЧАДАВХАА ДАЙЧИЛЖ, ХИЙЖ БУЙ АЖЛЫНХАА УТГА УЧРЫГ САНАЖ БАЙХ СОЁЛЫГ БИЙ БОЛГОХЫГ ЗОРЬСОН

Анх 2009 оноос эхлэн өнөөг хүртэл IRIM судалгааны хүрээлэнд ажиллаж байна. 2012 оны 11 сараас эхлэн нийт 5 жилийн хугацаанд Гүйцэтгэх захирлаар ажилласан. Анх Гүйцэтгэх захирлын албыг авахад байгууллага ерөнхийдөө жижиг, хүний нөөцийн хувьд үндсэн 6 ажилтан бусад нь гэрээт ажилтанууд байсан. Салбартаа тодорхой хэмжээнд танигдсан, голдуу Монгол хэл дээр, богино хугацааны судалгааны ажлууд хийдэг байв. Гэсэн хэдий ч засаглалын хувьд дараагийн шатанд хүрэх бэлтгэл хангагдсан байсан.

Миний хувьд байгууллагыг тогтвортой хөгжүүлэхэд 3 зүйл дээр илүү төвлөрч ажилласан.

Чанар: IRIM-д чанарын хяналтыг тогтолцоог бий болгосон. Энэ нь эхний үед үндсэн үйл ажиллагаа болох мэдээлэл цуглуулалт, шинжилгээний чанарын хяналтыг сайжруулахаас эхэлсэн. Мөн судалгааг зах зээлд эзлэх байр суурь гэж хардаггүй байсан тул судалгаа яагаад чухал вэ гэдгийг олонд таниулах, үндсэн голлох сэдвүүдээрээ мэргэшсэн байгууллага болохыг зорьсон. Судалгаа, үнэлгээ нь нийгмийн тулгамдсан, эрэлт хэрэгцээтэй асуудлыг хөнддөг, үр дүнд суурилж томоохон төсөл хөтөлбөрүүд ажлаа төлөвлөдөг учир хэрэгжүүлсэн төсөл бүр маш хариуцлагатай, чанартай байх ёстой. Тиймээс ямар ч жижиг ажил байсан тухайн ажилд бүрэн чадавхаа дайчилж ажиллах ёстой гэх, хийж буй ажлынхаа утга учрыг санаж байх соёлыг бий болгохыг зорьсон.

Гадаад харилцаа: Бидний үндсэн зорилго хөгжлийн талаарх мэдлэгийн төв болох байсан учраас олон улсын мэргэжлийн холбоодод нэгдэх, олон улсын байгууллагууд, дотоодын ИНБ, төрийн олон төрлийн байгууллагатай хамтрах, салбарын чадварлаг зөвлөх, мэргэжилтнүүдтэй ажиллахад анхаарлаа төвлөрүүлсэн.

Дотоод засаглалыг бэхжүүлэх: Жижиг байгууллагаас дунд хэмжээний байгууллага болж өргөжсөн тул байгууллагын бүхий л тал болох хүний нөөц, санхүү, үйл ажиллагаа, чанарын хяналт, төсөл хөгжүүлэлт, ХАБЭА зэргийг бэхжүүлэх, шинэчлэх ажлыг ТУЗ-тэй хамтарч хийсэн. Хараат бус байхын нэг суурь нь санхүүгийн хувьд бэхжих явдал байдаг тул тодорхой хэмжээнд бэхжүүлэхэд анхаарч, мөн чанарын удирдлагын тогтолцоо буюу ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.

Бидний үнэт зүйл болох хараат бус байх зарчмыг хангахын тулд өөрсдийн тогтсон хоёр ч судалгааг хийдэг. Үүнд жил бүр хийдэг “Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс”-ээс гадна “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-г мөн эхлүүлж байв.

Нийгмийн болоод хөгжлийн судалгаагаар дагнасан, аль нэг улс төрийн нам, байгууллагаас хараат бус, дотоод засаглал, ардчилал сайтай гэдгээрээ бусад судалгааны байгууллагаас онцлогтой гэж боддог. Сонирхолтой нэг мэдээлэл дурдахад 2015 онд хийгдсэн Монгол дахь судалгааны төрийн болон төрийн бус судалгааны байгууллагуудыг олон төрлийн индикаторуудаар хэмжсэн хөндлөнгийн үнэлгээгээр IRIM хамгийн өндөр үнэлгээтэй буюу нэгт жагссан байдаг.

Сүүлийн үед Монгол дахь ардчиллын нөхцөл байдал дордож, иргэдийн дуу хоолой, байр суурийг сонсох, бодлого шийдвэрт тусгах байдал буурч байна. Ийм нөхцөлд манай байгууллага иргэдийн дуу хоолойг судалгаагаар дамжуулан нийтэд хүргэх, хөндлөнгийн үнэлгээ хийх ажлаа үргэлжлүүлэн идэвхтэй хийсээр байна.



Ц. Батсугар

2011 оноос IRIM судалгааны хүрээлэнд судлаач, төслийн менежерээр ажлын гараагаа эхэлж, 2018-2019 оны хооронд Гүйцэтгэх захирлын албыг хашиж байсан. 2022 оноос төсөл хөгжлийн зөвлөхөөр ажиллаж байна.

ҮР НӨЛӨӨ ГЭДЭГ БОЛ БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

2015-2017 онуудад IRIM-ийн үйл ажиллагаа, үзүүл буй үйлчилгээ, хүний нөөцийн хувьд тогтворжиж, зөвлөх болон гэрээт судлаачдын мэргэжилтний нөөц ихээхэн өргөжиж тэлсэн. Үүнийг дагаад тодорхой институтчиллийг бэхжүүлэх, дүрэм журам, стандарт, чанарын шаардлага зэргийг ахисан түвшинд нэвтрүүлэх шаардлагатай болсон. 2016 оноос ISO стандарт нэвтрүүлэхтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэх стандарт, бодлого нь эрчимтэй боловсруулагдаж институтийн түвшинд хөгжиж, төлөвшиж эхэлсэн жилүүд юм. Мөн тодорхой хэмжээнд ОУ-ын зарлагдсан төслүүдэд бие дааж болон хамтран оролцох нь нэмэгдсэн гэх мэт олон динамик өөрчлөлтүүд гарч эхэлсэн. 2018-2019 онд захирлаар ажиллаж байх хугацаанд эдгээр шилжилтүүдийг цааш нь үргэлжлүүлэх бэхжүүлэх шаардлага зайлшгүй тулгарсан ч нөгөөтээгүүр 2017-2018 онууд зах зээлийн хувьд хямралтай жилүүд байсан. Тэр утгаараа өргөжин тэлж буй үйл ажиллагаагаа хадгалж үлдэх, үүнийг үргэлжлүүлэх, төлөвшүүлэн бэхжүүлэх нь гол даалгавар байсан.

Стратегиа тав таван жилээр төлөвлөж явдаг байгууллагын хувьд зорилт, чиглэл, хүрэх үр дүнгүүд харьцангуй тодорхой учраас нөөц бололцоогоо төлөвлөн ажиллахад үр дүнтэй байсан. Бид урт хугацаандаа дотоодын зах зээлд буюу үйл ажиллагаа явуулж буй салбартаа тэргүүлэгч болох, IRIM-ийг ОУ-ын түвшинд үйл ажиллагаа явуулдаг болох, Монгол мэргэжилтнүүдийг ОУ-ын түвшинд гаргах зорилт, мөрөөдлийг дотооддоо ярилцаж үүнийгээ стратеги дээрээ алхам алхмаар тусгаад явдаг. Монгол мэргэжилтнүүдийг ОУ-д гарах гүүр нь болох зорилтыг хангахын тулд нэн тэргүүнд боловсон хүчний туршлага, мэдлэг, чадварыг сайжруулах олон улсын туршлага мэдлэгтэй болгох, хувь хүний түвшинд карьерын өсөлтөө хол түвшинд харж чаддаг байх нь эргээд IRIM

болон мэргэжилтнүүдийн хувьд хамтын ажиллагааны гол итгэлцэл бат суурь нь зорилготойгоор ажиллаж байсан.

Гүйцэтгэх захирлаар ажиллаж байх хугацаанд гадаад харилцаа хамтын ажиллагаа өргөжсөн. Зүүн Ази, Зүүн Өмнөд, Төв Азийн орнуудын байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, тинк танк, судалгааны хүрээлэнгүүд олон төрлийн байгууллагуудтай хамтарч эхэлсэн. Тэр ч утгаараа чамлахааргүй тооны хүмүүсээ сургалтад суулгах, мэргэжилтнүүдээ олон улсын туршлагаас суралцах боломжуудыг нээж чадсан гэж боддог. Багагүй тооны хүмүүс маань сургалт, хэлэлцүүлэг олон улсын арга хэмжээнд оролцож байсан. Мөн манайд гаднын мэргэжилтнүүд, магистр, докторын оюутнууд сайн дурын ажил хийх дадлага хийх сонирхол нэлээн нэмэгдсэн. Миний санаж байгаагаар 2019 онд 4-5 гадаад мэргэжилтэн, дадлагажигч, сайн дурын хүмүүс манайд ажиллаж байсан. Гадаад харилцаа сайжрах тусам эргээд манайхыг сонирхож байгаа гаднын байгууллагууд, мэргэжилтнүүдийн тоо нэмэгдсэн. Гадаад харилцаатай уялдаад IRIM бусад байгууллагуудтай хамтран гадаадад төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах боломжууд нэмэгдэж эхэлсэн. Тухайлбал, тэр үед тавигдсан суурь дээр үндэслээд өнөө хүртэл цахимаар болон биечлэн Төв Азийн орнуудад 4-5 төсөл хэрэгжүүлсэн байна.

Манай байгууллагын онцлог гэвэл, бидний уриа чинь хараат бус, чанар, үр нөлөө тэгэхээр бусад байгууллагуудад ч гэсэн чанарын бодлоготой, улс төр, эдийн засаг аль нэг этгээдээс хараат бусаар үйл ажиллагаа явуулж чаддаг байх. Харин үр нөлөө гэдэг бол бидний үнэт зүйл. Тэр ч утгаараа судалгаа хийгээд зөвлөх үйлчилгээ үзүүлээд өнгөрчих зүйл биш тухайн асуудлаараа өөрчлөлт гаргах гэж зорьж эрмэлзэж ажилладаг хамт олон гэж боддог.



Л. Цэлмэгсайхан

2020 оноос хойш одоог хүртэл IRIM-ийн Гүйцэтгэх захирлын албыг хашиж байна.

IRIM-ЧУУД ИТГЭЛЦЭЛ, ХАМТЫН ХҮЧЭЭР ЦАР ТАХЛЫГ ХҮНДРЭЛ БАГАТАЙ ДАВЖ ЧАДСАН

Миний бие IRIM-даа ажиллаж хуримтлуулсан туршлагынхаа ачаар 2016-2018 онд Австрали Улсын Мельбурны их сургуульд Хөгжил судлалын магистрын зэрэг хамгаалсан. 2020 оноос дахин байгууллагынхаа Гүйцэтгэх захирлаар ажиллах хүндтэй бөгөөд сорилттой үүрэг хүлээж авсан. Ажил авах үед байгууллага маань салбартаа хэдийн танигдаж, байр сууриа олсон, хүчтэй засаглалтай, институтчилэл бэхэжсэн байсан. Шинэ аравны эхлэл утгаараа, 2020 оныг их өөдрөг эхлүүлсэн ч, тун удалгүй COVID-19 хэмээх хэний ч төсөөлөөгүй сорилт үүслээ. Тухайн үед амар байгаагүй, нөхцөл байдал өдрөөс өдөрт огцом өөрчлөгдөж, хийсэн гэрээ хэлэлцээр цуцлагдах, төлөвлөсөн ажлууд хугацаагүйгээр хойшлох, гэнэтийн хориг хязгаарт орох, хамгийн хэцүү нь өөрчлөгдөн буй нийгмийн сэтгэл зүйд зохицох явдал байсан. Байгууллагаараа сар тутам хуралдаж, нөхцөл байдлаа үнэлж ажилладаг байсан. Ямартай ч хамтын хүчээр цар тахлын үеийг хүндрэл багатайгаар, байгууллагынхаа үйл ажиллагааны цар хүрээг хумилгүй давж туулсан. Өнгөрсөн дөрвөн жилийн гол өөрчлөлтийг гурван санаанд зангидаж дүгнэж болно.

Нэгдүгээрт, байгууллагаараа цахим шилжилтийг амжилттай хийж чадсан. Бүрэн зайнаас ажиллаж сурна, шинэ цахим оффисын орчин руу шилжинэ, шинэ и-мэйл, шинэ программд хамтарч ажиллаж сурах нь өөрчлөлтийн томоохон менежмент байсан. Урд өмнө огт байгаагүй онлайн хуралд камер, микрофоноо зөв өгч, сууж сурахаас эхлээд

хөглөх, дассан сурснаасаа салах зэрэг хөгжилтэй, сургамжтай өдрүүд зөндөө байсан. Энэхүү ажлын дижитал шилжилт нь ажил амьдралын тэнцвэртээ ахиц гаргах, суралцах боломжийг олгосон.

Хоёрдугаарт, судалгааны ажлын хамгийн чухал хэсэг болох өгөгдөл, мэдээллийг бүрэн зайнаас цуглуулах чадавх, менежментийн арга барилыг нэвтрүүлсэн. Сүүлийн үеийн дуудлагын төвийг байгуулсны ачаар, цар тахлын улмаас хүн хоорондын нүүр тулсан харилцаа бүрэн хязгаарлагдсан үед, ямар ч саадгүйгээр судалгааны мэдээллийг цуглуулж, COVID-19-ийн хариу арга хэмжээний төсөл, сэргээн босгох арга хэмжээний хэрэгцээ, үр нөлөөний талаар шийдвэр гаргагчдыг үнэ цэнтэй мэдээллээр хангаж ажилласан нь цаашид шинэ гамшиг, онцгой нөхцөл байдал үүсэхэд орон зай, цаг хугацааны хязгаарлалтаас үл хамааран мэдээлэл, нотлох баримт цуглуулах бэлэн байдлаа бэхжүүлж чадсан.

Гуравдугаарт, судалгааны шинэ сэдвүүд рүү орох, шинэ зөвлөхүүдтэй хамтын ажиллагаа өргөтгөх боломжийг олгосон. Ялангуяа, цар тахлын үед, хүний эрх, хүүхдийн хүчирхийлэл, хүний наймаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн жендэрт суурилсан хүчирхийлэл, туслах малчдын хүний эрхийн зөрчил зэрэг тодорхой сэдвүүдэд судалгаа хийх замаар нийгмийн гаж үзэгдэл, криминологийн судалгааны чиглэлд чадавхаа хөгжүүлсэн. Энэ цаг үед цар тахлын үр дагаврыг даван туулахын тулд уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн үр ашигтай ашиглалт, ногоон эдийн засгийн чиглэлд судалгаа хийж байна.

IRIM-ЧУУДЫН ТҮҮХЭЭС



Н. Янжинпагма

IRIM судалгааны хүрээлэнд 2009 оноос хойш өнөөг хүртэл ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаандаа судлаач, ахлах судлаач, төслийн менежер, ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлыг хариуцан ажиллаж байна.

(2008-2012 оны төлөөлөл)

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХЭД АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН ОЛОН ТӨРЛИЙН АЖЛУУДЫН ЭХЛЭЛ ТАВИГДАЖ АЖИЛТНУУД ӨӨРСДИЙН ЗОРИЛГЫГ БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРААТАЙ УЯЛДУУЛЖ ЭХЭЛСЭН

МУИС-н Социологийн 2009 оны төгсөлтийн ангийнхан маань төгсөх жилдээ “Судлаач оюутан” төсөл хэрэгжүүлж, судалгаа хийхэд тулгардаг бэрхшээл, тухайн үеийн нийгмийн амьдралыг дүрсэлсэн “Үл гүйцэлдэл буюу Утопи” нэртэй кино төслийг хийж байсан. Тухайн кино төслийг хийхэд менежментийн багт манай ангиас Л.Цэлмэгсайхан, А.Долгион, Б.Эрдэнэ болон миний бие 4 хүний бүрэлдэхүүнтэй байв. Тухайн үед идэвхтэй хэрэгжиж байсан “Үдийн цай” болон “40000 айлын орон сууц” гэх хөтөлбөрүүдэд ангиараа үнэлгээ хийж, үр дүнг нь МУИС-ийн дугуй зааланд холбогдох талуудад танилцуулж байх үеэс судалгааны үр нөлөөг илүү тодоор, бүрэн зургаар харж эхэлсэн. Ингээд төгсөх үед Ч.Тамир багш манай кино төслийн багийнхныг IRIM-д ажиллах санал тавьж бид анхны ажлын гараагаа эхэлж байлаа.

IRIM-д ажилд орсны дараахан Жендерийн үндэсний хорооноос “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендерийн мэдрэмжтэй байдал” сэдвээр төсөлт ажил зарлагдаж, энэ нь миний бакалаврын дипломын сэдэв “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд сонгогдоход хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзүүлж буй нөлөө” судалгааны ажилтай маань шууд холбогдсоноор өөрийн судалгааны үр дүнгээ бодит нөхцөл байдалд хэрэгжүүлэх боломж бий болсон. Энэ ажлаас урам зориг авч цаашид судалгаагаар мэргэшин ажиллах, судалгаагаар дамжуулан нийгэмд нөлөөлөх боломжтойг олж харсан.

Мөн байгууллагын соёлын хувьд бие биеэсээ харилцан суралцах боломжийг бүрдүүлж өгсөн. Тухайлбал намайг анхлан ажилд орж байх үед Г.Цогтбаатар, М.Ариунтунгалаг, Э.Эрдэнэбаатар,

З.Зоригтбаатар зэрэг тухайн үеийн дээд төгсөлтийн ах, эгч нар маань бидэнд маш оновчтой, сэтгэлээсээ тусалж чиглүүлдэг байсан нь одоогийн хамтын соёлтой IRIM судалгааны хүрээлэнг бий болгох үндэс болсон гэж боддог. Энэ хугацаанд олон улсын болон дотоодын шилдэг зөвлөхүүдтэй хамтран ажилласнаар судлаачийнхаа хувьд суралцаж, өсөж хөгжсөн.

Манай байгууллага эхний 5 жилд байгууллагын алсын хараа, бүтэц зохион байгуулалт, байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэхэд илүүтэй төвлөрч байсан. Байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэх чиглэлд судлаачдад зориулсан зуны сургалт, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа, байгууллагын жилийн ойн арга хэмжээ гэх мэт ажилтнуудад чиглэсэн олон төрлийн ажлуудын эхлэл тавигдаж, эдгээр үйл ажиллагаанаас байгууллагын алсын хараатай өөрийн чиг зорилгыг уялдуулах талаар мэдээллийг авдаг байлаа. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд “Ажилтан өөрийн ирээдүйн зорилгоо, байгууллагын алсын хараатай уялдуулснаар байгууллага, ажилтан хоёулаа хөгжих боломжтой” гэсэн үзэл санааг байгууллага, ажилтан хоёр талаасаа ойлгож ажилладаг хамт олон болж төлөвшсөн.

Судалгаа, зөвлөх үйлчилгээний салбарт тасралтгүй 15 жил ажиллаж салбартаа улам мэргэшиж, ажил карьерын хувьд талбарын судлаачаас эхлэн, ахлах судлаач, ТУЗ-ийн гишүүн хүртэл өсөж, улам туршлагажиж байна. Мөн 2013 онд IRIM судалгааны хүрээлэнгийн охин компани болох бизнес, зах зээлийн судалгаа, инновацын зөвлөх үйлчилгээний МИРИМ Консалтант ХХК-ийг хамтран үүсгэн байгуулж, одоо ч ажилласаар байна.



Т. Элбэрэл

IRIM судалгааны хүрээлэнд 2012 оноос хойш тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаандаа судлаач, төслийн менежерээр ажиллаж байсан бөгөөд одоо ахлах судлаач, зөвлөхөөр ажиллаж байна.

(2013-2017 оны төлөөлөл)

СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨСЛҮҮД СУДЛААЧДЫГ ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАХ, МЭДЛЭГ, ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ РҮҮ ХӨТӨЛДӨГ

Би 2011 онд үйлдвэрлэлийн дадлагаа IRIM-д хийж байснаар нийгмийн ажилтан гэдэг мэргэжлээс судлаач мэргэжилд шилжин 12 дахь жилдээ ажиллаж байна. Анх Азийн Хөгжлийн Банкны нийгмийн эрүүл мэндтэй холбоотой төсөлд туслах судлаачаар ажиллан түүнээс хойш энэ чиглэлээр мэргэшин ажлын гараагаа эхлүүлж байжээ. Дипломын ажлаа Тамир багшаар удирдуулж байхдаа IRIM-ийг илүү академик, эрдэм шинжилгээний байгууллага байх гэсэн хүлээлт байсан. Гэтэл төслүүд дээр ажиллаж үзтэл илүү практикал чиглэлтэй, бодитой санагдсан.

Эргээд харахад миний карьер хөгжил 3 үе шатад хуваагдаж байна. Эхний хоёр жилд өөрийгөө сорих, шинэ орчинд шинэ салбар, чиглэл рүү орж, дасан зохицох шаардлагатай болсон. Дараа нь 4-6 дахь жилдээ төлөвшин, ажлаа ойлгож илүү бие дааж хийх, баг хамт олонтойгоо уусааж олон төслүүд дээр хамтран ажиллаж ирсэн. Гурав дахь шатанд буюу 6 дахь жилдээ АНУ-ын Засгийн газрын Fulbright-ийн тэтгэлэг авч АНУ-ын Жоржиа мужийн их сургуулийн Андрью Яангийн бодлого судлалын сургуульд Төрийн бодлогын чиглэлээр магистрын зэрэг горилсон. Мэдээж тэтгэлгээр суралцахад IRIM-д ажилласан

туршлага, эзэмшсэн мэдлэг, ур чадвар томоохон дэмжлэг болсон. Төгсөж ирээд ч үргэлжлүүлэн ажиллаж байгаа учраас миний карьер хөгжилтэй IRIM салшгүй холбоотой.

Мэргэжлийн онцлогоос шалтгаалан аливаа зүйл дээр үзэл бодлоо илэрхийлэхдээ субъектив хандлагаас илүү нотолгоонд суурилсан, баримт мэдээлэлд тулгуурлан ярих соёл хувь хүний түвшинд үүссэн болов уу гэж хардаг.

Манай ажлын онцлог нь шинэ сэдвүүдийг судалж, өөр өөр хүмүүстэй ажиллах боломжийг олгодог нь биднийг байнга суралцах, шинийг эрэлхийлэх, шат ахих үйл рүү хөтөлдөг. Энэ нь шинэ судалгаа, үнэлгээний төсөл рүү орсноор нэг салбар чиглэлийг илүү танин мэдэж байна гэсэн үг. Мөн нэгнээсээ суралцах, харилцан туслах байгууллагын соёл их зөв санагддаг. IRIM-ийн хоёрдугаар таван жилийг тодорхойлбол, хүний нөөцийг олон улсын түвшинд бэлтгэх чиглэлд ихээхэн анхаарсан. Энэ ч утгаараа хамтдаа олон улсын тэтгэлэг, хөтөлбөрүүдэд тасралтгүй бэлдэж, хувь хүний хувьд карьер, байгууллагын хувьд хүний нөөцөө олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц болгоход анхаарч, хувь нэмрээ оруулсан жилүүд гэж онцолж болох юм.



Г. Жаргалмаа

IRIM судалгааны хүрээлэнд 2016 оноос хойш судлаач, зохицуулагч, төслийн менежер, ТУЗ-ийн нарийн бичгээр ажиллаж байсан.

Одоо Үйл ажиллагааны захирлаар ажиллаж байна.

(2018-2023 оны төлөөлөл)

НЭГ ТАЛААС БАЙГУУЛЛАГЫН ИНСТИТУТЧИЛЭГДСЭН БАЙДАЛ, НӨГӨӨ ТАЛААС ИЖИЛ ҮНЭТ ЗҮЙЛТЭЙ ЭЕРЭГ ХАМТ ОЛОН МААНЬ IRIM-ИЙГ МИНИЙ ХУВЬД ХҮСЭМЖИТ АЖЛЫН БАЙР БОЛГОДОГ.

МУИС-д нийгмийн ажилтан мэргэжлээр суралцаж байхдаа IRIM-д дадлага хийх боломж олдсоноор байгууллагатайгаа холбогдож эхэлсэн. Бакалаврын дипломоо “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах” сэдвээр бичээд сургуулиа төгсөх үеэр IRIM-д яг энэ чиглэлийн төсөл эхэлж, Ч.Тамир багшаас холбож өгч байснаар анх төсөл дээр туслах судлаачаар орж ажлын гараагаа эхэлсэн. Их сургуульд судалсан зүйлээ ажил хэрэг болгох, ашиглах боломж олдсонд тухайн үедээ маш их баярлаж байж билээ.

Анх ажилд ороод “Шинэ судлаачдын сургалт”-д хамрагдахад судлаачдын туулах карьерын зураглалыг танилцуулж байсан нь одоо хүртэл мартагддаггүй. Туслах судлаачаас эхлээд судлаач, зохицуулагч, менежер цаашлаад сэдвчилсэн агуулгаар мэргэшиж, салбарын эксперт, зөвлөхийн түвшинд хүрэх боломжтой зэргээр судлаач хүний урт хугацааны карьерын боломжуудыг дурдаж, үүнд байгууллагын зүгээс оруулж чадах хувь нэмэр, дэмжих боломжуудаа бас тодорхой тайлбарлаж байсан. Одоо эргээд харахад яг тэр тайлбарлаж, хэлж өгч байсан замналаар л явж байна.

Намайг анх орж ирэхэд ISO-г үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд, дүрэм журмууд шинээр боловсруулагдаж, ажилтнуудын чиг үүргүүд илүү нарийвчлагдаж байсан. Дөнгөж сургуулиа төгссөн надад Минжирмаа эгч, Сүхээ ах нарын ярьдаг байсан орц, гарц, шаардлага, аудит гэх зүйлүүд их л хол санагдаж байсан. Одоо ингээд ISO стандартаа нэвтрүүлж, баталгаажуулалтаа авчихсаны дараа харахад чанарын менежментийн тогтолцоог

байгууллагынхаа үйл ажиллагаанд бүр соёл болтол нь хэвшүүлнэ гэдэг маш их хичээл зүтгэл, анхаарал, манлайлал шаарддаг ажил санагдаж байна. Бас ISO-ийн тасралтгүй сайжруулалт хийнэ, тогтмол процессоо сайжруулах өнцгөөс хардаг байна гэдэг зарчим нь манай байгууллагын хамт олны соёлтой ч их уялдаж байгаа санагддаг.

Бусад байгууллагуудтай харьцуулахад манайх тун залуу хамт олонтой. Тиймдээ ч бүгд дор бүрнээ өсөж, хөгжих, улам мэргэших хүсэл эрмэлзэлтэй, ижил үнэт зүйлтэй байдаг тул манай байгууллагын дотоод уур амьсгал, хамт олны соёл маш дулаан. Ийм хамт олонтой байхаар ажлаас гадна олон зүйлийг үе тэнгийн залуучуудаасаа суралцах боломжтой байдаг нь сайхан. Тухайлбал, одоо Австралид суралцаж байгаа Ээгий (Эрдэнэцэцэг)-ийн хурдтай, эрч хүчтэй байдал, хөгжилтэй зан чанар, Тина (Түвшинтөгс) хөдөлмөрч, нямбай, няхуур байдал, Нара (Нарантуяа)-ийн үргэлж хамт ажиллагсдаа халамжилж, санаа тавьдаг чанарууд гээд үе үеийн IRIM-чууд байгууллагын институцын, соёлын одоогийн хөгжлийг бий болгосон юм. Тайлангийн хугацаа тулсан үед хонож ажиллах хэрэг гарна, хурал дээр шаардлагатай төслүүд дээр гаргалгаа олох гэж бүгд нийлж суугаад ярилцана, хэн нэгнийхээ төсөлд хэрэгтэй мэдээлэл олбол хуваалцана, ачаалал их үед гэр бүл шиг сайхан дэмжигч, хамтач, эерэг хандлагатай залуучуудтай хамт ажиллах нь маш том дэмжлэг байдаг.

Нэг талаас байгууллагын тодорхой түвшинд хүрч институтчилэгдсэн байдал, нөгөө талаас ижил үнэт зүйлтэй эерэг, дулаан хамт олон маань IRIM-ийг миний хувьд хүсэмжит ажлын байр болгож байдаг юм уу даа.

IRIM-ИЙН 15 ЖИЛИЙН ТОВЧООН

Үүсэл

ҮҮСГЭН БАЙГУУЛАГДАВ

“Шилэн түрийвч” санаачилгын хүрээнд төсвийн ил тод байдлыг бий болгох чиглэлээр төрийн байгууллагуудыг чадавхжуулан ажилласан нь “Шилэн дансны тухай хууль” батлагдан гарахад нөлөөлсөн.

ISA ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА БОЛОВ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдан гарснаар өмнө нь тогтоол байх үеийн үнэлэх арга зүйгээ шинэчлэн сайжруулж, төрийн байгууллагын цахим хуудсыг хэмжих арга зүйн үндсэн хүрээгээ тодорхойлон, уг арга зүйгээр тогтвортой үнэлж эхлэв.

АҮАД ХӨТӨЛБӨР ХҮЛЭЭН АВАГЧ

2008 он

2008 оны 4-р сарын 4-нд дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулагдсан.

2009 он

НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУДЫГ ХИЙЖ ЭХЛЭВ

2010 он

Олон улсын Социологийн холбоонд албан ёсны гишүүнээр элссэн.

2011 он

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХЭМЖИЖ ЭХЛЭВ

2012 он

Австралийн сайн дурынхан хөтөлбөрөөс олон улсын сайн дурын ажилтныг анх удаа хүлээн авч эхэлснээр байгууллагын чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарах эхлэл тавигдсан.

Байгууллагын институтчилэл

Хараат бус, ил тод зарчмыг түгээн дэлгэрүүлэх үүднээс бид 2013-2014 оноос эхлэн жил бүр хэрэгжүүлсэн төсөл, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй түгээх “Жилийн тайлан”-г гаргаж эхлэв.

МИРИМ ХХК ОХИН КОМПАНИ БАЙГУУЛАВ

ХШҮ-ний салбарт ажилладаг, салбарыг хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй үнэлгээчдийг нэгтгэн Монголын Үнэлгээний Сүлжээг үүсгэлээ.

СТРАТЕГИ, БОДЛОГОО ШИНЭЧЛЭВ

Субъектив сайн сайхан байдлын судалгааг эхлүүлж, үр дүнг олон улсын үр дүнтэй харьцуулан, үндэсний хэмжээнд олон нийтэд нээлттэй түгээсээр байна. Энэ хүрээнд “Олон Улсын Субъектив Сайн Сайхан Байдлын Түншлэл”-д гишүүнээр элсэж, мөн “Ази Номхон Далайн Үнэлгээний Холбоо”, “Өөрчлөлтийн Төлөөх Инновац санаачилгын Төв Азийн бүлэг”-т тус тус гишүүнээр элсэв.

2013 он

ЖИЛИЙН ТАЙЛАН ГАРГАЖ ЭХЛЭВ

IRIM дэргэдээ охин компани байгуулан, судалгаа, шинжилгээний зах зээлд маркетинг, бизнес, инновац судалгааны үйлчилгээ үзүүлэх, энэ туршлагыг нийт байгууллагаараа хуваалцан, хамтдаа хөгжих суурь тавигдсан.

2014 он

2015 он

ҮНДЭСНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭ САНААЧИЛГЫГ ЭХЛҮҮЛЭВ

Дэлхий дахинд болон үндэсний хэмжээнд хөгжлийн зорилгуудыг дахин тодорхойлж буйтай холбоотойгоор бид байгууллагын шинэ алсын хараа, үнэт зүйл болон Стратегийн Төлөвлөгөө; 2016-2020-г боловсруулав.

2016 он

2017 он

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЖ, МӨН “НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА”-Г ЭХЛҮҮЛЭВ.

Төлөвшил

21-Р ЗУУНЫ АРДЧИЛАЛ: “СОРИЛТУУД БА ЦААШДЫН ХАНДЛАГА” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг хэмждэг арга зүйгээ шинэчлэн олон улсад ашиглаж болохуйц “Ил тод байдлын индекс” болгон Төв Азийн улсуудад танилцуулж, Киргизстан улстай харьцуулсан туршилт судалгааг амжилттай зохион байгуулав.

ЗАЙНААС МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ИЖ БҮРЭН ДУУДЛАГЫН ТӨВТЭЙ БОЛОВ

Олон улсын “Give2Asia” хандивын сүлжээ болон Лантуун дохио ТББ-уудтай хамтран зорилтот бүлэгт чиглэсэн ажлуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэв.

ISO 9001:2015 СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

2018 он

IRIM нь Дэлхийн Нийгмийн Сангийн дэмжлэгтэйгээр Ардчиллын сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 14 орны 31 эрдэмтэд өөрсдийн илтгэл, өгүүллээ танилцуулав.

2019 он

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХЭМЖИХ ТУРШЛАГАА ОЛОН УЛСАД

2020 он

COVID-19 цар тахлын хөл хорионы үед зайнаас мэдээлэл цуглуулах чадавхаа дээшлүүлж, иж бүрэн дуудлагын төв байгуулж, тасралтгүй, тогтвортой ажиллагаагаа ханган ажиллав.

2021 он

ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЧИГЛЭСЭН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА НЭМЭГДҮҮЛЭХ АЛХАМ

2022 он

2016 оноос хойш үйл ажиллагаандаа нэвтрүүлж ирсэн ISO 9001:2015 Чанарын Менежментийн Тогтолцооны олон улсын баталгаажуулалтын гэрчилгээг гардан авав.

ЗУРГИЙН ЦОМОГ



| IRIM-ийн анхны Зуны сургалт, 2009 он



| IRIM-ийн 2 жилийн ой, 2010 он



| IRIM-ийн 3 жилийн ой, 2011 он



| IRIM-ийн 4 жилийн ой, 2012 он



| IRIM-ийн 5 жилийн ой, 2013 он



| IRIM-ийн 6 жилийн ой, 2014 он



| IRIM-ийн 7 жилийн ой, 2015 он



| IRIM-ийн 8 жилийн ой, 2016 он



| IRIM-ийн 9 жилийн ой, 2017 он




| IRIM-ийн 10 жилийн ой, 2018 он



| IRIM-ийн 11 жилийн ой, 2019 он



| IRIM-ийн 12 жилийн ой, 2020 он



IRIM-ийн 13 жилийн ой, 2021 он. COVID-19 цар тахлын хорио цээрийн улмаас 13 жилийн ойг цахимаар зохион байгуулав.



IRIM-ийн 14 жилийн ой, 2022 он

Бүлэг 2

IRIM 2022 ОНД

- ◆ 2022 оны онцлох мэдээ
- ◆ IRIM-ийн брэнд төслүүд
- ◆ Засаглал
- ◆ Тогтвортой байдал
- ◆ Боловсрол
- ◆ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээл
- ◆ Жендэр ба Хөгжлийн бэрхшээл
- ◆ Бусад төслүүд

2022 ОНЫ ОНЦЛОХ МЭДЭЭ

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015 СТАНДАРТЫН БАТАЛГААЖУУЛАЛТАА АВЛАА



IRIM судалгааны хүрээлэн нь судалгаа, үнэлгээ, зөвлөх үйлчилгээний төслүүдээ мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулахад анхаарсаар ирсэн. Уг зорилтынхоо хүрээнд 2016 оноос хойш олон улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2022 оны 8 сард олон улсын баталгаажуулалтын гэрчилгээг гардан авлаа. IRIM судалгааны хүрээлэн “Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байх” чанарын бодлогыг дэвшүүлэн, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулахад анхааран ажилласаар байна.

БЭЛГИЙН ДАРАМТ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛСЭН АЖЛЫН БАЙРНЫ ЭЭЛТЭЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ БАЙНА

IRIM судалгааны хүрээлэн 2017 оноос хойш Жендэрийн үндэсний хорооны гишүүн байгууллагаар ажиллаж, хорооны жил тутмын төлөвлөгөөнд туссан ажлуудын хэрэгжилтийг хангахад санаачилга гаргаж, холбогдох судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгэсээр ирсэн билээ.

Энэ удаад бид байгууллагын дотоод соёл институтчилэл, менежментийн бүх түвшинд жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллагын онцлогт тулгуурласан “Ажлын байрны бэлгийн дарамт, хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх бодлого”-ыг Австралийн Сайн Дурынхан Хөтөлбөрийн Үр нөлөөний сангийн дэмжлэгтэйгээр 2022 онд боловсруулан, байгууллагадаа нэвтрүүлээд байна.

Уг бодлогыг хэрэгжүүлснээр үндэсний болон олон улсын хууль тогтоомжийн хүрээнд ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх чиглэлд тавигдаж буй ажил олгогчийн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаагийн зэрэгцээ илүү хүний эрхийг дээдэлсэн, мэргэжлийн ёс зүйтэй хамт олныг төлөвшүүлэх, учирч болзошгүй хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх чиглэлд ажлын байрны соёлын хувьд нэг алхам урагшилсан алхам болж буй юм. Тус бодлогыг байгууллага дотооддоо нэвтрүүлээд зогсохгүй салбарын бусад судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллагуудад уг бодлогын баримт бичгийг нэвтрүүлэхийг уриалах зорилгоор салбарын оролцогч талуудад танилцуулсан. Түүнчлэн уг бодлогын баримт бичгийг Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өөрсдийн вэбсайтаар дамжуулан Англи, Монгол хэлээр нээлттэй хуваалцлаа. Бодлоготой дараах холбоосоор танилцах боломжтой. [АББДХМУСБ](#)



DATA MANAGEMENT SYSTEM-ЭЭ ШИНЭЧИЛЛЭЭ

IRIM судалгааны хүрээлэн 15 жилийн хугацааны төслийн менежментийн туршлагадаа тулгуурлан байгууллагын дотоод мэдлэгийн сан болох **Data Management System (DMS)**-г 2016 оноос хойш ашиглаж байна. Техник технологийн хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэн алхах үүднээс байгууллагын дотоод системээ Microsoft 365 платформын Power Platform-д суурилсан хувилбарт хөрвүүлж, хэрэглээнд нэвтрүүлээд байна. Энэхүү үүлэн технологид суурилсан шийдэл нь бүтээгдэхүүний хувилбар бүрийн түүх болон утсан мэдээллийг сэргээх, нэгдсэн платформ дээрээс хэрэглэгчдийнхээ хэрэглээг дэмжих, дундын мэдээллийн сан, харилцаа холбоон дээр суурилсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааны зорилго, процессын зураглалд суурилан хөгжүүлснээрээ ихээхэн онцлогтой.



Ингэснээр судалгаа, зөвлөх үйлчилгээний ажлын байнгын тасралтгүй сайжрах процессыг хялбарчлахад дотоод мэдээллийн сан бүхий системээр дамжуулан өмнөх төсөл, үйл ажиллагааны мэдээллийг хайж, ашиглан, боловсруулж буй арга зүй, аргачлал, тайлан, шинжилгээ бүхий бүтээгдэхүүнүүд маань сайжрах боломжийг бий болгож байна.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧАДАВХАА НЭМЭГДҮҮЛЖ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛСЭЭР БАЙНА

IRIM судалгааны хүрээлэн нь Монголын Үнэлгээний Сүлжээг үүсгэн байгуулагчдын нэг болохын хувьд Монгол Улсад үнэлгээний мэдлэг, ур чадварыг таниулах, нэмэгдүүлэхэд ихээхэн идэвх санаачилгатай, анхаарч ажилласаар ирсэн. Сүлжээ нь албан ёсны www.evaluation.mn вэбсайтыг үүсгэж, хөгжүүлэлтийн ажлыг эхлээд байна. Монголын үнэлгээний чадавхыг бэхжүүлэхийн тулд 2022 онд манай байгууллага дараах онцлох ажлуудыг хийжээ.

IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх Ц.Батсугар 'Ази Номхон Далайн Үнэлгээний Холбооны (АРЕА) III бага хурал'-д панелистаар оролцов. Түүнчлэн уг холбооноос 12 дугаар сард зохион байгуулагдсан Үндэсний Үнэлгээний Бодлого, Системийн Ази Номхон Далайн Бүсийн Хэлэлцүүлэгт Монголын Үнэлгээний Сүлжээг төлөөлөн **Монголын үнэлгээний бодлого, системийн статусыг танилцууллаа.**



Ахлах судлаач Т.Элбэрэл нь Швейцар улс дахь Берний Их Сургуульд зохион байгуулагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр дэлхий дахинд хамгийн нэр хүндтэй хөтөлбөр болох "Олон улсын хөгжлийн үнэлгээний

сургалтын хөтөлбөр 2022"-т хамрагдав. Уг хөтөлбөр нь Дэлхийн Банкны Хараат Бус Үнэлгээний Групп болон Дэлхий дахины Үнэлгээний Санаачилга, Үнэлгээний төлөөх Төв зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулдаг хөтөлбөр юм. Тэрээр одоо Монголын Үнэлгээний Сүлжээний нарийн бичгийн дарга бөгөөд Тогтвортой Хөгжлийн Зорилтын хэрэгжилтийн талаарх "Үндэсний сайн дурын илтгэл" бэлтгэх ажлын хэсэгт орж, ХШҮ-ний салбарт хувь нэмрээ оруулсаар байна.

ЗАСАГЛАЛ, ИРГЭНИЙ ОРОН ЗАЙГ ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛСААР БАЙНА

Нийгмийн хөгжилд иргэний нийгмийн дуу хоолойг хүргэх, үндэсний хууль тогтоомжид орж буй өөрчлөлт, шинэчлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, өөрсдийн байр суурийг илэрхийлсээр байна. Тухайлбал, 2021 онд “Нийтийн мэдээллийн тухай” хуулийн төслийн талаарх ирээдүйд үүсэж болох эрсдэлийн талаарх байр сууриа илэрхийлж байсан бол 2022 онд “Монголын Үнэлгээний Сүлжээ”-тэй хамтран “Гүйцэтгэх засаглалын хяналтын тухай хуулийн төсөл”-ийг эсэргүүцсэн мэдэгдэл гарган холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн тус онд Ашгийн Төлөө бус Олон Улсын Төв (ICNL)-ийн дэмжлэгтэйгээр Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрийн иргэний орон зайд үзүүлсэн нөлөөллийг судалсан “Монгол Улс дахь иргэний орон зайн тэсвэртэй байдал: Цар тахлын сургаж” судалгааны ажлыг гүйцэтгэж, үр дүнг хэвлэл мэдээлэл, салбарын мэргэжилтнүүдэд танилцууллаа.



Үүгээр зогсохгүй манай судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач “Тогтвортой Хөгжлийн Зорилтын хэрэгжилтийн талаарх Үндэсний сайн дурын илтгэл” бэлтгэх ажлын хэсэгт, инновац, технологийн менежер “Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллаж байна. Ардчилал, иргэний нийгмийн судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдгийнхаа хувьд бид 2018 онд зохион байгуулсан ардчиллын олон улсын хурлын хүрээнд гарсан илтгэлүүдийг нэгтгэн “[Ардчиллын](#)

[тэмцэл сорилтын жилүүдэд: Монгол ба Дэлхийн улс орнууд туршлагажиж эхэлсэн нь](#)” бүтээлийг Дэлхийн нийгмийн сантай (WSF) хамтран эрхлэн гаргасан. Мөн түүнчлэн IRIM судалгааны хүрээлэн “Азийн ардчиллын судалгааны сүлжээ” (ADRN)-ний гишүүнчлэлийнхээ хүрээнд тус сүлжээний “ADRN Working Paper” эрдэм шинжилгээний сэтгүүлд “[Монгол дахь шууд ардчиллын түүх, чиг хандлага](#)” сэдэвт өгүүлэл, “ADRN Special Reports” сэтгүүлд “[Ази дахь шууд ардчиллын уналт босолт](#)” сэдэвт өгүүлэл нийтлүүлээд байна.

ЗАЙНААС МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ТУРШЛАГАДАА ТУЛГУУРЛАН ЗҮҮН ТИМОР УЛСАД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

IRIM судалгааны хүрээлэн 2020 оноос хойш зайнаас мэдээлэл цуглуулах дуудлагын төвийг байгуулж, 2 жилийн хугацаанд нийт 20,000 оролцогчоос мэдээлэл цуглуулаад байна. Өөрсдийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан 2022 онд Зүүн Тиморын Улсын Статистикийн газрын мэргэжилтнүүдийг



[CATI \(computer assisted telephone interview\)](#) арга зүйд сургаж чадавхжуулах, утсан судалгааны технологийн дэд бүтцийн шийдлийг сонгох, нутагшуулах зэргээр мэдээлэл цуглуулалтын ажлыг 2022 оны 5 дугаар сард зохион байгууллаа.

Зөвлөх үйлчилгээг Дэлхийн банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Зүүн Тимор улсын Үндэсний Статистикийн газар (GDS) хамтран хэрэгжүүлж буй “COVID-19-ийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хянах өрхийн утсан судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтад дэмжлэг үзүүлэхэд хамтарч ажиллан олон улсад хэрэгжүүлсэн төслийн тоогоо нэгээр нэмлээ.

ТӨВ АЗИЙН БҮСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА (CAREC)-НЫ ИНСТИТУТИЙН ХӨГЖЛИЙН ТИНК ТАНК ФОРУМД ОРОЛЦЛОО

Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институт (CAREC)-ийн гишүүнээр IRIM судалгааны хүрээлэн 2022 онд элссэн. CAREC институтээс жил бүр зохион байгуулдаг Тинк Танкуудын Хөгжлийн VI Форум нь “Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийн динамикийг дахин тохируулах нь” сэдвийн дор 2022 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Азербайжан Улсын Баку хотноо зохион байгуулагдлаа. Тус форумд IRIM судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан Монгол Улсын төлөөлөгчдийн нэгээр оролцлоо. Чуулганаар хөгжлийн төлөөх татварын хуваарилалт, уур амьсгалын өөрчлөлт болон жендерийн тэгш бус байдлыг бууруулах, дижиталчлалыг бэхжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах нь CAREC-ийн орнуудын хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах бодлогын тэргүүлэх чиглэл болохыг онцолсон юм.



НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭ ХУВААЛЦЛАА

22 жилийн дараа зохион байгуулж буй “Социологийн симпозиум VI”-д IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх Ц.Батсугар оролцож, “Монголын нийгмийн нэгдэл нягтрал” сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Энэхүү сэдэв нь 2016 оноос хойш IRIM судалгааны хүрээлэнгийн бие даан судалж, хөгжүүлж буй ажил болох “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны нэг бүрэлдэхүүн юм.

Мөн судалгааны цаг үеийн шинжтэй үр дүнг манай судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбатын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг 2022 оны Жилийн хүлээн авалтын үндсэн сэдвээр онцолж, Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан “Сорилттой цаг үеийн Монголын нийгмийн сайн сайхан байдал ба эмзэг байдал: IRIM-ийн сүүлийн судалгаануудад суурилсан ажиглалт” сэдвийн дор илтгэл танилцууллаа.

Өнгөрсөн хугацаанд тус сэдвээр судалгааны 3 тайлан, 1 эрдэм шинжилгээний нийтлэл, 3 илтгэл бэлдэн олон нийт болоод зорилтот байгууллагуудад танилцуулаад байна.



ЯПОН УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “АЗИЙН 7 ОРНЫ ЗАЛУУ СУДЛААЧДЫН ХАМТАРСАН СУДАЛГААНЫ ХӨТӨЛБӨР”-Т ОРОЛЦЛОО



Уг хөтөлбөр нь олон улсын судалгааны сүлжээ, судлаачдын чадавхыг нэмэгдүүлэх зорилготой Core-to-Core хөтөлбөрөөс 2022-2024 оны хооронд хэрэгжиж буй “Азийн хөгжиж буй орнуудад Санаачилгад тулгуурласан тэсвэртэй байдлыг бий болгоход Нийгмийн капиталыг ашиглах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй юм. Хөтөлбөрт Монголоос IRIM судалгааны хүрээлэнгийн судлаачдын төлөөлөл Филиппин болон Вьетнам Улсын

судлаачидтай хамтран “Байгалийн аливаа эрсдэл, гамигийн үе дэх Нийгмийн капитал болон идэвхтэй тэсвэртэй байдал (Proactive Resilience)” сэдэвт судалгааг ирэх гурван жилийн хугацаанд гүйцэтгэхээр боллоо. Уг судалгаагаар уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа байгалийн гамшиг, эрсдэл болохоос өмнө болон дараа иргэд, олон нийтийн тэсвэртэй байдлыг бий болгоход нийгмийн капитал буюу олон нийтийн бүлгийн холбоо сүлжээ, итгэлцлийн нөхцөл байдал хэрхэн нөлөөтэйг хуурай газрын болон арлын улс орнуудын нөхцөл байдалд харьцуулан судлахаар ажиллаж байна.


АВСТРАЛИЙН САЙН ДУРЫНХАН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 7 ДАХЬ САЙН ДУРЫН АЖИЛТНАА ХҮЛЭЭН АВЛАА

IRIM судалгааны хүрээлэн Австралийн Сайн Дурынхан хөтөлбөртэй тогтвортой хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээндээ онцлох хамтын ажиллагаа нь сайн дурын ажилтны хөтөлбөр юм. 2011 оноос эхэлсэн уг хөтөлбөрөөр дамжуулан бид 5 сайн дурын ажилтныг эх орондоо хүлээн авч, хөтөлбөрүүдээ амжилттай хэрэгжүүлсэн билээ.

Харин цар тахлын үеэс хойш 2 дахь сайн дурын ажилтнаа зайнаас буюу цахимаар хүлээн авч, ажиллаа. Энэ удаагийн хөтөлбөр нь байгууллагын олон нийттэй харилцах үйл ажиллагаанд чиглэж, энэ чиглэлийн эксперт Женни Смиттэй хамтран байгууллагаас бэлтгэн гаргадаг тогтмол мэдээлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зорилтот бүлгүүдэд хүргэхэд харах өнцөг, хүргэх мессежийн онцлогуудыг тусгах сайн туршлагууд бий болгож чадсан.




Australian
Volunteers



Independence

Quality

Impact



15 ЖИЛИЙН ОЙН БОСГОН ДЭЭРЭЭ ШИНЭ ОФФИСТОО НҮҮЖ ОРЛОО

IRIM судалгааны хүрээлэн анх үүсгэн байгуулагдахдаа МУИС-ийн хичээлийн II байрны ард байрлах Green House барилгын дотор үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 15 жилийн ойн босгон дээрээ эхэлж байсан байршилдаа нүүж ирэн бууриа сэлгэлээ. Манай байгууллага хөгжлийн шат бүрдээ оффисоо сэлгэж, өдгөө 6 дахь оффисоо нүүн ороод байгаа нь энэ юм. Бидний шинэ байршил [Уланбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 48-р байр, 301 тоот.](#)

IRIM-ИЙН БРЭНД ТӨСЛҮҮД

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС 2022



САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

- IRIM судалгааны хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Индексийн гол зорилго нь төрийн байгууллагуудын цахим мэдээллийн ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хөшүүрэг болоход хувь нэмэр оруулах зорилготой юм. Индексийн гол зорилтууд нь:

- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.



2022 9-р сар

2023 3-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

93 төрийн байгууллага	
16	- Яам
26	- Хэрэгжүүлэгч агентлаг
10	- Тохируулагч агентлаг
10	- Парламентын харьяа байгууллага
22	- Аймаг, нийслэлийн ЗДТГ
9	- Нийслэл, дүүргийн ЗДТГ

Төрийн захиргааны нийт 93 байгууллагын үр дүнд үндэслэн цахим ил тод байдлын индексийг тооцон гаргадаг.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал эрчимтэй явагдаж, дижиталчлал болон мэдээлэл, харилцаа, холбооны технологи (МХХТ)-ийн хэрэглээ дэлхийн өнцөг булан бүрийг хурдацтай хамарч, засгийн газар, хувийн хэвшил, олон нийтийн болон бизнесийн уламжлалт хэв маягийг дахин хэлбэржүүлж байна. Энэхүү МХХТ-ын дэвшил нь иргэдэд мэдээлэл нээлттэй, хурдан шуурхай хүрэхэд хамгийн чухал хэрэгсэл болж байна. МУЗГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Цахим үндэстэн" болох зорилт тавьж, үүнд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. Үүний үр дүнд цахим засаглалтай холбоотой эрх зүйн орчны шинэчлэлт, түүнийг хэрэгжүүлэх бүтэц бий боллоо. Нийтийн мэдээллийн тухай хууль шинээр батлагдаж, 2022 оноос мөрдөгдөж эхэлж байгаатай холбоотойгоор шинэчилсэн арга зүйгээр хийж буй энэ мониторингийн үр дүн нь шинэ хуулийн мониторингийн суурь болж байгаагаараа онцлог байна.

IRIM судалгааны хүрээлэн нь цахим ил тод байдлын хөндлөнгийн үнэлгээг 11 дэх жилдээ гүйцэтгэн та бүхэнд хүргэж байгаа бөгөөд мэдээллийн цахим ил тод байдлыг тогтмол сайжруулахад нь хөшүүрэг болох үндсэн зорилготойгоор хийж хэрэгжүүлсээр ирлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүн бус (i) мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх, (ii) түүнийг хэрэгжүүлэх

төрийн байгууллагын чадамж байгаа эсэх, (iii) үүний үр дүнд иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн, хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх үйл явцыг үнэлэх юм. Тиймээс энэхүү индексийн загвар нь гурван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бүрэн цогцоор нь үнэлэх оролдлого юм.



Цахим ил тод байдлын индексийн үзэл баримтлалын хүрээ

Ихэнх индексийн адилаар индикаторуудыг нэгтгэж, цахим ил тод байдлыг илтгэх нэгдсэн нэг оноогоор хэмжигдэнэ. Эдгээр оноо нь үндэсний болон байгууллагын түвшинд илэрхийлэгдэх боломжтой байна.

Цахим ил тод байдлын индексийг хэмжихийн тулд 35 шалгуур үзүүлэлтийн дагуу 150 асуулт/үзүүлэлтийг ашигладаг.



Тооцох аргачлал


Индексийн үзүүлэлтийгс байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэхийн тулд харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлана. Энэхүү индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож байна.

Индексийн түвшин

ГОЛ ҮР ДҮН

Төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 93 төрийн байгууллагын 2022 оны цахим ил тод байдлын ерөнхий индекс 63.1% гарсан нь төрийн

байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд байгааг харуулж байна. Уг үр дүнг 2021 онтой харьцуулахад (60.2%) бага зэрэг өссөн байгаа ч ангиллын хувьд ялгаагүй 'сул' гэсэн түвшинд хэвээр байна.



Бодлогын орчин олон улсын болон үндэсний түвшинд 'хангалттай' гэж үнэлэгдэж байна. Харин эдгээрийг хэрэгжүүлэх байгууллагын түвшинд авч хэрэгжүүлж буй төлөвлөгөө, арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлага байгаа нь ажиглагдав.

Байгууллагын чадамжийн хувьд хүний нөөц, технологийн чадавх 'хангалттай' түвшинд байгаа боловч удирдлагын манлайлал хангалтгүй, албан хаагчдадаа ил тод болгох мэдээллийн журам, хүрээг боловсруулан хэрэгжүүлдэггүй, танилцуулдаггүй, хяналт сул, байгаагаас мэдээллийн ил тод байдал төдийлөн сайжрахгүй байна.

Цахим нээлттэй мэдээллийг 2021 оны үр дүнтэй харьцуулахад (62.7%) 'сул' гэсэн ангиллаас буурсан байгаа нь мэдээллийн ил тод байдлын эрх зүйн шинэчлэлтэй шууд холбоотой. Учир нь 2022 оноос Нийтийн мэдээллийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шинэ хуулийн дагуу мэдээллийг байгууллагууд байршуулж хэвшээгүй байна.

#	Байгууллагын төрөл	2021 оны индекс	2022 оны индекс	Зөрүү
1	Монгол Улсын Яамд	64.8%	66.6%	1.8%
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	59.5%	62.5%	3.0%
3	Тохируулагч агентлагууд	63.3%	61.2%	-2.1%
4	Аймгуудын ЗДТГ	58.4%	65.6%	7.2%
5	Дүүргүүдийн ЗДТГ	61.2%	62.7%	1.5%
6	Парламентын харьяа байгууллагууд	59.7%	64.5%	4.8%
Ерөнхий дундаж		60.2%	63.1%	3.3%

Байгууллагын төрлөөр үр дүн, өмнөх жилтэй харьцуулалт



Сайн | >80 | Хангалттай | 65-79 | Сул | 50-64 | Хангалгүй | 35-49 | Муу | <35

Цахим ил тод байдлын өөрчлөлт, оноор

Төрийн байгууллагуудаас Тохируулагч агентлагийн үр дүн өнгөрсөн онтой харьцуулахад буурсан бол бусад төрлийн байгууллагын үр дүн өссөн байна. Яамдын хувьд жигдхэн сайн үнэлэгдсэн ба Барилга, хот байгуулалтын яам нийт байгууллагуудаас тэргүүлж (76.8%), хоёрт Сангийн яам (75.3%), гуравт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (74.7%) эрэмбэлэгдлээ.

Нийт хамрагдсан төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшнийг ангилан харвал 36.6% нь 'хангалттай' түвшинд бусад нь сул, хангалтгүй түвшинд үнэлэгдлээ. Харин 'сайн' буюу 80%-аас дээш түвшинд цахим ил тод байдлаа хангасан байгууллага байгаагүй.

Мэдээллийн ил тод байдлыг ихэнх тохиолдолд Шилэн дансны хуулийн хүрээнд харж, хэрэгжүүлж байгаа нь хэрэглэгчдэд хүртээмжгүй байхад нөлөөлж байна. Тиймээс байгууллага тус бүр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллага тус бүр нээлттэй мэдээллийн хүрээ, хангах үйл явц, үүрэг хариуцлага, хяналтын механизм, нөөц зэргийг тусгасан баримт бичиг, журмыг дотооддоо баталж мөрдүүлэх хэрэгтэй.

Цахим хуудасны дизайн, технологийн шийдлүүд сайжирч байгаа боловч дотор нь байршуулж буй мэдээллийг ашиглахад хялбар байлгах тал дээр сайжруулах шаардлага байсаар байна.

Ерөнхийд нь дүгнэвэл төрийн байгууллагууд мэдээллийг цахим хэлбэрээр байршуулахдаа ямар нэг холбогдох хууль тогтоомжийг хангах үүднээс байршуулж байгаа ба хэрэглэгчийн өнцгөөс тэдэнд мэдээлэл хайх, хүлээн авахад хялбар байх талаас нь бодолцон сайжруулах байдал сул байгаа тул энэ чиглэлд холбогдох албан хаагчдыг чадавхжуулах шаардлагатай байна. Тиймээс тайланд зарим сайн байж болох жишээнүүдийг дурдаж оруулсан ба тэдгээрээс өөр хоорондоо суралцаж, сайжруулах боломж бүрдэх юм. Үр дүнгийн дэлгэрэнгүй тайлантай та бүхэн www.irim.mn/web-monitoring холбоосоор хандан танилцах боломжтой.

МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА 2022 ОНД



САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

- IRIM судалгааны хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг судалгаа нь нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой. Судалгааны хүрээнд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:


- Субъектив сайн сайхан байдлыг нарийвчлан хэмжих
- Нийгмийн суурь үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийх
- Судалгааны үр дүнг шийдвэр гарагчид болон гадаад, дотоодын судлаачдад танилцуулах



2022 6-р сар

2023 3-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэнгийн бие даасан бүтээгдэхүүн болох "Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа"-г 6 дахь жилдээ хийж байна. Уг судалгаа нь нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Судалгааны хүрээнд жил бүр нийгмийн ялгаатай бүлгүүдийг судалгааны зорилтот түүврээр сонгон авч тухайн бүлгийн нийгмийн сайн сайхан байдлыг шинжлэх ухааны арга, аргачлалаар цуглуулсан баримт нотолгоонд суурилан тайлбарлахыг зорьдог билээ. Уг судалгаа нь өнгөрсөн хугацаанд дараах онцлогуудыг тусган хийгдэж байв. Үүнд:

- Анх судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2016-2019 оны хооронд жил бүр өөр өөр цаг хугацаа, цаг үеийн ялгаатай мөчлөгүүдийн харгалзан цуглуулж, энгийн үе болон баярын үеэр цуглуулсан үеийн гэх мэт ялгаатай үеүдэд ямар ялгаатай өөрчлөлтүүд гарч байгаа талаар харьцуулж байв.

- 2020 онд "Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал" сэдэвчилсэн судалгаа
- 2021 онд COVID-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан "Эмч эмнэлгийн байгууллагын ажилчдын сайн сайхан байдал" сэдэвчилсэн судалгааны ажил гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

2022 онд "Монгол дахь уур амьсгалын өөрчлөлт болон сайн сайхан байдлын талаарх судалгаа"-г нийт 13 аймаг, 8 дүүргээс нийт 2800 түүвэртэйгээр мэдээлэл цуглуулсан.

Нийгмийн сайн сайхан байдлыг илэрхийлэх үндсэн асуултуудыг 0-10 хүртэлх 11 сонголт бүхий Кантрил (Cantril, 1965)-ын шкалыг ашиглан, үр дүнг эдгээрийн дунджаар илэрхийлдэг.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбогдох сэдвээр хийгдэж буй сайн сайхан байдлын судалгааны үр дүнг нэгтгэн, тайланг 2023 онд гаргахаар төлөвлөж байна.



Байгууллагын дотоод нөөцөд түшиглэн гүйцэтгэж буй нийгмийн сайн сайхан байдлын судалгааны үр дүнг дотооддоо болон олон улсад хуваалцах, арга зүй, индексийг сайжруулах зорилгоор 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- 22 жилийн дараа зохион байгуулж буй “Социологийн симпозиум VI”-д IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх Ц.Батсугар оролцож, “Монголын нийгмийн нэгдэл нягтрал” сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.
- Мөн манай судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбатын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион

байгуулагдаж 2022 оны Жилийн хүлээн авалтын гол сэдвээр онцолж, Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан “Сорилттой цаг үеийн Монголын нийгмийн сайн сайхан байдал ба эмзэг байдал: IRIM-ийн сүүлийн судалгаануудад суурилсан ажиглалт” сэдвийн дор илтгэл танилцууллаа.

- Азийн сайн сайхан байдлын консорциумаас хэрэгжүүлж буй “Building Proactive Resilience in Asian Developing Countries Making Good Use of Social Capital” хамтарсан төслийн хүрээнд 2022 оны 8 сард IRIM судалгааны хүрээлэнгээс 3 судлаач Залуу судлаачдыг дэмжих, хамтарсан төсөл хэрэгжүүлэх Япон улсад зохион байгуулагдсан хуралд оролцсон билээ. Уг төслийн хүрээнд 2023 оны 02 сард зохион байгуулагдсан симпозиумд IRIM судалгааны хүрээлэнгийн удирдлагын төлөөлөл мөн оролцсон. Уг төслийн хүрээнд 2023-2024 онд “Монгол Улсын агаарын бохирдлын үед сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхэдтэй эхчүүдийн нийгмийн сайн сайхан байдал” сэдвээр photovoice аргаар судалгааны ажил гүйцэтгэхээр ажиллаж байна.

EARLY-CAREER RESEARCHERS WORKSHOP 2022

“Building Proactive Resilience in Asian Developing Countries Making Good Use of Social Capital” (2022-2024)



IRIM's team members



Group work with researchers from the Philippines and Vietnam



All participants of the workshop

August 23-25, 2022

Ikuta Campus, Senshu University

ЗАСАГЛАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ИРГЭНИЙ ОРОН ЗАЙН ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ: ЦАР ТАХЛЫН СУРГАМЖ

ICNL INTERNATIONAL CENTER FOR NOT-FOR-PROFIT LAW



ЗАХИАЛАГЧ

- Ашгийн Төлөө Бус Хуулийн Олон Улсын Төв (ICNL)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь Монгол Улсын Засгийн газраас COVID-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн шийдвэр, арга хэмжээг дүгнэх, Монгол Улсын хэмжээнд цар тахлын засаглалтай холбоотой бодлого, шийдвэр, түүний иргэний нийгмийн орон зайд үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох явдал юм. Судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилтууд нь:

- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед төрөөс хэрэгжүүлсэн иргэний орон зайд тодорхой хэмжээний үр дагавартай хууль, бодлого, бусад шийдвэрийг тодорхойлж, тэдгээрийн иргэний орон зайд үзүүлэх нөлөөллийг үнэлэх,
- Цар тахлын засаглалын сөрөг нөлөөг даван туулах, дасан зохицох, иргэний орон зайг хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврыг бууруулах чиглэлд төр засаг болон иргэний нийгмийн зүгээс авч хэрэгжүүлсэн сайн туршлага, сургамжийг кейс судалгааны үндсэн дээр тодорхойлох,
- Иргэний орон зайд хор хөнөөлтэй, сөрөг нөлөө өндөртэй хууль, бодлого, шийдвэрүүдийг тодорхойлж, тэдгээрт чиглэсэн сөрөг үр дагаврыг бууруулах, зохицуулалтын орчныг сайжруулах талаар стратеги, бодлогын зөвлөмжүүдийг боловсруулж холбогдох талуудад хүргэх зэрэг болно.



2022

7-р сар

2022

12-р сар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

COVID-19 цар тахлын улмаас дэлхийн улс орнууд эрүүл мэндийн төдийгүй засаглал, нийгэм, эдийн засгийн олон бэрхшээлтэй асуудлуудтай тулгарсан. Хэдийгээр 2022 онд хүн төрөлхтөн цар тахлын аюулыг даван туулж, нийгмийн эрүүл мэндийн эрсдэл буурч байгаа ч, эдийн засгийн, засаглалын болон нийгмийн зарим сөрөг үр дагавартай урт хугацаанд тэмцэх шаардлага үүсэж байна.

Цар тахал, түүнээс улбаатай хорио цээр зэрэг хариу арга хэмжээний хүрээнд сайн засаглалын жишиг туршлагаас ухрах, хүний эрхийн зөрчил, хязгаарлалтуудыг түгээмэл хэрэгжүүлэх болсон нь иргэний эрх, иргэний орон зай, иргэний нийгмийн төлөв байдал, цаашдын хөгжилд хүчтэй нөлөө үзүүлэхээр байна.

Монгол Улсын хувьд COVID-19 цар тахлын эдийн засгийн үр дагавартай холбоотой болон хүний тодорхой эрхүүд нь цар тахал, түүний хариу арга хэмжээнд хэрхэн өртсөн талаар сэдэвчилсэн судалгаа, шинжилгээ багагүй хийгджээ.

Цар тахалтай холбоотой засаглал хийгээд иргэний орон зайд гарсан сөрөг үр дагаврыг арилгах, үүнийг цар тахлын өмнөх түвшинд хүргэн сэргээхийн тулд цар тахлын үеийн засаглалын богино болон урт хугацааны үр дагавар, сургамж, цаашид иргэний орон зайг тэлэхэд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний цогц үнэлгээ, шинжилгээ хийх шаардлагатай байна.

Иймд, МУЗГ, төрийн бусад байгууллагаас COVID-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэр, арга хэмжээ, бүхэлдээ цар тахлын үеийн засаглалын Монголын

иргэний нийгэмд үзүүлсэн нөлөөг тодорхойлох зорилгоор Ашгийн Төлөө Бус Олон Улсын Төвийн тэтгэлгээр энэхүү судалгааг гүйцэтгэв.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаанд CIVICUS, Нээлттэй Засаглалын Түншлэл, Ашгийн Төлөө Бус Хуулийн Олон Улсын Төв, ОКФСМ-ын Иргэний орон зайн мониторингийн арга зүй, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Иргэний орон зайн хяналтын арга зүй гэх мэт тогтвортой хэрэгжиж буй судалгаа, үнэлгээний аргачлалуудыг харьцуулах замаар шинжилгээний хүрээг боловсруулсан.

Монгол Улс нь COVID-19 анх тархсан БНХАУ-ын хөрш орон болохын хувьд халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрт буюу анх 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, холбогдох хууль, шийдвэрүүдийг баталсан. Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 02 дугаар 12-ны өдөр 62 дугаар тогтоол гарган "Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт" шилжсэнээс 2022 оны 2 дугаар сарын 14-нд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлыг түвшнийг цуцлах хүртэл 2 жилийн хугацаанд авч хэрэгжүүлсэн шийдвэрүүдийг хамруулан үнэлэв.

Судалгаа нь дээр дурдсан хугацаанд төрөөс баталж хэрэгжүүлсэн, хууль, бодлого, шийдвэрийг хамруулсан бөгөөд нийт 1312 шийдвэрийг тойм үнэлж, цар тахал, түүний үр дагавартай тэмцэх арга хэмжээний хүрээнд батлагдсан шийдвэрүүдийг түүвэрлэн үнэллээ. Эдгээрээс цар тахлын хариу арга хэмжээнд хамаарах 286 шийдвэр байгаагийн 235 нь шууд хамааралтай байна.





Үүнээс иргэний орон зайд хамаарах 74 эрх зүйн акт батлагдсанаас 63 нь цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд гарсан шийдвэр байна. Мөн оролцогч талуудын 16 ярилцлага болон холбогдох тайлан мэдээллүүдийг ашиглав. Шинжилгээний хүрээ нь:

- (i) иргэний орон зай
- (ii) иргэний нийгмийн үйл ажиллагааны орчин гэсэн хоёр бүрэлдэхүүн асуудлыг хамарч байгаа ч судалгааны хүрээнд цар тахал, түүний хариу арга хэмжээний иргэний орон зайд нөлөөлөхтэй холбоотой бусад асуудлыг товч хөндөхийг зорьсон.

ГОЛ ҮР ДҮН

Цар тахлын хариу арга хэмжээнд хамаарах шийдвэрүүдийн 15.1% нь иргэний эрхийн асуудлыг, 20.2% нь ТББ-ын үйл ажиллагааны орчныг хөндсөн, үлдсэн хувь нь бусад хүний эрхийн асуудлыг хөндсөн байгаа нь цар тахлын хариу арга хэмжээ нь хүний эрх болон иргэний үндсэн эрхийн асуудлыг өргөн хүрээнд хамарсан, тодорхой үр нөлөөтэй байсныг илтгэнэ. Цар тахлын үеийн засаглалд дараах 3 гол эрх зүйн баримт бичгүүд мөрдөгдөж байсан ч олон удаа нэмэлт, өөрчлөлтүүд орж байжээ.

Нэмэлт өөрчлөлт оруулсан тоо

- 10 "Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт" шилжих тухай МУЗГ 62-р тогтоол 
- 9 Гамшгаас хамгаалах тухай хууль
- 8 "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль 

COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хууль нь Монгол Улсад цар тахалтай үеийн засаглалын эрх зүйн үндэс болсон. COVID-19-ээс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсан нь сайн туршлага гэж олон хүн үзэж байгаа ч цаашдын бодлого, эрх зүйн актууд нь хүний эрхийг хамгаалах зарчим, сайн туршлагад тун хангалтгүй нийцүүлсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) болон бусад олон байгууллагууд нь тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний

үр дүнд хүний эрх, тэр дундаа үндсэн эрх, эрх чөлөө өргөн хүрээтэй зөрчигдөж байгааг тайлангууддаа нотолж байна.

Хорио болон урьдчилан сэргийлэх бусад бодлогуудын үндэс болсон зарим эрх зүйн актууд хууль тогтоох үйл явцуудын шалгууруудыг хангаагүй, хууль дээдлэх ёсыг ноцтой алдагдуулсныг харуулсан. Мөн Засгийн газрын эрх мэдлийг их хэмжээгээр нэмэгдүүлж, хяналт, тэнцвэрийг гажуудуулж, сайн засаглалын үйл ажиллагаа хурдацтай буурч байна. Тухайлбал, төсвийн ил тод байдал, хариуцлага алдагдаж нийт 13.6 их наяд төгрөгийн төсвийг зарцуулсан болохыг үндэсний аудитын шалгалтаар тогтоосон.

Иргэний орон зай: Хүний эрхийг хязгаарлахдаа тодорхой шалгуур зарчимд нийцүүлэн хязгаарлалтыг тогтоох ёстой ч шаардлагагүй өргөн хүрээний хязгаарлалтуудыг авч хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Тухайлбал, дотоодод халдвар тархаагүй үед хөл хорио тогтоож, үүнээс үүдэлтэй гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх, тэдний тусламж авах боломжийг хязгаарлагдсан, 21 хоногийн тусгаарлалтын арга хэмжээ авсан зэргийг нэрлэж болно.

COVID-19 халдварын тархалттай холбоотойгоор Улсын Онцгой Комисс (УОК)-ын даргын тогтоолоор баталсан түр журмаар жагсаал, цуглааныг зохицуулах эрх зүйн актууд нь иргэний эрхийг зөвхөн хуулиар хязгаарлана гэсэнтэй зөрчилдөж, жагсаал цуглааныг хориглох, хүчээр тараах, үндэслэлгүйгээр зөрчлийн болон бусад арга хэмжээ авах гэх мэтээр хүний эрхийн зөрчил түгээмэл гарчээ. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн 55 (иргэний эрхийн зөрчлийн 24%) зөрчил илэрснийг Глоб Интернэшнл Төв бүртгэжээ. (Глоб Интернэшнл Төв, 2022)

Үүнээс гадна иргэдийн мэдэх эрхийг хязгаарласан гол шийдвэр нь Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, "үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, ухуулан таниулах үүрэг бүхий" түр хороог 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр МУЗГ-ын 29 дүгээр тогтоолоор байгуулсан. Гэвч энэ нь нэг эх сурвалжаас мэдээлэл авах нь хөл хорионы улмаас олон талын байр суурийг хүргэх, олон эх сурвалжаас мэдээллийг баталгаажуулах боломж хумигдаж, хэт ерөнхий, мэдэгдлийн

шинжтэй, анхаарал татсан асуудлын талаар булзааруулсан, мэдээллийн зөрүүтэй байдлыг нягтлахад хүндрэлтэй, зарим талаар төрийн байгууллагууд уялдаа холбоогүй зөрүүтэй хариулт өгч иргэдийг төөрөгдүүлэх явдлууд гарсан ба энэ талаар Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс мэдэгдэл гаргаж байв.

Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хувьд *“Гамшгаас хамгаалах тухай”, “COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хууль”, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд тусгагдсан шийтгэл оногдуулах тухай хууль тогтоомжид заасан “худал мэдээлэл” тархахтай тэмцэх, гэх мэт дүрэм журмуудын улмаас ихээхэн аюул заналхийлж байсан.*

Эдгээр заалтууд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг маш ихээр хэлмэгдүүлсэн гэдгийг олон төрлийн эх сурвалжууд хүлээн зөвшөөрсөн. Энэ нь сэтгүүлчдэд төдийгүй энгийн хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тэр дундаа нийгмийн сүлжээн дэх хувийн орон зайд ч нөлөөлсөн. 2020 онд *“худал мэдээлэл тараасан”* 1790 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Энэ тоо 2021 онд 1962 болж өсөж, *Эрүүгийн хуулийн “Худал мэдээлэл тараасан”* гэсэн зүйл ангиар 2021 онд 283 гомдол, мэдээлэл иржээ. Хуулийн хэрэгжилт ойлгомжгүй, хууль дээдлэх ёс муу, хуулийн нэг талыг барьсан үйл ажиллагаанаас үүдэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн тоо нэмэгдсэн.

Үндсэн эрхийг зөрчих явдал нэмэгдэж байгаа үеүдэд, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг *Эрүүгийн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн болон COVID-19 цар тахлын эдийн засгийн нөлөөлөл нь үндсэн эрхийг хязгаарласан шийдвэрт тавигдах хууль эрх зүйн шаардлагыг* тодорхойлсон боловч хүмүүс хамгаалагдах эрхээ хэрэгжүүлж чадаагүй.

Энэ мэт үзэл бодол, үг хэлэх эрх чөлөөгөө эдэлсний төлөө, засгийн газар, цагдаагийн байгууллагаар айлган сүрдүүлэх, цагдан хорих, байцаах зэргээр зөрчлүүд гарч байв. Гэвч ийм хуулийн дэмжлэг болон шүүхэд хандсан тохиолдол байдаг ч иргэд хангалттай энэ талын мэдлэг, ойлголтгүйгээс хууль зүйн зөвлөгөө, дэмжлэггүй үлдэх тохиолдол цөөнгүй гарч байна.

Иргэний нийгмийн үйл ажиллагааны орчин: Монгол дахь төрийн бус байгууллагууд (ТББ) нь харилцан адилгүй хэлбэр, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, чадавх, нөөц бололцоотой байдгаас цар тахлын үеийн хөл хорио, бусад гамшгаас хамгаалах арга хэмжээ харилцан адилгүй түвшинд нөлөөлснийг судалгааны үр дүн харуулсан.

COVID-19-ын хууль болон цар тахлын үед батлагдсан бусад эрх зүйн актад ТББ-ын үйл ажиллагааны орчныг тусгайлан зохицуулсан заалт тусгагдаагүй. Үндсэндээ хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь татвар, нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгжийг татвар, торгууль, алдангиас чөлөөлөх, цахилгаан, ус, дулааны төлбөрөөс чөлөөлөх гэсэн зохицуулалтуудаар хязгаарлагдаж байв. Зарим салбарт хөнгөлөлттэй зээл гэх мэт бусад арга хэмжээ хэрэгжсэн ч ТББ-уудад тусдаа дэмжлэгийн арга хэмжээ байхгүй. Ихэнх ТББ-ууд нь татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, өөрсдийн байргүй зэрэг нь ТББ-уудад дорвитой дэмжлэг болж чадаагүй ч зарим олон хүн ажиллуулж буй томоохон ТББ-уудад дорвитой дэмжлэг болох боломжтой байв.

Цар тахлын үед ТББ-уудад санхүүгийн болон үйл ажиллагаанд тодорхой эрсдэлүүд тулгарчээ. Учир нь 2021 оны судалгаагаар ТББ-уудын 84% нь санхүүгийн эрсдэлээс хамгаалсан хуримтлалгүй, (О.Саранчулуун, 2021) байгаа нь цар тахлын сөрөг нөлөөнд эмзэг байгааг илтгэнэ. Мөн хорио цээрийн арга хэмжээ нь нийгмийн халамж, нийгмийн хамгааллын чиглэлд үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд хөл хорионы үед зорилтот бүлэг, хохирогчдод хүрч ажиллахад хүндрэл учирч байсан, ТББ-уудын санхүүжилт буурсан хойшилсон зэрэг хүндрэлүүд үүссэн байна. Үүнээс гадна ТББ-ын үйл ажиллагаанд нийтлэг гарсан асуудал нь төрийн байгууллагатай харилцах, мэдээлэл авах, хамтран ажиллах чиглэлд хүндрэл үүссэн байна. Цар тахлын үед мэдээлэл авах эрх, иргэний оролцоо буурснаас ТББ-ууд үр дүнтэй үйл ажиллагаа явуулах, төрийн шийдвэр, үйл ажиллагаанд оролцоход бэрхшээл учруулж байжээ.

Судалгааны үр дүн болон бодлогын хураангуй IRIM судалгааны хүрээлэн холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, судлаачид зэрэг талуудад 2022 оны 12 сарын 7-ны өдөр танилцуулсан. Судалгааны товч үр дүнг *цахим хуудас*-наас авах боломжтой.

ТӨРИЙН БОДЛОГО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА 2022



САНХҮҮЖҮҮЛЭГЧ

- Швейцарын Хөгжлийн Агентлаг (ШХА),
- Нийгмийн Хариуцлагын төлөөх Дэлхий Нийтийн Түншлэл (НХДНТ)

ЗАХИАЛАГЧ

- Дэлхийн банк группийн “Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төсөл
- Засгийн газрын Хэрэг эрхлэх Газар

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгаа нь төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, төрийн үйлчилгээ иргэдэд хэр чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, түргэн шуурхай хүрч байгаа талаар иргэдийн санаа бодлыг тодруулах зорилготой. Энэ хүрээнд судалгаанд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:


- Аймаг, нийслэл, сум дүүрэг бүрд “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу салбарын бодлого, хэрэгжилтийн талаар иргэдээс санал, асуулгыг авах,
- Үр дүнг 21 аймаг, 16 салбар бүрээр харьцуулан, дүгнэлт, зөвлөмж боловсруулах.



2022 11-р сар

2023 2-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, иргэдэд хүргэдэг үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, улмаар үнэлгээний үр дүнд үндэслэн төрийн үйлчилгээг сайжруулах, цаашид бодлого, үйл ажиллагаагаа тодорхойлох зорилгоор төрөөс тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал,

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-ын даргын 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралт - "Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж" (2017 он) баталсан.
- Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны даргын А/66 тоот тушаал-"Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны түүврийн арга зүй" (2019 онд) баталсан тогтоол, шийдвэрийг дурдаж болно.

Эдгээр баримт бичгүүд батлагдахаас өмнө төрийн байгууллагууд өөр өөрсдийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулдаг байсан нь арга зүйн хувьд ялгаатай, хооронд нь харьцуулах боломж бага, үйл ажиллагаандаа тусгах байдал сул байв. Харин

ЗГХЭГ нь Дэлхийн банкны "Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" (МУНЭХБ) төслийн дэмжлэгтэйгээр "Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа"-ны арга зүйг боловсруулж, төрийн байгууллагын үнэлгээг орон даяар нэгдсэн байдлаар зохион байгуулах болсон нь дээрх байдлыг шийдэхэд нэг чухал алхам болсон юм. Уг судалгааг 2019 онд анх удаа орон даяар 21 аймаг, 291 сумаас нийт 13,860 иргэнийг хамруулан мэргэжлийн судалгааны 4 байгууллагаар гүйцэтгүүлж байсны нэг нь IRIM судалгааны хүрээлэн байсан билээ. Харин хоёр дахь удаагийн энэхүү судалгааг IRIM судалгааны хүрээлэн дангаар гүйцэтгэхээр шалгарч, 21 аймаг, 9 дүүргээс нийт 10,111 иргэний түүвэртэйгээр нэг сар гаруй хугацаанд мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэсэн нь манай байгууллагын богино хугацаанд өргөн хүрээнд мэдээлэл цуглуулах туршлагыг нэмэгдүүлсэн томоохон төслийн нэг болж байгаагаараа онцлог юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН


Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашигласан. Тоон судалгааны асуумжийг 2017 онд батлагдсан "Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж"-ийг баримтлан холбогдох сайжруулалтуудыг хийж ашигласан бол фокус бүлгийн ярилцлагын удирдамжийг IRIM судалгааны хүрээлэнгийн 2019 онд боловсруулсан арга зүйгээр аймаг, дүүрэг бүрд зохион байгуулсан.

Мөн энэ удаагийн судалгаа нь өмнөх онуудтай харьцуулахад үнэлгээнд хамруулах салбар, чиг үүргийн тоо нэмэгдсэн, цаг үеийн байдалтай уялдуулан шалгуур асуултуудыг шинэчилж, нэмэгдүүлсэн, хүний эрхийн холбогдолтой бүлэг асуултууд нэмсэн зэрэг онцлог талуудтай.

Судалгааны түүврийн аргачлалыг ҮСХ-ны "Төрийн бодлого үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны түүврийн арга зүй" (2019)-г баримтлан ажилласан.

НИЙТ ТҮҮВЭР

Асуумж судалгаанд 21 аймгийн 63 сум (1 аймгаас 3 сум) болон нийслэлийн 9 дүүргийг хамруулан нийт 10,111 иргэнээс мэдээлэл цуглуулсан. Судалгаанд оролцогчдын гуравны нэгийг хөдөө, орон нутагт амьдардаг иргэд эзэлж байгаа бөгөөд Улаанбаатар хотоос 2061 (20.4%)-ийг, үлдсэн 8050 (79.6%) нь орон нутгаас хамрагдав.



Үнэлгээний үр дүнг чанарын мэдээллээр баяжуулах зорилгоор нийт 21 аймаг, 9 дүүрэг бүрд нийт 30 удаагийн фокус бүлгийн ярилцлага хийж тодруулав.

Мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 11 сарын 17-оос 12 сарын 23-ны хүртэл 33 хоногийн хугацаанд зохион байгуулав. Үр дүнг үнэлүүлэхдээ 1-5 онооны хэмжүүр ашигласан бөгөөд цуглуулсан үр дүнг үйл ажиллагааны салбар, чиг үүрэг болон аймгаар харьцуулан, эрэмбэлж, холбогдох дүгнэлт, санал зөвлөмжийг боловсруулан хүлээлгэн өгсөн.

ГОЛ ҮР ДҮН

Судалгааны ажил нь ерөнхий 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд, төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн улсын хэмжээнд гарсан үр дүнгүүдийг төрийн 16 салбар, чиг үүргийн үнэлгээ болон аймаг тус бүрээр ангилан харуулж, тэдгээрийн талаарх хэлэлцүүлэг, харьцуулсан мэдээллийг багтаасан. Төрийн үйлчилгээний сэтгэл ханамж 3.12 гэсэн ерөнхий дундажтай байна.


Төрийн 16 салбар, чиг үүргийн үр дүнгүүд

Салбарын үзүүлэлтийг 2019 онд 11 салбараар үнэлж байсан бол 2022 онд шинээр 5 салбарын үйл ажиллагааг нэмж, нийт 16 салбар үзүүлэлтээр үнэлсэн. Энэ үр дүнг 2019 онтой харьцуулах боломжтой 11 салбарын тухайд 7 салбарын үзүүлэлт бага зэрэг буурч, 4 салбарын үзүүлэлт өсжээ. Гэвч шинээр нэмэгдсэн салбаруудыг иргэд эергээр хүлээн авч, үйл ажиллагааг ерөнхий дунджаас дээш түвшинд үнэлсэн байна.

Ялангуяа төрийн цахим үйлчилгээнд, тухайлан иргэд E-Mongolia үйлчилгээнд онцлон сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн. Боловсрол, шинжлэх ухааны салбарын өсөлт өмнөх үеэс мэдэгдэхүйц өсжээ. Үүний гол шалтгаан нь COVID-19 цар тахлын үед цахим хичээлийн агуулга, үр дүн сайн байсан, үүнд Боловсролын яам болон аймгийн холбогдох байгууллагууд боловсролыг нэмэгдүүлэх, хоцрогдлыг арилгах арга хэмжээнүүд авсан, ЕБС-ууд сэтгэл зүйцтэй болсон, орон нутагт хувийн сургууль болон сургалтын төвүүд нэмэгдэж хүүхдийн хөгжих боломж нэмэгдсэн зэргийг дурдаж байна. Мөн зам тээвэр, дэд бүтцийн салбарын үзүүлэлтүүд 2019 онтой харьцуулахад өссөн ба хатуу хучилттай замууд, тэмдэг, тэмдэглэгээ нэмэгдсэн болон барилга байгууламж шинээр баригдаж, төвийн шугамд холбох үйл ажиллагаа орон нутгуудад хийгдэж байгаад иргэд сэтгэл ханамжтай байна.

Харин байгаль орчны салбарын үнэлгээ хамгийн бага байна. Уул уурхайн салбарын төрийн үйлчилгээнд иргэд хамгийн бага сэтгэл ханамжтай байгаа бөгөөд уул уурхайн нөхөн сэргээлт хангалтгүй, төрөөс нөхөн сэргээлтийн ажлуудад зарцуулах төсөв хөрөнгийн зарцуулалтыг үр дүнтэй болгох, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүний дараа эрүүл орчны асуудал бага үнэлгээтэй байгаа ба агаарын бохирдол,


хүнсний аюулгүй байдал, зам тээврийн осол зэрэг асуудлуудад иргэд санаа зовж байна. Мөн хог хаягдлын асуудал нийт иргэдийн дунд шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоонд зүй ёсоор орж байгаа ба төрөөс хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэдийн хог хаягдлын талаарх мэдлэг ойлголт, дадал хэвшлийг дээшлүүлэх ажлуудыг зохион байгуулах хэрэгтэй гэжээ.



Төрийн 16 салбар (чиг үүрэг)-ын иргэдийн сэтгэл ханамжийн үр дүн, дундаж оноо (1-5)

Аймаг/ нийслэлийн үнэлгээ

Аймаг, нийслэлээс 15 нь улсын дунджаас дээгүүр үнэлэгдэж бусад нь дунджаас доогуур үр дүнг үзүүлсэн байна. Хэнтий аймгийн хувьд төрийн үйлчилгээний салбар, чиг үүргээс үл хамааран ихэнх үзүүлэлтэд харьцангуй өндөр сэтгэл ханамжтай байна. Улаанбаатар хотын иргэд төрийн үйлчилгээнд хамгийн бага сэтгэл ханамжтай байна. Байршлаас шалтгаалж иргэдийн үнэлгээнд ялгаа байгаа эсэхэд статистик тест хийж үзэхэд төвлөрсөн хот суурин газарт амьдардаг иргэдийн сэтгэл ханамж хөдөө, баг, суманд амьдардаг иргэдээс мэдэгдэхүйц бага болох нь ажиглагдлаа.



Аймаг тус бүрийн иргэдийн сэтгэл ханамжийн үр дүн, дундаж оноо

Аймаг, нийслэлийн үнэлгээг гаргахдаа тухайн орон нутагт хамгийн сайн хэрэгжсэн онцлох ажлуудыг тодруулж, мөн цаашид нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг тодруулан гаргаж ирсэн.

Ерөнхийд нь тоймлон дүгнэвэл улсын болон орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн ажил засаг захиргааны бүх түвшиндээ тодорхой хэмжээнд хангагдсан байна. Харин тэдгээрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үр дүнг тооцох, үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо хангалттай бус гэж үзэж байна. Шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажилд иргэдийн оролцоо хангалтгүй байдгаас төр, олон нийтийн хооронд үүссэн орон зайд мэдээлэл солилцооны дутмаг байдал бий болж иргэдийн сэтгэл ханамж дундуур байх шалтгаан болж байна. Мөн төрийн албанд улс төрийн нөлөөлөл их байдгаас төрийн үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж, мэдлэг чадвартай, ёс зүйтэй, мэргэжилтэй хүний нөөцийн дутагдалд орсон, харилцааны соёл, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрддөггүй, чадваргүй төрийн албан хаагчид төрийн албаны бүх шатанд байгаа нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжид иргэд сэтгэл дундуур байх шалтгаан болж байна.

“ЗАЛУУЧУУДЫН ДУУ ХООЛОЙ” СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Монголын Үндэсний Комисс

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгаа нь 16-24 насны залуучуудын тодорхойлж буй Монголын болон дэлхийн хэмжээний нийгмийн асуудал, Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын талаарх үзэл бодлыг тодорхойлох зорилготой. Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд IRIM судалгааны хүрээлэн судалгааны арга зүйн болон үр дүнг гаргахад мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажиллав.



2022 7-р сар

2022 10-р сар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2015 оны 9-р сард НҮБ-ын гишүүн орнууд “Тогтвортой Хөгжил 2030” хөтөлбөрийг баталж, үүний хүрээнд 2030 он гэхэд 17 зорилго, 169 зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд өөрт тулгарсан саад бэрхшээлийг даван туулж, ирээдүйд гарч болох эрсдэлээс сэргийлэх талаар хамтран ажиллаж байна. Энэхүү тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд залуучууд идэвхтэй хувь нэмэр оруулж, Тогтвортой Хөгжлийн Зорилт (ТХЗ)-г дагаж мөрдөх, хянах үйл явцад оролцсоор ирсэн бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш ТХЗ-ын хэрэгжилтэд залуучуудын оролцоо чухал хэмээн хэлсэн байдаг¹. 2021 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 45.5%-ийг 24 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж буй харьцангуй залуу насны бүтэцтэй улс орны хувьд залуучуудын нийгэм, улс төрийн идэвх оролцоог сайжруулах, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй юм. Үүний тулд ЮНЕСКО-ын Монголын үндэсний комиссын дэмжлэгтэйгээр залуус өөрсдөө “Залуучуудад юу хэрэгтэй байна вэ?”, “Залуучууд ямар бэрхшээлтэй тулгардаг вэ?”, “Залуучуудад ямар шийдэл байна вэ?” зэрэг асуултад үнэн бодитой хариулт олох нь зорилгоор уг судалгааг хийх болсон юм.

Уг төслийн хүрээнд ЮНЕСКО-ын Монголын Үндэсний Комисс болон НҮБЗЗХ-ны зүгээс судалгааны ажлыг хариуцан гүйцэтгэх залуу судлаачдыг сонгон шалгаруулж, IRIM судалгааны хүрээлэнгийн зүгээс эдгээр залуу судлаачдад судалгааны талаар ойлголт, арга зүй, ёс зүй, мэдээлэл боловсруулалт, тайлан хэрхэн бичих талаар цуврал сургалтууд зохион байгуулж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.

¹ World youth report: Youth and the 2030 Agenda for Sustainable Development. (2018). Published by The United Nations New York, New York 10017 United States of America.

СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Тодорхойлон гаргасан зорилтуудыг хангахын тулд тоон арга зүй давамгайлсан, дараалсан холимог дизайныг ашиглав. Судалгааны ажлын хүрээнд тоон мэдээлэл цуглуулан, судалгаанд оролцогчдын хэв шинжийг тодруулан гаргасны дараа тоон дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн.

“Залуучуудын дуухоолой судалгаа”-г асуумжийн аргаар үндэсний түвшинд зорилтот бүлэг болох 16-24 насны 600 залуучуудыг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулсан.

ГОЛ ҮР ДҮН

Залуучуудын ТХЗ-уудын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хэрэгцээ байна. ТХЗ-уудын талаар 51.9% нь дунд, 26.2% нь муу болон маш муу мэдлэгтэй байна. Мөн ТХЗ-ууд залуучуудад чиглэсэн асуудлыг хэрхэн тусгаж өгсөн талаар мэдлэг сул байна. Гэсэн хэдий ч залуучуудын 94.2% нь ТХЗ-оор дамжуулан залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой хэмээн үзэж байгаа нь ТХЗ-д итгэл итгэл өндөр байгааг харуулж байна.

Залуучуудын хувьд дэлхий дахинд болон Монгол Улсын хэмжээнд санаа зовж буй асуудлууд нь ерөнхийдөө ижил байгаа бөгөөд дэлхий хэмжээнд “Уур амьсгалын өөрчлөлт”, Монголын хэмжээнд “Зохистой ажлын байр болон боломж”-ийг илүү чухалчилж байна.



Монголын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг илүү нарийвчилж үзвэл:

- A) Залуучуудын хувьд тэргүүлэх тулгамдсан асуудал бол **ажилгүйдэл** байна. Ажилгүйдлийг бууруулах арга замыг залуучууд ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын байрны ёс зүйг сайжруулах, ажиллахад таатай эрүүл аюулгүй орчныг бий болгох, татварын дарамтыг бууруулах, цалин хангамжийн хэмжээг нэмэгдүүлэх, ажиллах хүчний өрсөлдөх чадвар, оролцооны түвшнийг нэмэгдүүлэх хэмээн үзэж байна. Ажил эрхэлдэг залуучуудын хувьд ажлын байрны орчин нөхцөл, эрүүл таатай орчин бий болгох шаардлагатай гэдгийг онцолж байна.
- B) Залуучуудын хувьд хоёр дахь тулгамдсан асуудал бол **боловсрол болон эрүүл мэндийн тогтолцоо** чанар, хүртээмжийг сайжруулах асуудал байна. Боловсрол болон эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах арга замыг залуучууд тогтолцоог шинэчлэх, үйлчилгээг хүртээмжтэй болгох, салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг бүрдүүлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх, ажиллах таатай орчин бүрдүүлэх гэсэн бол, орон нутагт үзүүлж буй үйлчилгээний чанарт анхаарал хандуулах, салбар байгууллагуудын тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний

төлбөр бууруулах гэсэн шийдлүүдийг санал болгож байна.

- B) Залуучуудын хувьд гуравдахь тулгамдсан асуудал бол **үнийн өсөлт, татварын дарамт, цалин хангамжийн хүрэлцээ** хэмээн тодорхойлж байна. Залуучууд ойрын 10 жилийн ирээдүйгээ эерэг, сайхнаар төсөөлж, төлөвлөж байна. Тухайлбал залуучууд залуу хүн гэдгийг улс орны ирээдүй, ажиллаж хөдөлмөрлөх нас, эрч хүчтэй, хүсэл тэмүүлэлтэй, шинийг эрэлхийлэгч хүн гэсэн ухагдахуунаар тодорхойлж, судалгаанд оролцогчдын 45.7% нь ирээдүйгээ сайхан, амжилттай байна гэж харж байгаа бол 18% нь мөн адил эергээр буюу тогтвортой ажилтай, гэр бүлтэй байгаагаар төсөөлж байна.

Залуучуудын гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн их байгаа шалтгаан нь чанартай боловсрол эзэмшихэд чиглэж байна. Залуучууд өөрсдийнхөө нийгэмд оруулах хувь нэмэр, хүлээх үүргийг өндрөөр үнэлж, тодорхойлж байна. Тухайлбал залуучуудын 63.5% нь нийгэмд оруулах хувь нэмрээ их болон маш их гэж тодорхойлохын зэрэгцээ, 51.8% нь 2030 он гэхэд Монголын залуучуудын нөхцөл байдал одоогийнхтой харьцуулбал сайжирна хэмээн төлөвлөж байна.

Энэхүү судалгаа нь олон нийтэд нээлттэй тавигдсан бөгөөд судалгааны [тайлантай энэ дарж](#) танилцана уу.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

МОНГОЛ ДАХ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧ

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт (ДДНХИ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь дараах зорилтуудтай.


1. Уур амьсгалын өөрчлөлт, түүний шалтгаан, сааруулах арга замын талаарх иргэд, олон нийт, нийгмийн эмзэг бүлэг, оролцогч талуудын мэдээлэл, мэдлэгийг үнэлэх
2. Хүмүүсийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хандлага, дадлыг тодорхойлох.
3. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмж, хариу арга хэмжээ авах чадавх боломжид нь хүйсийн болон нийгэм-эдийн засгийн эмзэг байдлаас үүдэлтэй тэгш бус байдал нөлөөлж буй эсэхийг шинжлэх
4. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг шаардлагатай арга хэмжээний талаарх иргэд болон гол оролцогч талуудын хүлээлтийг тодорхойлох
5. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг авч үзэхэд хэр бэлэн байгаа талаарх гол оролцогч талуудын ойлголтыг үнэлэх
6. Хүн амын тодорхой бүлэг, оролцогч талуудад чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг зохион байгуулахад анхаарах гол хүчин зүйлсийг тодорхойлох.
7. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгарч буй сорилтод хариу өгөхийн тулд аль бүлэгт нэн тэргүүний тусламж хэрэгтэй байгааг тодорхойлох.



2022 6-р сар

2023 3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Судалгаанд хамрагдсан багууд, экологийн бүсээр

Тайлбар: Газрын зурагт Дархан-Уул, Дархан XVII; Орхон – Жаргалант IV; Баян-Өлгий – Ногооннуур – VIII; Хэнтий – Биндэр VI багуудыг харуулаагүй. Газрын зургийн эх сурвалж: www.eic.mn. Судалгаанд сонгогдсон багуудыг бор өнгөөр тэмдэглэсэн болно.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Уур амьсгалын өөрчлөлт ирэх хэдэн арван жилийн хугацаанд эрчимжих төлөвтэй байгаа бөгөөд үүний дүнд байгалийн харилцаа, хамаарал, зүй тогтолд тоо томшгүй олон нөлөө бий болохоор байна.¹ Нэн ялангуяа, Монгол оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ихсэж, цөлжилт, усны хомсдол, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөх, цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж нэмэгдэх зэрэг үзэгдэл аль хэдийн үүсээд байгаа билээ. Сүүлийн 80 жилд Монгол орны жилийн дундаж температур 2.25°C-аар нэмэгдсэн². Хүн амын бүлгүүд, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөөд зогсохгүй түүний нөлөөгөөр бий болсон

гамшиг, эрсдэлд тэсвэрлэн үлдэх, хариу арга хэмжээ авах чадвар нь хязгаарлагдмал байгаагаас үүдэн их хохирол амсаж болзошгүй байна.

2019 онд Уур Амьсгалын Өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцод тайлагнасан Монгол Улсын Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн³ зорилтод уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг бүлгийг нэн тэргүүнд хамгаалах, уур амьсгалаас үүдэлтэй эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх олон нийтийн чадавхыг нэмэгдүүлэх нь нэг зорилт болох тухай дурдсан байдаг. Гэвч, хүн ам болон эмзэг бүлгүүдийн дунд мэдлэгийг нэмэгдүүлэх, эерэг хандлага, дадал хэвшлийг бий болгох ямар боломж байгааг тодорхойлсон судалгаа Монгол Улсад дутмаг байна.

¹ Ategeka, John, and others, Behavioral science interventions within the development and environmental fields in developing countries: 2022.

² БОАЖЯ, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, 2020

³ БОАЖЯ, UNFCCC, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, 2019

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаа нь үндэсний хэмжээнд төлөөлөхүйц түүврийг бүрдүүлж, 13 аймаг болон Улаанбаатар хотын 9 дүүргээс түүвэрлэсэн 2804 оролцогчоос тоон судалгаа авсан. Мөн чанарын судалгаанд үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, ТББ-ууд, эрдэм шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээлэл болон хувийн хэвшлийн нийт 49 гол оролцогч талуудыг зорилтот бүлгээр сонгосон. Нийт 9 фокус бүлгийн хэлэлцүүлгийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, малчин, газар тариаланч, үндэстний цөөнхүүд болон уул уурхайн нөлөөллийн бүс нутаг, алслагдсан хилийн бүсийн иргэд зэрэг олон янзын төлөөллийг хамруулан зохион байгуулсан.

Судалгааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэг, мэдээллийн хэрэгцээ, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийг боловсруулах чадавч зэрэгт нийгэм, эдийн засгийн байдал нь хэрхэн нөлөөлж буйг мөн судалсан. Ингэхдээ судалгааны баг нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн эдийн засгийн гачигдал, эрүүл мэндийн асуудал, нийгмийн тусгаарлалтад өртөх эрсдэл өндөртэй хүмүүсийн шинж чанар болон тоог хэмжих эмзэг байдлын индексийг боловсруулж ашигласан.

Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, архаг өвчтэй, орлого багатай, боловсролын түвшин доогуур, шилжилт хөдөлгөөн, амьжиргаа нь уур амьсгалын өөрчлөлтөөс хамааралтай, өртөмтгий байдал зэрэг нийт 13 шинж чанарыг үндэслэн индексийг боловсруулсан. Индексийг ашиглах замаар судалгаанд оролцогчдыг “эмзэг байдал бага” болон “эмзэг байдал өндөр” гэсэн хоёр бүлэгт хуваан, түүнийгээ ашиглан харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

ГОЛ ҮР ДҮН

Ойлголт, мэдлэг, хандлага, дадал: Монголчуудын 67.3% нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар сонссон харьцангуй сайн ойлголттой байна. Гэсэн ч энэ ойлголтын талаарх мэдлэг, хандлага, дадал тааруу, зөвхөн 23.6% нь мэдлэгээ хангалттай гэж үнэлсэн. Мөн 46.6% нь сүүлийн 10 жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт нь тэдний амьдрал, амьжиргаанд нөлөөлсөн гэжээ. Иргэдийн дийлэнх нь буюу 84.0% нь уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь хүний үйл ажиллагаа гэдгийг баттай хүлээн зөвшөөрч

байна. Харин ердөө 6.8% нь уур амьсгалын өөрчлөлт бий болоход аж үйлдвэржсэн орнууд нөлөөлж байгаа, 35.9% нь Монгол Улсын иргэд өөрсдөө уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байна гэж үзжээ. Сонирхолтой нь судалгаанд оролцсон таван хүн тутмын нэг нь (22.5%) уур амьсгалын өөрчлөлт бол далдын хүч, байгаль эх шийтгэж буй дохио гэж үзэж байна.

Монголчуудын дунд уур амьсгалын өөрчлөлтийг өөрсдийн амьдарч буй газраас хол болж байгаа зүйл гэж үзэх хандлага хүчтэй бөгөөд өөрсдөд нь ойрын ирээдүйд тохиолдохгүй (67.1%) гэж үзэж байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн одоо бий болсон үр нөлөө болон цаашид тохиолдох үр нөлөөний талаарх мэдээлэл дутмаг байгаатай холбоотой.

Ихэнх хүмүүс уур амьсгалын өөрчлөлт нь цахилгаан, усны хэрэглээ, нүүрс шатаах зэрэг өдөр тутмын үйлдлээс үүдэлтэй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч, эмзэг бүлгийнхэн гэр бүлээ тэжээхийн тулд нүүрс түлж халаалтын зардлыг хэмнэх, байшингаа дулаан байлгахын тулд цахилгаан тень ашиглах, цахилгааны төлбөрөө төлөх гэх мэт эргэлзээтэй сонголтуудын улмаас өдөр тутмын дадлаа өөрчлөхөд сорилттой байдаг тухай дурджээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг, хандлага, дадал хүн ам зүйн үзүүлэлтээр ялгаатай эсэхийг авч үзвэл хүйсээс хамаарсан ялгаа харьцангуй бага хэдий ч эмэгтэйчүүд нь илүү санаа зовох хандлагатай бөгөөд нэмэлт мэдлэг, ур чадвар эзэмшихийг хүсэж байна. Насны хувьд 18-24 насны залуучууд уур амьсгалын өөрчлөлтийн талаар илүү их сонсож, уур амьсгалын өөрчлөлт болж байгаад илүү итгэж байгаа боловч тэд энэ талаар хамгийн бага санаа зовж, нэмэлт мэдлэг, ур чадвар олж авах сонирхол нь ч хамгийн бага байна. Боловсролын түвшин доогуур, орлого багатай иргэд уур амьсгалын өөрчлөлтийн тэдний амьжиргаанд нөлөөлөх нөлөөллийг ойлгохгүй байх магадлал өндөр байна. Хөдөө орон нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг илүү бага байгаагаас тэд дэлхий нийтэд болон Монголд уур амьсгалын өөрчлөлт болоогүй гэж итгэх магадлал өндөр байна. Хэдийгээр тэд байгаль орчны янз бүрийн өөрчлөлтийг илүү анзаарч, байгалийн гамшигт илүү их өртөж байсан ч, энэ нь ихэвчлэн арван жилийн мөчлөгөөр тохиолддог байгалийн үзэгдэл, өөрчлөлт гэж итгэх хандлагатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар авах арга хэмжээ: Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг хийж, хэрэгжүүлэх нь Монгол Улсын Засгийн газар, түүний дотор орон нутгийн засаг захиргаанаас ихээхэн хамаарна гэж 62.9% нь үзжээ. Нийт судалгаанд оролцогчдын дөнгөж 12.0% нь аж үйлдвэржсэн орнууд уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байна гэж үзсэн бол 6.8% нь энэхүү оролцогч талыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй гэж үзжээ. Фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс харахад, аж үйлдвэржсэн орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөлөл, түүнийг шийдвэрлэх чадавхын талаар ойлголт дутмаг байгаа нь иргэд уур амьсгалын өөрчлөлтийг зөвхөн үндэсний хэмжээнд авч үзэж шийдвэрлэх хандлагатай байгаагаас харагдаж байсан. Иргэдийн бодлоор уур амьсгалын чиглэлд Засгийн газраас авч хэрэгжүүлэх ёстой хамгийн нийтлэг дурдагдсан арга хэмжээ бол хотын оршин суугчдын үзэж байгаагаар эрчим хүч, хог хаягдал, тээврийн асуудал бол хөдөөгийн оршин суугчид мал аж ахуй, газар тариалан, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг түлхүү нэрлэжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэглээ ба харилцаа холбоо: Монголчууд уур амьсгалын өөрчлөлтийг ноцтой асуудал гэдгийг 92.7% нь ухамсарлаж, санаа зовж, цаашид хэвлэл мэдээллийн хэрэгслээр (85.1%) энэ талаар илүү их мэдээлэл авах сонирхлоо илэрхийлж байна. Иргэдийн мэдээлэл авч буй үндсэн эх сурвалж нь телевиз болон интернэт байна. Телевиз нь эмзэг бүлгийн хүмүүст мэдээллийн хамгийн хүртээмжтэй эх сурвалж нь болж байна. Иргэдийн 44.1% нь "уур амьсгалын өөрчлөлт" эсвэл "дэлхийн дулаарал"-тай холбоотой ямар нэгэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүлээн авсан бол 45.3% нь ямар ч мэдээлэл авч байгаагүй гэжээ. Олон нийтийн дунд хүртээл болсон хоёр гол эх сурвалж нь "Хүрээлэн"

байгаль орчны баримтат нэвтрүүлэг, "Ногоон шошго" нэвтрүүлэг байна.

Монгол дахь уур амьсгалын чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түгээн дэлгэрүүлж, нэвтрүүлэхтэй холбоотой оролцогч талуудын үзэл бодол: Оролцогч талуудтай хийсэн ярилцлагаас харахад, төрийн албан хаагчид, хараат бус шинжээчид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл болон тус тусын салбар дахь хариу арга хэмжээний талаар ерөнхий ойлголт, мэдлэг сайтай байна. Бүхий л оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг Засгийн газар, хариуцаж буй Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас манлайлал үзүүлэх, чиг үүргийн дагуу нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, дотоод болон гадаад оролцогч талуудыг уялдуулан зохицуулахад хүчин чармайлт гаргах хэрэгтэйг онцлон тэмдэглэв. Цаашилбал, уур амьсгалын өөрчлөлтийг авч үзэх, түүний нөлөөллийг зохицуулах, бууруулах шийдлийг олоход бүх түвшний оролцогч талуудыг оролцуулсан оролцооны хандлагыг сайжруулах шаардлагатайг онцолсон.

Монголын уур амьсгалын өөрчлөлтөд бэлэн байдлын түвшнийг 1-4 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд оролцогчид 2.6 гэж үнэлсэн. Гэвч шаардлагатай зүйлс нь хязгаарлагдмал, яаралтай сайжруулах шаардлагатай байгааг онцолсон.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд мэргэшсэн, чадварлаг хүний нөөц, шинжээч салбарын болон байгууллагын түвшинд дутмаг, нэн ялангуяа хөдөө орон нутагт хангалтгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнд тулгуурлан мэдлэг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх кампанит ажлын стратегийг боловсруулсан. Судалгааны тайлан удахгүй www.irim.mn болон <https://gaggi.org/> вэбсайтад тавигдах болно.

ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ БА НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ЗАХИАЛАГЧ

- Азийн Хөгжлийн Банк
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам

ХАМТРАГЧ

- ТоС Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо
- Хөгжлийн шийдэл ТББ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Зөвлөх үйлчилгээ нь бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн (БЖДБЭ)-ийн тойрог эдийн засаг, ногоон технологийн талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэх замаар жендерийн тэгш байдлыг дэмжих үндсэн зорилготой. Тус зөвлөх үйлчилгээ нь эмэгтэй эзэнтэй болон эмэгтэй удирдлагатай БЖДБЭ-дэд COVID-19-ийн дараах хямралаас бизнесээ сэргээж, тогтвортой ногоон сэргэлт хийхэд нь туслах зорилготой юм.



2022 11-р сар

2024 5-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол Улсад бүс нутгийн техник тусалцааны төслийг санхүүжүүлж байна.

Монгол Улсад хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээг IRIM судалгааны хүрээлэн нь Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Хөгжлийн шийдэл ТББ болон Германы Аделпи байгууллагуудтай хамтран 1.5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр шалгараад байна.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэлхий нийтээр байгалийн баялгийг үр ашигтай, хаягдал багатайгаар эдийн засгийн эргэлтэд оруулахыг чухалчилж анхнаас нь “дахин хэрэглэгдэхүйц” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, улмаар хэмнэлттэй, үр дүнтэй, ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх эдийн засгийн шинэ загварыг зорьж байна.

Байгаль орчны асуудал хурцаар тавигдах болсон энэ цаг үед хариуцлагатай бизнесийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Гэвч багагүй хугацаанд үргэлжилсэн COVID-19 цар тахлын үр нөлөө нь хувь хүн, бизнес, улс орон гэх мэт бүхий л түвшинд, бүхий л салбарт сөргөөр нөлөөлсөн. Энэхүү сөрөг нөлөөлөл бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүүтэй мэдрэгдэж, олон бизнесүүд хаагдаж, үйл ажиллагаа нь доголдсон. Энэ нөхцөл байдал нь бизнесүүдэд үйл ажиллагаагаа сэргээх, тогтвортой хөгжүүлэхэд хүндрэл учруулж байгааг олон судалгааны үр дүн харуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, COVID-19 цар тахлын үр нөлөөг багасгах чиглэлээр хөгжлийн байгууллагууд олон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж байгаагийн нэг нь энэхүү зөвлөх үйлчилгээний төсөл болж байна. Азийн хөгжлийн банк нь COVID-19 цар тахлын дараах жендерийн оролцоотой ногоон бизнесийг дэмжих чиглэлд БНХАУ болон

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Нэгдүгээрт, тойрог эдийн засгийг дэмжсэн бодлогын орчин, хууль эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, тойрог эдийн засгийг нэвтрүүлэх боломж, хүндрэл бэрхшээлийн талаар цогц үнэлгээ хийх.

Хоёрдугаарт, судалгааны үр дүнд үндэслэн зорилтот салбарын БЖДБЭ-ийн тойрог эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

Гуравдугаарт, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд суурилан үндэсний болон олон улсын түвшинд бий болсон үр дүнгийн талаарх мэдээлэл түгээх, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах юм.

ГОЛ ҮР ДҮН

Төслийн үйл явц одоогоор нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг болох суурь мэдээллүүдийг цуглуулах, үр дүнд тулгуурлан чадавх бэхжүүлэх болон дэмжлэгийг төлөвлөх шатны үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ, ОРОН НУТАГТАЙ ХАМТРАХ ХҮРЭЭНД ХИЙСЭН БОЛОН ХИЙЖ БУЙ АЖЛУУДЫН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧ

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр II

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг үнэлгээ нь Монгол дахь олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх, орон нутгийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд хийсэн ажлуудын үр нөлөө, тогтвортой байдлыг үнэлж, сайжруулах арга замуудыг тодорхойлох зорилготой.



2022 12-р сар

2023 3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



залуу үеийнхэнд мэдлэг туршлагаа шинэлэг арга замаар, мэдээлэл харилцааны хэрэгслээр хуваалцах боломж олгоход чиглэнэ. Энэхүү санаачилга нь (i) Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоог хангах ажлууд, бодлогын орчныг үнэлэх (ii) орон нутгийн нөхцөл байдалд тохирсон шинэлэг мэдээлэл харилцааны стратеги боловсруулах гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүний эхний бүрэлдэхүүн хэсэг болох үнэлгээг IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ


Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж буй, хөгжлийн тулгуур салбаруудын нэг юм. Тухайлбал, 2010-2021 оны хооронд уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 23%-ийг эзэлж байв. Түүнчлэн, энэ салбар дангаараа нийт ажиллах хүчний 3.6% орчим, улсын төсвийн 20% гаруй, экспортын 90% гаруй бүрдүүлж байна (*Баатарзориг, Галиндэв, Мэйссоннэйв, 2018*).

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) олон нийтийн оролцоонд суурилсан үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, талуудын үүрэг оролцоог илүү тодорхой болгох, иргэд санал бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байгаа нь өмнөх судалгаад үр дүнгээс олон талаар харагдаж байсан. Сүүлийн жилүүдэд хуучин тогтолцоонд тулгуурласан мэдээлэл харилцаа, олон нийттэй харилцах арга зам нь иргэдийн оролцоог хангаж, тэдний санал бодлыг тусгахад хангалттай үр дүнтэй биш болох нь харагдсан бөгөөд ингэснээр олон нийтийн итгэл суларч, салбарын нэр хүндэд нөлөөлөхөд хүрч байна.

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр II (АМЕП) -өөс санаачилсан “Эрдэс баялгийн салбарын үнэ цэнийг нэмэгдүүлэх нь” төсөл нь орон нутгийн иргэд, малчид, төрийн бус байгууллагууд,

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээний ерөнхий арга зүй нь Монгол дахь олборлох үйлдвэрлэлийн салбарт сүүлийн 5 жилийн хугацаанд хийгдсэн болон одоо хийгдэж буй олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлуудыг баримт нотолгоонд үндэслэн, нарийвчлан үнэлэхэд чиглэсэн. Ингэхдээ олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг бий болгох чиглэлд оролцогч талуудын ойлголтыг илүү сайн ойлгох үүднээс эрэл хайгуулч, харилцан зөвлөлдөх хандлагыг баримталсан.



Судалгааны анхдагч, хоёрдогч мэдээлэлд тулгуурлан олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоо, тэдэнд хүрч ажилласан ажлын үр нөлөөг үнэлэхийн тулд судлагдсан байдлыг системтэй үнэлэх, чанарын ярилцлагууд, зөрүүний шинжилгээг хийх аргуудыг ашигласан.

ГОЛ ҮР ДҮН

Уг тайланг боловсруулах үед үнэлгээний үр дүн боловсруулагдаж байгаа бөгөөд тайлан хараахан эцэслэгдээгүй болно.

“АВСТРАЛИЙН УЛААН ЗАГАЛМАЙН ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨР 2019-2024”-ИЙН ДУНД ШАТНЫ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧ

Австралийн Улаан Загалмай Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дунд шатны үнэлгээний зорилго нь:

- Австралийн Улаан Загалмайн таван жилийн хугацаатай олон улсын хөтөлбөрийн үйл явц, ахицыг үнэлэх;
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнгүүдтэй холбоотой гүнзгийрүүлсэн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн сүүлийн хоёр жил болон 2024 оноос хойших стратегид зориулсан нотолгоонд суурилсан зөвлөмжүүд боловсруулах явдал байв.




2022

9-р сар

2023

12-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Австралийн Улаан Загалмайн Олон Улсын Хөтөлбөр 2019-2024 нь дараах гурван үр дүнд хүрэх зорилттой хэрэгжиж байна. Үүнд:

Хүрэх үр дүн 1: Хүчирхэг Үндэсний Нийгэмлэг

Хүрэх үр дүн 2: Үндэсний нийгэмлэг манлайлсан үр дүнтэй гамшгийн эрсдэлийн менежмент

Хүрэх үр дүн 3: Хүмүүнлэгийн бодлого, практикт үзүүлэх нөлөө

Үүний хүрээнд Австралийн Улаан Загалмай Нийгэмлэг нь Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийг Монгол Улсын Засгийн Газарт нэмэлт хүч болж, гамшгийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээнд ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, баримт бичгийн шинжилгээний аргуудыг хослуулан ашиглав.

Үнэлгээний анхдагч мэдээлэл цуглуулалтыг МУЗН, төрийн байгууллага, иргэний нийгэм, НҮБ-ын салбар байгууллагууд, Улаан загалмайн сайн дурын идэвхтнүүд, иргэдийн төлөөлүүдийг хамруулан зохион байгуулав.

ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан оролцогч талууд МУЗН-ийг хүчирхэг, итгэл даахуйц, найдвартай

түнш гэж үзэж байв. МУЗН нь тодорхой дотоод журмууд, үр ашигтай, сахилга баттай, нээлттэй байдлыг бий болгосон, манлайлал, менежментийн хувьд олон улсын стандартаар жишиг болохуйц байгууллага гэдэг нь үнэлгээний үр дүнгээс харагдсан. Мөн улсын хэмжээнд шийдвэр гаргах түвшний гол оролцогч байж, хүмүүнлэгийн механизмуудад (кластерууд, ажлын хэсгүүд гэх мэт) идэвхтэй хамрагддаг байна.

Харин оролцогч талууд МУЗН-ийн харилцаа холбооны сувгууд, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн, сурталчилгааны ажлууд, шинэлэг бус, нэгэн хэвийн байдалд нь шүүмжлэлтэй хандаж байв. Тиймээс дараах зүйлсэд анхаарч ажиллах шаардлагатай талаар оролцогч талууд зөвлөмж, саналаа илэрхийлж байсан. Үүнд:

- Олон нийттэй харилцах харилцаагаа сайжруулах
- Тогтвортой манлайллаа хадгалах төлөвлөгөө боловсруулах
- Дунд болон анхан шатны хороодыг чадавхжуулах (хүний нөөц, материаллаг бааз)
- Дотоодоос хөрөнгө босгох, шинэ гишүүд нэмэхэд анхаарч ажиллах

Уг үнэлгээний тайлан нь Австралийн Улаан Загалмай Нийгэмлэгийн олон улсын хөтөлбөр хэрэгжиж буй бусад улс орнуудын дунд шатны үнэлгээний тайлангуудтай нэгтгэгдэж, тус хөтөлбөрийн цаашдын хэрэгжилтэд мэдээлэл, хувь нэмэр болох юм.

МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГИЙН (МУЗН) COVID-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АВСАН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧ

- Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар
Нийгэмлэгүүдийн Холбоо

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Үнэлгээ нь 2020 оны 2 сараас 2022 оны 1 сарын хооронд Монголын Улаан Загалмай Нийгэмлэг (МУЗН)-ээс цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээний явц, үр дүн, ололт амжилтыг үнэлж, цаашид хэрэгжүүлэх цар тахлын дараах нөхөн сэргээх хөтөлбөрийн үйл ажиллагааны санал, зөвлөмж боловсруулах зорилготой байв.



2022 2-р сар

2022 8-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

МУЗН нь эрүүл мэндийн салбарыг дэмжих, эмзэг бүлгийн иргэдэд туслах зорилгоор үндэсний хэмжээнд COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, Улсын Онцгой Комисс болон бусад сүлжээ байгууллагуудын гишүүний хувиар Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааг дэмжин ажилласан юм.

МУЗН-ийн COVID-19-ийн эсрэг хариу арга хэмжээний үнэлгээг дараах үндсэн 3 чиглэлд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг хэмжих зорилгоор гүйцэтгэв.

- Чиглэл 1:** Эрүүл мэнд, ус ба эрүүл ахуй;
- Чиглэл 2:** COVID-19-ийн нийгэм-эдийн засгийн үр нөлөөг бууруулах;
- Чиглэл 3:** Үндэсний нийгэмлэгийг чадавхжуулах.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

МУЗН-ийн 2020 оны 2 сараас 2022 оны 1 сарын хооронд авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээг IFRC үнэлгээний хүрээний-ийн 5 шалгуур үзүүлэлт болох (i) хамааралтай, зохистой байдал, (ii) үр ашигтай байдал, (iii) үр дүнтэй байдал, (iv) хамрах хүрээ, (v) тогтвортой, уялдаа холбоотой байдал гэсэн шалгуурын дагуу үнэллээ.

Тоон судалгаанд COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд МУЗН-ээс тусламж хүртсэн 390 үр шим хүртэгчид болон

МУЗН-ын 80 сайн дурын идэвхтнүүд, төрийн байгууллагын төлөөлөл, МУЗН-ын ажилтнууд зэрэг бусад оролцогч талуудаас 28 төлөөллийг хамруулав.

ГОЛ ҮР ДҮН

Оролцогч талуудын төлөөлөл бүгд МУЗН-ийн хариу арга хэмжээ маш үр дүнтэй байж, анхны төлөвлөгөөгөө биелүүлж чадсаныг онцолж байв.

COVID-19 цар тахлын үед МУЗН 1440 сайн дурын идэвхтнийг сурган дайчилж, өрхийн эмнэлгүүд болон Халдварт өвчин судлалын үндэсний төвд (ХӨСҮТ) ажиллуулжээ. Үүний үр дүнд COVID-19-ын халдварын 148,200 хавьтал илрүүлж, 534,250 хүн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн (WASH) үйл ажиллагаануудаас үр шим хүртэж, 118,200 хүн дархлаажуулалтад хамрагдсан байна.

МУЗН цар тахалтай холбоотой мэдээллийг сайн дурын идэвхтнүүдийн тусламжтайгаар олон төрлийн сувгуудаар дамжуулж, улс орон даяар давхардсан тоогоор нийт 2.9 сая хүнд хүргэж чадсан нь нийтийн эрүүл мэндийг дэмжих, халдварын эрсдэлийг бууруулахад чухал нөлөө үзүүлжээ. Мөн COVID-19 цар тахлын улмаас орлогоо алдсан нийт 184,380 хүнд хүнс тэжээлийн дутагдалд орох эрсдэлээс хамгаалан хүнсний багц тараасан байна. Судалгаанд оролцсон нийт 390 үр шим хүртэгчийн 91.9% нь МУЗН-ээс үзүүлсэн хүнс тэжээлийн тусламж тэдний амьжиргааг дээшлүүлж, хэрэгцээг нь бүрэн хангаж чадсан гэж хариулсан нь МУЗН COVID-19 цар тахлын үед МУЗГ-г чухал дэмжлэг үзүүлснийг илтгэж байна.

МОНГОЛ УЛСЫН УСАН ХАНГАМЖИЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ



ЗАХИАЛАГЧ

- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

- Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
- Зүүн Азийн тогтвортой байдал ХХК
- ATKINS Member of the SNC Lavalin Group
- Мон-Энержи ХХК
- Эко-Трейд ХХК

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


Энэхүү Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах төслийн ерөнхий зорилго нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банканд усалгааны нөхөн сэргээлтийн төслийг иж бүрэн үнэлж, батлах, хэрэгжүүлэх боломжийг олгох явдал юм. Ингэхдээ эдийн засаг, хүн ам зүй, үйл ажиллагаа, байгууллагын мэдээллийг цуглуулж, төслийн оролцоог харьцуулах суурь үзүүлэлтийг бий болгоно.



2022 8-p cap

2023 8-p cap

LOCATION OF IRRIGATION SYSTEMS IN MONGOLIA



Монгол Улс дахь усалтын системийн байршил

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол орны газар нутгийн зөвхөн нэг хувь нь (1.3м га) тариалангийн талбай бөгөөд 400,000 га газрыг тариалангийн нөөц болгох бололцоотой. Усны нөөцийн гол хэрэглэгч нь хөдөө аж ахуйн салбар бөгөөд ган гачиг температурын эрс тэс өөрчлөлт, хур тунадасны хэлбэлзэл, хур тунадасны улмаас газар тариалан, бэлчээрийг сүйтгэх зэрэг уур амьсгалын олон эрсдэлтэй тулгардаг. Газар тариаланд гадаргын усыг голчлон ашигладаг бөгөөд зарим усалтын системд гүний усыг ашигладаг. Орон нутгуудад усалгааны тарифыг цуглуулах систем байдаг ч одоогийн системд тарифын зохицуулалт байдаггүй.

Хөдөө аж ахуйн салбарт усны менежментийг сайжруулах, уур амьсгалд тэсвэртэй усалтын системийг хөгжүүлэх зорилгоор Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-аас 2022 оны 07 сараас эхлэн уг төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд усалтын системүүдийг

шинээр барих, шинэчлэх, сэргээн засварлах ажлыг эхлүүлэхтэй холбоотой усалтын систем бүхий 20 орчим байршлуудад гидрологи, тариф, нийгэм, байгаль орчин, хууль эрх зүйн цогц судалгааг хийж ТЭЗҮ боловсруулах ажлыг хийж гүйцэтгэх юм. Төслийн гол хэрэгжүүлэгчээр дэлхийн 175 оронд үйл ажиллагаа явуулдаг АТКИНС олон улсын байгууллага, дотоодын хамтран ажиллагчаар Зүүн Азийн Тогтвортой хөгжил (SEA), IRIM судалгааны хүрээлэн, Эко трейд, Мон-Энержи байгууллагууд хамтран ажиллаж байна. Уг төслийн хүрээнд манай байгууллагын зөвлөхүүд гидрологи, байгаль орчин, тариф, жендерийн судалгаа, дүн шинжилгээ хийхэд олон улсын зөвлөхүүдэд дэмжлэг үзүүлнэ.

ГОЛ ҮР ДҮН

Төсөл нь 2022 оны 08-р сараас хэрэгжиж байгаа бөгөөд одоогоор төслийн үр дүн гараагүй байна.

“МИНИЙ МИНИЙХ” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ КОНТЕНТЫН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧ

- Love Frankie агентлаг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) болон Development Alternatives, Inc (DAI) байгууллагаас зохион байгуулж буй “Миний Минийх” аяны хүрээнд хийгдэх ажлууд, боловсруулагдах контентын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд зорилтот бүлгийн үзэл бодол, хандлагыг тодруулах, аяны хүрээнд гарсан бүтээгдэхүүнүүдэд санал авах хэлэлцүүлгийг зорилтот бүлгийнхний дунд зохион байгуулах зорилготой.



2022 4-р сар

2022 7-р сар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Уг аяны зорилго нь Монголчуудын цахим аюулгүй байдал, онлайн үеийн аюулгүй байдал, тоон бичиг үсэг тайлагдалтын ойлголт мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд өрнүүлсэн аян бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Монгол дахь цахим аюулгүй байдлын гол тулгамдаж буй асуудлууд, цахим гэмт хэрэгтэй холбоотойгоор хувийн мэдээллийн нууцлалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх
2. Хувийн мэдээллийнхээ нууцлалыг хангах чиглэлд Монголчуудад мэдлэг олгох
3. Залуучуудыг гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, нийгмийн хүрээнд тоон бичиг үсэг тайлагдалт, цахим аюулгүй байдлын ойлголт, мэдлэгийг түгээх чиглэлд идэвхжүүлэх
4. Монголчуудыг цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, түүнээс хамгаалахад сургах
5. ТББ, хувийн хэвшил, олон нийтэд нөлөөлөгчид (influencers)-ээр дамжуулж олон нийтийн цахим аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

Аяныг ялгаатай зорилтот бүлгүүдэд чиглүүлэн хоёр үе шаттай зохион байгуулсан. Үүнд:



1-р үе шат: 16-25 насны залуучууд

2-р үе шат: 41-55 насны эцэг эх, бизнес эрхэлдэг буюу цахим санхүүгийн үйлчилгээ ашиглагч

ТӨСЛИЙН ГОЛ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэхүү нөлөөллийн аян зорилтот бүлэгтээ хэрхэн хүрч байгаа, цаашид анхаарах зүйлсийг тодруулах зорилгоор IRIM судалгааны хүрээлэн нь хэрэгжүүлэгч талд шаардлагатай мэдээллийг фокус бүлгийн аргаар цуглуулж хүлээлгэн өгсөн.

1-р үе шатны ФБЯ-ын зорилго нь дээр дурдсан эхний 4 зорилтуудыг хэрэгжүүлэхэд видео бичлэг, сурталчилгааны кампанит ажлыг 16-25 насны залуусын бүлэгт турших байдлаар хэрэгжүүлж, залуучуудад тулгуурлаж ажилласан. Мөн аяны хүрээнд хийгдсэн дараах үйл ажиллагааг үнэлэхийг оролдсон. Үүнд:

1. Видео бичлэгийн агуулга болон уран бүтээлчийн кампанит ажлын гол мессеж нь тодорхой, үр дүнтэйгээр хүрч чадсан эсэхийг үнэлэх
2. Нөлөөллийн ажлын хүрээнд зохион байгуулсан Live Music Session уралдааны идэвхжүүлэлт, үзэгчдийн хандалтыг нэмэгдүүлэхэд зурагт хуудаснууд нь нөлөө үзүүлсэн эсэхийг үнэлүүлсэн.



Эхний үе шатанд 4 удаагийн ФБЯ-ийг зохион байгуулсан бөгөөд 16-21 насны болон 22-25 насны эрэгтэй, эмэгтэй оролцогчдыг түүвэрлэсэн.

Харин 2-р үе шатны ФБЯ-ын зорилго нь (i) кампанит ажлын агуулгатай танилцахаас өмнөх болон дараах онлайн аюулгүй байдал, нууц үгийн хамгаалалт, онлайн санхүүгийн залилангийн талаарх мэдлэгийн өөрчлөлтийг үнэлэх, (ii) өдөр тутмын амьдралын хэрэглээнд зориулсан кампанит ажлаар дамжуулан онлайн аюулгүй байдлын дадал зуршлын талаарх хэрэгцээний талаар ойлголт өгөх, (iii)

Бизнес эрхэлдэг 45-55 насны хүмүүст ойлголт өгөх байв.

Хоёрдугаар үе шатанд мөн адил 4 удаагийн ФБЯ-ийг зохион байгуулсан бөгөөд 41-49 насны болон 50-55 насны эрэгтэй, эмэгтэй гэсэн бүлгээр ярилцлагад оролцогчдыг түүвэрлэсэн.

Төслийн 1 болон 2-р үе шатанд хийсэн нөлөөллийн ажлын үр дүнг захиалагч байгууллагаас ирүүлсэн асуулт, удирдамжийн дагуу фокус бүлгийн ярилцлагаар тодруулж, цуглуулсан мэдээллийг нэгтгэн, чанарыг баталгаажуулан Англи хэл дээр хүлээлгэн өгөөд байна.



БОЛОВСРОЛ

“УЛААНБААТАР ХОТЫН ЭЦЭГ ЭХ,
БАГА НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН УНШИХ
ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГАА”



The Asia Foundation



ЗАХИАЛАГЧ

- Азийн Сан

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Суурь мэдээлэл цуглуулах ажлын зорилго нь эцэг, эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ ном уншиж өгдөг зуршил, хүүхдийг номтой танилцуулах, ном уншиж өгөхийн ач холбогдлын талаарх ойлголт, гэр, сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдэд зориулсан номын хүртээмж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа ямар түвшинд байгааг тодруулах юм.



2021

11-р сар

2022

3-р сар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ


Хүүхдэд бага наснаас эхлэн ном уншиж өгөх нь түүний аливаа зүйлийг ойлгох чадвар болон бусадтай харилцах харилцааг сайжруулдгийг олон судалгааны үр дүн харуулж байна. Түүнчлэн хүүхдийн сониуч байдал, анхаарал төвлөрөл, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл нийгэмшихүйн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хувь хүн болж төлөвшихөд эергээр нөлөөлдөг байна.

Азийн сан “Хамтдаа Уншицгаая” санаачилгыг сургуулийн өмнөх боловсролын бага насны хүүхдүүдийн сургуульд суралцах бэлэн байдал хангалтгүй байгаа асуудал дээр тулгуурлаж, 2021 оны 9 дүгээр сард хүүхдүүдэд ном уншихыг сурталчлах, боловсролын үр дүнг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү санаачилга нь Монгол хэл дээрх чанартай хүүхдийн номын хүртээмжийг нэмэгдүүлэх, насанд хүрэгчдэд бага насны хүүхдүүдтэй ном унших хэвшлийг бий болгоход чиглэсэн цогц хөтөлбөр юм. Энэхүү санаачилга нь эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн номыг бага насны хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал “хэрэгсэл” болгон ашиглахад туслах зорилготой юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан зохион байгуулсан. Тоон судалгаанд Улаанбаатар хотын сонгогдсон сургууль, цэцэрлэгийн 0-5 хүүхдүүдийн 834 эцэг эхчүүдийг хамруулав. Харин чанарын судалгаанд Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Боловсролын газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, дүүргүүдийн боловсролын хэлтэс, цэцэрлэг, сургуулийн удирдлагуудын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Суурь судалгааны мэдээллийг төслийн эцсийн үнэлгээний үр дүнтэй харьцуулагдахуйц байхад тохиромжтой, цаг хугацааны давтамжтай загварыг сонгосон.



Цаг хугацааны давтамжтай загвар

ГОЛ ҮР ДҮН

- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөх, түүнийг номд дуртай болгоход чиглэсэн үйл ажиллагаа хязгаарлагдмал байна. Тэдний ердөө 9.7% нь хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгч байна. Нэг удаад хүүхдэдээ ном уншиж өгөх хугацаа дунджаар 10 минут байна.
- Хүүхдэдээ ном уншиж өгөх, түүнийг номд дуртай болгох үйл ажиллагаа нь эцэг эхчүүдийн боловсролын түвшинтэй шууд хамааралтай байна. Эцэг эхийн боловсролын түвшин доогуур байх тусам хүүхдэдээ ном уншиж өгөх нь бага байна. Сонирхолтой нь, өрхийн орлого өндөр байх тусам эцэг эхчүүдийн хүүхдэдээ ном уншиж өгөхөд зарцуулж буй цаг бага байна. Тэд орлого олохын тулд их ажилладаг учир хүүхдэдээ зарцуулах цаг бага гардаг гэж тайлбарлажээ.
- Эцэг эхчүүд завгүй ажилладаг, хүүхдэдээ ном авч өгөх санхүүгийн бололцоо муу, гэрийн ойролцоо номын сан, дэлгүүр байхгүй зэрэг шалтгаан нь ном уншиж өгөх соёл дэлгэрэхгүй байх нөхцөл болж байна.
- Ихэнх эцэг эхчүүд хүүхдэдээ номд дуртай болгох нь чухал гэдэгтэй санал нийлж байна.
- Эцэг эхчүүдийн 41.9% нь хүүхдэдээ номтой танилцуулах, ном уншиж өгч эхлэхэд хамгийн тохиромжтой насыг 3-5 нас гэж үзсэн бол 39% нь 3 наснаас өмнө уг үйлийг хийх хэрэгтэй гэж үзсэн. Түүнчлэн эцэг эхчүүдийн 11.3% нь хүүхдэдээ эхийн хэвлийд байхад ном уншиж өгөх нь чухал гэж үзсэн.
- 1, 2 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдийн маш бага хувь нь хүүхдэдээ сургуульд

- элсэхээс өмнө ном уншиж өгч байсан гэж хариулжээ. Тодруулбал, зорилтот хороодын эцэг эхчүүдийн ердөө 10.9% нь, зорилтот бус хороодын эцэг эхчүүдийн 8.8% нь хүүхдэдээ 'байнга' ном уншиж өгдөг байсан гэж хариулжээ. Энэ үзүүлэлтийг хүйсийн хувьд харьцуулж үзвэл ээж нар (11.6%) аавуудыг (0%) бодвол хүүхдэдээ ном уншиж өгөх нь илүү байна.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд эцэг, эхчүүд нь цахим ном уншиж өгөх соёл хэвшээгүй байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн хариултаас харахад цахим хэлбэрийн ном худалдан авч уншдаг гэр бүл зорилтот хороонд 18.1%, зорилтот бус хороонд 10.8% байна. Үлдсэн хэсэг нь цахим номыг сонирхохгүй байна.
 - Судалгаанд хамрагдсан хороодод нийтийн номын сан, номын дэлгүүрийн хүртээмж хангалтгүй байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 51.8% нь гэрийнх нь ойролцоо ямар ч номын сан байхгүй гэж хариулсан.
 - Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн багш, менежерүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс насанд хүрсэн хүний тусламжгүйгээр хүүхэд хүрэхүйц газар номыг байрлуулах хэрэгтэй гэсэн ойлголттой байгаа нь ажиглагдсан. Судалгааны үр дүнгээс харвал хүүхдүүд насанд хүрэгчдийн тусламжгүйгээр гэртээ номтой хамгийн ойр байдаг гэж зорилтот хороо 62.1%, зорилтот бус хороонд 79.7% үзсэн байна.


- Боловсролын байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас дүгнэхэд Монгол Улсад хүүхдийн номд тавих нэгдсэн шалгуур, стандартыг шинэчлэн батлах шаардлага байна.
- Цэцэрлэгүүд ном ашиглан хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг өөрсдийн хязгаарлагдмал төсөвтөө тааруулан зохион байгуулдаг ч номын хүртээмж, чанар хангалтгүй хэвээр байна.

Эдгээр гарсан суурь судалгааны мэдээллийг "Хамтдаа уншицгаая" төслийг хэрэгжүүлэхэд гарсан өөрчлөлт, үр дүнг хэмжихэд хэрэглэж юм.

"Let's Read" digital library for all children


Explore the world with your children through reading hundreds of high-quality books from "Let's Read" library.

Download Let's Read app:



www.letsreadasia.org

Free to read online and offline, and print from any device.



“СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН 5 ДУГААР ШАТНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ХИЙХ” ТӨСӨЛ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ЗАХИАЛАГЧ

- Дэлхийн Банк
- Боловсрол, шинжлэх ухааны яам

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Үнэлгээний зорилго нь (i) Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх, (ii) Төслийн үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлэх явдал юм.




2022

1-р сар

2023

5-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-наас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Боловсролын чанарын шинэчлэл төсөл” (БЧШТ)-ийг 2015 оны 8 дугаар сараас эхлэн үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна.

Уг төслийн 3-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бага боловсролын сургалтын чанарыг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулахад чиглэсэн шинэлэг үйл ажиллагааг дэмжих зорилгоор БШУЯ-аас төрийн өмчийн ЕБС-уудын санаачилсан төслийн саналыг шалгаруулан тэтгэлэг олгох үйл ажиллагаа буюу “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг (СТХ)” 2016-2021 оны хооронд C1, C2, C3, C4, C5 гэсэн үсгийн товчлол бүхий нийт 5 үе шатны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны хэрэгжилтийн үр дүнг үнэлэх зорилгоор үнэлгээг зохион байгуулж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг үнэлгээнд Хөндлөн огтлолын судалгааны дизайн буюу Cross-sectional design¹-ыг

¹ The Cohort as a Concept in the Study of Social Change, Ryder, Norman B., 1965

ашигласан. Хөндлөн огтлолын судалгааны дизайн нь цаг хугацааны тодорхой нэг цаг үед олон янзын хүмүүсээс тодорхой нэг онцлог асуудал дээр тулгуурлан мэдээлэл цуглуулдаг судалгааны загвар юм. Энэхүү судалгааны загвар нь тодорхой нэг зүйлийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх, чанарыг сайжруулах шаардлагатай хүчин зүйлсийг судлахад чухал нөлөө үзүүлдэг.



ГОЛ ҮР ДҮН

Энэхүү үнэлгээний ажил нь IRIM судалгааны хүрээлэнгийн жилийн тайланг бэлтгэх явцад хэрэгжиж байгаа ба 2023 оны 5-р сард эцсийн үр дүнг гарахаар төлөвлөн ажиллаж байна.

НИЙГЭМ ХАМГААЛАЛ БА ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

МАЛЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААРХ ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГАА



International
Labour
Organization



ЗАХИАЛАГЧ

- НҮБ-ын Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
- НҮБ-ын ТХЗ Хамтарсан Сан

ХАМТРАГЧ

- Маастрихтын Их Сургууль

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгаа нь Монгол Улсын малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд хандах хандлагыг судлах зорилготой. Үүнд:

- Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны тухай ойлголт, зан үйлийг судлах;
- Малчдын өнөөгийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт болон даатгалын үйлчилгээ авах хэрэгцээ, тулгарч буй бэрхшээл болон хамрагдах болон эс хамрагдахад нөлөөлж буй шалтгаануудыг тодруулах;
- Монголын болон олон улсын сайн туршлага болсон загваруудыг харьцуулан судлах;
- Хууль, бодлогын зохицуулалт болон үйлчилгээтэй холбоотой оролцогч талуудын болон зөрүүний шинжилгээ гүйцэтгэх; үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц боломжит чадавч, нөөцийг тодорхойлох
- НД, ЭМД-н үйлчилгээ, малчдын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хууль, эрх зүйн орчноос үүдсэн бэрхшээлүүдийг тодорхойлох;
- Малчдад НД, ЭМД-г хүргэж буй байгууллагын болон технологийн тогтолцоог шинжлэх;
- Малчдад зориулсан нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сайжруулах санал зөвлөмж боловсруулах.




2021

4-р сар

2022

5-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Уур амьсгалын эрс тэс өөрчлөлт, мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийн хязгаарлагдмал байдал нь малчдын аж амьдралыг эрсдэлд оруулж, улмаар ядууралд гүн гүнзгий хүргэх эрсдэлтэй байдаг. Иймд Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) нийгмийн хамгааллыг малчдын орлогын баталгааг хангах гол хэрэгсэл болгох байдлаар Төрөөс малчдын талаар баримтлах бодлого (2009-2020)-д “Малчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд 100 хувь хамруулж, төрийн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэнэ” гэсэн зорилгыг дэвшүүлсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын харьяа байгууллагуудын хамтарсан ‘Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь’ (SP-Harders, MNG/19/01/UND) хөтөлбөр нь малчдын амьдралын болзошгүй нөхцөл байдал, тэдний нийгмийн даатгалын хэрэгцээг хангахуйц нийгмийн хамгааллын шинэлэг шийдлүүдийг боловсруулж эдгээр зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулж байна. Эдгээр шалтгаанаас улбаалаад Монгол Улсын малчин хүн амын нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөхөд

чиглэсэн шийдвэрийг үндэслэлтэй тайлбарлах тоо, баримт шаардлагатай. Улмаар Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас малчдын зан байдал, амьдралын хэв маягийн талаарх шийдвэр гаргагчид болон оролцогч талуудын ойлголтыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү судалгааг санаачилж, захиалсан.

Энэ хүрээнд IRIM судалгааны хүрээлэн Маастрихтын их сургуультай хамтран судалгааг гүйцэтгэсэн ба манай байгууллага судалгааны төслийг ахалж, Маастрихын их сургууль судалгааны ажлын тэргүүлэх түншээр ажиллав.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү судалгаа нь Монгол малчдын нийгэм, эдийн засгийн асуудал болон нийгмийн даатгалын чиглэлд хийгдсэн анхны судалгаа байсан. Мөн түүврийн хувьд үндэсний хэмжээнд төлөөлөхүйц бөгөөд өмнө нь малчдын нийгмийн асуудлыг судалсан, томоохон хэмжээний судалгаа дутмаг байв. Судалгаанд туршилтын загварыг ашигласан бөгөөд малчдын нийгмийн даатгалд хамрагдалтын шалтгааныг илрүүлэхийн тулд

4 төрлийн туршилтын бүлэг үүсгэх замаар моделийн дагуу нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн нь арга зүйн хувьд шинэлэг, үнэн бодит үр дүнг харуулах баталгаа болсон.

Ингэхдээ малчдыг туршилтын дөрвөн бүлэгт хувааж, хоёр зорилтот бүлэг, нэг идэвхтэй хяналт, нэг хяналтын бүлэг болгон малчдын нийгмийн даатгалд хамрагдах шалтгаан болж буй зан хандлагыг тодруулахыг зорьсон.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Тоон судалгаа: Асуумж (Бүх малчид)

- Компьютерийн тусламжтай утсаар мэдээлэл цуглуулах аргыг ашиглаж 4,000 малчдаас судалгаа авсан.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Чанарын судалгаа: Ганцаарчилсан ярилцлага (Гол оролцогч талууд)

- Үндэсний болон орон нутгийн түвшний оролцогч талуудтай нийт 52 ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан.

ГОЛ ҮР ДҮН

Монгол Улсад 2020 оны байдлаар нийт өрхийн 27% нь буюу 242,024 өрх мал аж ахуй эрхлэн амьдарч байна. Нийт хүн амын 9% нь малчин хэмээх ангилалд бүртгэлтэй байна. Нийт малчдын 32% нь 'ядуу' өрхөд хамаарна хэмээн тооцоолсон (Ганчимэг нар, 2019) боловч малчдын дунд тэгш бус байдал оршсоор байна. Малчин өрхүүдийн дөнгөж 5% нь нийт малын 22%-ийг өмчилдөг бол 45% орчим нь 200-аас доош толгой малтай буюу амьжиргаагаа залгуулах боломжтой тоо толгойд хүрэхээргүй хэмжээний малтай байна (НҮБ, АХБ, 2018).

Хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд, Нийгмийн даатгалын тухай хууль нь хувь хүмүүст (өөртөө ажлын байр бий болгогч хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, чөлөөт уран бүтээлчид г.м) нийгмийн даатгалд хамрагдахгүй байх боломж олгосон байна. Нийгмийн даатгалын тухай хуулиар албан журмаар даатгуулагч өөрийн хүсэлтээр сайн дурын даатгалд давхар хамрагдах эрхийг хязгаарласнаар нэмэлт даатгал хийлгэх боломж хаагдаж, даатгалын хамрагдалтад сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм. Мөн үүгээр зогсохгүй сайн дураар даатгуулагч иргэн зөвшөөрөгдсөн шимтгэлийн хэмжээний хамгийн багаар шимтгэлээ төлж, улмаар ирээдүйд бага тэтгэвэр тогтоологж, тэтгэврийн наснаас хойш амьжиргааны баталгаажих түвшин бага байхад нөлөөлж болзошгүй байна. Монгол Улсад малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хууль эрх зүйн орчныг (1990-2000) бүрдүүлж, хэрэгжүүлсэн нь малчдыг

дахин ийм хууль гарахыг хүлээн Нийгмийн даатгалын санд шимтгэл төлөхөөс түдгэлзэх, хүлээлт үүсгэх сөрөг нөлөөлөл үүсгэжээ.

Институтийн түвшинд, санхүүгийн эх үүсвэр, техникийн болон боловсон хүчин хангалтгүйгээс орон нутгийн даатгалын ажилтнууд малчдад хүрч ажиллах, нийгмийн даатгалын хамрах хүрээг сурталчилж, өргөжүүлэх боломжгүй байна. Мөн малчдын хувьд шимтгэлээ шалгах, өөрсдөө бие даан төлбөрөө төлөх (мөн гишүүнчлэлийн бусад үйлчилгээг ашиглах) боломж бүхий хүртээмжтэй, хэрэглэгчдэд ээлтэй төлбөрийн болон дуудлагын төвийн үйлчилгээ дутмаг байна.

Малчдын эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах, эс хамрагдах шалтгаан, мөн байгууллага, олон нийт болон үндэсний хэмжээний бодлого зохицуулалтыг бүхэлд нь системтэйгээр судалсан нь ихээхэн ач холбогдолтой, өргөн цар хүрээтэй болгож өгсөн. Судалгааны үр дүнд үндэслэн малчдын нийгмийн даатгал болон нийгмийн хамгааллын асуудалд чиглэсэн бодлогын хувилбар, санал зөвлөмжүүдийг Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам болон ОУХБ-н төслийн нэгжид хүлээлгэн өгсөн. Түүний үр дүнд, нийгмийн даатгалын бодлогын шинэчлэл хийгдэж, хууль, холбогдох журмуудад өөрчлөлт ороход суурь мэдээлэл болгон ашиглагдсан. Судалгааны үр дүнг үндэсний болон орон нутгийн түвшний талууд, малчид, иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулах, тайлангийн нээлтийн ажиллагааг 2022 оны 6-р сарын 2-ны өдөр зохион байгуулсан. Судалгааны тайлантай [энд дарж](#) танилцана уу.



ТӨГСӨЛТИЙН АРГАЧЛАЛЫН ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



МОНГОЛЫН
УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГ



ЗАХИАЛАГЧ

- Азийн Хөгжлийн Банк,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

- Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Зах зээлийн судалгаа нь Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн хүүхдийн мөнгө болон хүнсний талон авч буй зорилтот өрхүүдийн онцлогт нийцсэн 8-10 тогтвортой амьжиргааны хувилбаруудыг дүүрэг тус бүрээр тодорхойлон гаргах зорилготой. Энэ хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

- Ядуу өрхүүд зах зээлд хэрхэн оролцож байгаа, оролцоход тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлэх, зах зээлийн тогтолцоо болон нэмүү өртгийн сүлжээг тодорхойлох зорилгоор дүүргийн зах зээлийн ерөнхий нөхцөл байдлын шинжилгээг хийнэ.
- Дүүрэг бүр дэх нэн ядуу, эмзэг бүлгийн өрхүүдэд тулгарч буй боломж, эрсдэлийг тодорхойлохын тулд боломжит зах зээлийн систем болон нэмүү өртгийн сүлжээний боломжит амьжиргааны үнэлгээг хийнэ.
- Дүүрэг бүрийн онцлог тохирсон 8-10 амьжиргааны эх үүсвэрийн багц буюу боломжит бизнесийн багцыг боловсруулна.
- Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрт хамрагдах өрхүүдийн ур чадвар, туршлага, нөөц бололцоонд тулгуурлан бизнес эрхлэхэд бэлэн байдлын үнэлгээний (профайлинг) хэрэглэгдэхүүнийг боловсруулна.



2022 12-р сар

2023 5-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот Баянзүрх,
Чингэлтэй, Сонгинохайрхан
дүүрэг



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Манай улсад 2016 оноос хойш ядуурал дорвитой буураагүй бөгөөд 2020 оны байдлаар нийт хүн амын 27.8% буюу 903.4 мянган хүн ядуу амьдарч байна. Түүнчлэн хүн амын 14% орчим нь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр байгаа нь багахан хэмжээний цочролд өртөхөд эдгээр хүн ам ядууралд ороход бэлэн байгааг харуулж байна. Нийт ядуу хүн амын 42% нь Улаанбаатар хотод байгаа төдийгүй сүүлийн жилүүдэд нийслэлд ядуурал огтхон ч буураагүй (Дэлхийн банк, YCX, 2021). Ядуурлын бууралт удаашрахад эдийн засаг, нийгмийн олон хүчин зүйл нөлөөлдөг ч нийгмийн халамжийн зорилтот хөтөлбөрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх нь ядуурлыг бууруулахад онцгой хувь нэмэртэй байдгийг олон эх сурвалж дурдсан байдаг. Нийгмийн халамжийн хуулиудын хүрээнд төрөөс 12 төрлийн үндсэн багц нийгмийн халамж, үйлчилгээний хөтөлбөр хэрэгжиж байна. 2018-2019 онд нийгмийн халамжийн арга хэмжээ, үйлчилгээний зардал дунджаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 2 орчим хувийг эзэлж байсан бол COVID-19 цар тахлын дэгдэлтээс үүдэн уг зардал сүүлийн хоёр жилд дунджаар 2.5 дахин өсөж 2021 онд ДНБ-ний 4.6%-д хүрчээ (YCX, 2022).

Азийн Хөгжлийн Банк, ХНХЯ-ны Цар тахлын үед


хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төслийн 2-р шатны хүрээнд хөтөлбөр нь ядуу, эмзэг бүлгийн иргэдийн эдийн засгийн оролцоог хангах, амьжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад цогц дэмжлэг үзүүлэх зорилгоор Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүрэгт хэрэгжиж байна. Хөтөлбөрт 18-55 хүртэлх хөдөлмөрийн насны ядуу дор хаяж нэг гишүүнтэй, хүнсний эрхийн бичиг, хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагддаг нийт 1520 иргэнийг хамруулахаар төлөвлөж, бэлтгэл ажлууд хийгдэж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зах зээлийн судалгааг 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр шатанд зорилтод өрхийн амьжиргааны чадамж, бизнесийн боломжийн нийцлийн судалгааг “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-ийн суурь судалгаанд оролцсон иргэдээс 308-г түүвэрлэн авч, асуумж судалгааг авна. Судалгааны үр дүнд нь Бизнесийн үйл ажиллагааны урт жагсаалтын эхний хувилбарыг боловсруулна. Уг жагсаалтыг *жигжиг бизнесийг үнэлэх үнэлгээний аргачлалаар* зорилтот бүлгийн иргэдийн чадамжид суурилан үнэлж, илүү амьдрах чадвар бүхий бизнесийн үйл ажиллагааны эцсийн урт жагсаалтыг гаргана.

Хоёрдугаар шатанд урт жагсаалт дахь бизнесийн үйл ажиллагаануудын зах зээлийн багтаамжийн цар хүрээг тодорхойлох зорилгын хүрээнд зах зээлийн эрэлтийн судалгаа хийнэ. Энэ хүрээнд боломжит эрэлт үүсгэгчийг *өрхийн хэрэглэгч, үйлдвэрлэлийн хэрэглэгч, төрийн байгууллагын худалдан авалт* гэсэн үндсэн гурван бүлэгт ангилна. Өрхийн хэрэглэгчийн судалгааг гурван дүүргийн иргэдээс 285-г санамсаргүй түүврийн аргаар сонгож, хамруулна. Дээрх хоёр шатанд хийгдсэн судалгааны үр дүнд үндэслэн дүүрэг бүрд 8-10 бизнесийн үйл ажиллагаа бүхий богино жагсаалтыг гаргана. Энэхүү жагсаалтыг



“Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-ийн зах зээлийн судалгааны дизайн

гаргахдаа төгсөлтийн аргачлалын богино жагсаалтын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгааг мөн шалгана.

Гуравдугаар шатанд богино жагсаалтад орсон бизнесийн үйл ажиллагаа бүрийн хувьд нэгдүгээрт, нэмүү өртгийн сүлжээг тодорхойлох судалгаа хийнэ. Энэ хүрээнд түүхий эд болон нийлүүлэлтийн сүлжээг тодорхойлж, шаардагдах мэдээллийг хоёрдогч тоон мэдээлэл, ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулна. Хоёрдугаарт, санхүүгийн

шинжилгээ хийж, шаардагдах бараа, үйлчилгээ, тээврийн зардал зэргийн үнийг хоёрдогч эх сурвалжийн тоон мэдээллээс авна. Эдгээрт үндэслэн бизнесийн үйл ажиллагааны багцыг боловсруулна.

ГОЛ ҮР ДҮН

Одоогоор зах зээлийн судалгааны төсөл нь хэрэгжиж байгаа бөгөөд бизнесийн чиглэлийн урт, богино жагсаалтууд гарч, нэмүү өртгийн шинжилгээ хийх ажил явагдаж байна.

ЗҮҮН ТИМОРЫН COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ХЯНАХ СУДАЛГАА



САНХҮҮЖҮҮЛЭГЧ

- Дэлхийн Банк

ЗАХИАЛАГЧ

- НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)
- Зүүн Тиморын Статистикийн ерөнхий газар

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь Зүүн Тиморын COVID-19 цар тахлын үеийн өрхийн нийгэм, эдийн засгийн механизмд үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох, засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, хариу арга хэмжээний зөрүүг тодорхойлох, цар тахлын нөлөөлөлд өртсөн хүн амын нөлөөллийг даван туулах болон эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээхэд шаардлагатай нөөцийг нэмэгдүүлэх, дахин чиглүүлэхэд туслах зорилгоор хэрэгжүүлж буй утсаар мэдээлэл цуглуулах түргэвчилсэн судалгаа юм.



2022

5-р сар

2023

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Зүүн Тимор улс, Дили хот
(Зүүн Өмнөд Ази)

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2022 оны гуравдугаар сард Дэлхийн банк (ДБ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) Зүүн Тиморын Сангийн яам болон Статистикийн ерөнхий газар (СЕГ) хамтран “Зүүн Тиморын COVID-19 цар тахлын үеийн өрхийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хянах судалгаа” (HiFu)-г санаачилсан. Судалгааны зорилго нь өрхийн цар тахлаас өмнөх амьдралын нөхцөл байдал болон COVID-19-ийн удаан хугацааны хөл хорионы үеийн нөлөөг хэрхэн даван туулж байгааг тодруулахад оршино. Судалгааны үр дүнд тус улсын шийдвэр гаргагчид COVID-19-ийн нийгэм, эдийн засгийн өрхүүдэд үзүүлэх нөлөөллийн талаарх бодит мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой болж, цуглуулсан мэдээлэлд үндэслэн нотолгоонд суурилсан цар тахлын эсрэг хариу арга хэмжээг дэмжихэд ашиглах боломжтой болж байгаа юм.

Судалгаа нь хэд хэдэн онцлогтой:

1. 2021 онд НҮБ болон Зүүн Тиморын Засгийн газраас хийсэн SEIA 2.0 судалгааг ашиглан түүврийн аргаа тодорхойлсон. Тиймээс энэ нь үндэсний хэмжээнд үргэлжилж буй судалгааны нэг хэсэг юм.
2. HiFu судалгаа нь CsPro программ дээр хийгдсэн дижитал асуулга болон Bitrix24

утсаар ярилцлага авч, хянах программ хангамжийг ашиглан СЕГ-т Компьютерын тусламжтай утсаар ярих аргыг нэвтрүүлсэн. Энэ нь мэдээлэл цуглуулах багийг ажлын байранд суралцах, чадавхыг бэхжүүлэх ажлыг өргөн хүрээнд хийх шаардлагатай болгосон.

3. Судалгааны асуумжийг улсын хэмжээнд авч, давхардлаас зайлсхийх үүднээс өмнө нь хийгдсэн болон одоо байгаа бусад судалгаатай харьцуулалт хийсэн.

Тус судалгааны багийн ахлагчаар IRIM-ийн ТУЗ-ын гишүүн, Зүүн Тиморын НҮБХХ-ийн зөвлөх А.Долгион ажиллаж, Л.Цэлмэгсайхан болон Ц.Батсугар нар мэдээлэл цуглуулалтын зөвлөхөөр ажилласан.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү судалгаанд түүврийн хамрах хүрээг гаргахдаа 2021 оны COVID-19-ын Нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний 2-р шатны (SEIA-2) судалгаанаас сонгогдсон гар утастай өрхийн тэргүүнтэй эсвэл өрхийн аль нэг гар утастай гишүүнтэй өрхүүдийн жагсаалтыг ашигласан. Уг түүвэрлэлтийн аргыг ашиглан HiFu судалгааны 1-р шатанд нийт 1000 өрхтэй ярилцлага хийсэн бөгөөд 2-р шатанд яг ижил өрхүүдээс ярилцлага авахаар болсон.

COVID-19 цар тахлын Зүүн Тиморын өрхүүдэд үзүүлэх нийгэм, эдийн засгийн нөлөө




Энэхүү судалгаанд ашигласан түүврийн арга нь шаталсан санамсаргүй түүврийн арга юм. *Түүврийн хэмжээг хангахын тулд өрхийн тэргүүний зарим боломжит хувьсагчдад үндэслэн өрхүүдийг шаталж нь ангилсан.* Үе шат болгонд ашигласан хувьсагчдыг сонгохдоо бид 2021 оны судалгааны мэдээллийн тархалтыг 2015 оны тооллогын мэдээлэлтэй харьцуулсан.

Судалгааг IRIM судалгааны хүрээлэн нь утсаар мэдээлэл цуглуулах (CATI) туршлагадаа тулгуурлан зохион байгуулсан бөгөөд судалгаа 2 үе шаттай байв.

ГОЛ ҮР ДҮН


IRIM судалгааны хүрээлэн 2020 оноос Bitrix 24 программд суурилсан зайнаас мэдээлэл цуглуулах төв болох Дуудлагын төвийг байгуулан ажиллаж байна. Өнөөдрийг хүртэл уг дуудлагын төв нь давхардаагүй тоогоор 64,000 гаруй дугаарын нөөцтэй, олон улсын хөгжлийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургуулийн захиалгаар 15 төслийн 20,000 гаруй судалгааг амжилттай цуглуулсан. BITRIX 24 нь бусад онлайн мэдээлэл цуглуулалтын платформуос үүлэн технологид суурилсан хэрэглэгчийн үйлчилгээний менежмент (CRM), процессын болон хүний нөөцийн менежментийн автоматжуулалтын (business automation) платформуудтай хослуулан ажилладгаараа ялгардаг.



Энэхүү судалгаа нь Зүүн Тиморын өрхүүдэд COVID-19-ийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө болон дэлхийн бусад өнөөгийн нөлөөллийн талаарх олон сэдвийг хамарна.

Өөрсдийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан 2022 онд Зүүн Тимор улсын Статистикийн газрын мэргэжилтнүүдийг CATI (computer assisted telephone interview) арга зүйд сургаж чадавхжуулах, утсан судалгааны технологийн дэд бүтцийн шийдлийг сонгох, нутагшуулах зэргээр мэдээлэл цуглуулалтын ажлыг 2022-2023 онд зохион байгууллаа.

“COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН БҮСИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ НЬ” ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ

- Азийн Хөгжлийн Банк
- Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

‘Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр’-ийн нэгдүгээр үе шатны бүтээн байгуулалт болох Баянхошуу болон Сэлбэ дэд төвийн зорилтот хороодын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид (БЖДБЭ)-ийн хэрэгцээг тодорхойлж, түүнд тулгуурлан БЖДБЭ-ийг чадавхжуулах, тэднийг дэмжих зорилготой.

Үүний тулд дараах 3 зорилтыг хангана. Үүнд:

1. Зорилтот хороодын БЖДБЭ-н бизнесийн хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийх
2. Зорилтот хороодын БЖДБЭ-н хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадавх нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
3. Зорилтот хороодын БЖДБЭ-дэд тоног төхөөрөмжийн бодит дэмжлэг үзүүлэх



2021

5-р сар

2023

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

СХД-ийн 8, 9, 10, 11, 26, 40-р хороо
ЧД-ийн 14, 18-р хороо
СБД-ийн 13, 14-р хорооны бизнес
эрхлэгчид



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Азийн Хөгжлийн Банк, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны санхүүжилтээр “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” (УБГХХХОДХ)-ийг 9 жилийн хугацаанд 3 үе шаттай хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд нийгмийн болон инженерийн дэд бүтцийн ажлыг хийж, гүйцэтгэн 6 дэд төвийг байгуулах юм.

Ингэснээр Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон зохисгүй төвлөрлийг сааруулж, нийгмийн болон хотын үйлчилгээг жигд хүртээмжтэй болгоход тулах зорилготой. АХБ болон төслийн үзэл баримтлалын дагуу хийгдэж буй төслүүд нь бүтээн байгуулалт хийгээд зогсохгүй, тухайн бүсийн иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах, амьжиргааг дэмжих зэргээр цогц арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Хөтөлбөрийн үр дүнд дараах 4 зүйлс багтана. Үүнд:

- Зорилтот дэд төвүүдийн хүрээнд авто зам, хотын үйлчилгээ өргөжин, дэд төвүүдийн холболт сайжирсан.
- Дэд төвүүдийн эдийн засаг, төрийн үйлчилгээ сайжирсан.
- Үйлчилгээ үзүүлэгчид илүү үр ашигтай болдог.

- Хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээ үзүүлэх институт, чадавхыг бэхжүүлсэн.

Үүний үндсэн дээр ашиглалтад орсон Баянхошуу, Сэлбэ дэд төвийн иргэдийн нийгмийн хангамж, эдийн засгийг хөгжүүлэхэд бичил, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах судалгаа, техник туслалцааны ажлуудыг IRIM, VFAS, WEMC байгууллагууд хамтран хэрэгжүүлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН


Төслийн ерөнхий зорилгын хүрээнд 3 үр дүнд хүрэхийг зорьсон. Үүнд:

1. Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид (БЖДБЭ)-ийн бизнесийн үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үнэлгээ
2. Зорилтот хороодын БЖДБЭ-ийн мэдлэг чадавх нэмэгдэх
3. Зорилтот хороодын БЖДБЭ-ийн тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэх

Зорилго 1: БЖДБЭ-н бизнесийн үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үнэлгээ:

Дэд төв орчмын бүсийн БЖДБЭ-ийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийснээр үр дүнд үндэслэн дараагийн арга хэмжээнүүдийг тодорхойлох байв. Тиймээс энэ ажлын эхний шатанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан Баянхошуу, Сэлбэ дэд төв орчмын 276 БЖДБЭ-ээс асуумж болон бизнес эрхлэгчтэй хамтран ажилладаг төр, олон улсын төсөл хөтөлбөр, банк санхүүгийн байгууллагын төлөөллүүдийг хамруулсан.

Хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд тулгуурлан хэрэгцээт сургалтууд болон дэмжлэгүүдийг олгосон бол суурь үзүүлэлтийг төслийн эцсийн үр дүнгээ хэмжихэд ашигласан. Төслийн эцсийн шатны үнэлгээг 2022 оны



төгсгөлд зохион байгуулж, үр шим хүртэгчдэд гарсан өөрчлөлтийн талаар тодруулж, суурь судалгааны гол үзүүлэлттэй харьцуулан төслийн үр дүнгээ төгсгөлийн шатанд хэмжсэн.

Зорилго 2: Зорилтот хороодын БЖДБЭ-н мэдлэг, чадавх нэмэгдэх: Судалгааны үр дүнд тулгуурлан сургалтын сэдвийг тодорхойлон, сургалтын агуулгыг бэлтгэн нийт 84 удаагийн сургалт, 4 удаагийн санхүүгийн байгууллагатай танилцах аялал, 3 удаагийн сургагч багш бэлтгэх сургалтууд төлөвлөж, үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнээс гадна сургалтын хугацаанд өдөр тутам 2 дэд төвд менторууд ажиллаж шаардлага зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан. Сургалтын үр дүнгээ сайжруулах үүднээс сургалтын өмнөх болон дараах үнэлгээг тогтмол зохион байгуулж, сайжруулалт хийж, үр дүнгээ үнэлж байв.

Зорилго 3: Зорилтот хороодын БЖДБЭ тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэх: Хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд тулгуурлан БЖДБЭ-дэд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн хэрэгцээг судалж, үүний үр дүнд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүний хүрээнд БЖДБЭ-ийн бизнесийн нөхцөл байдлыг судалснаар тэдэнд тохирсон сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, үнэлгээний хороо байгуулан тоног төхөөрөмжийн дэмжлэг хүссэн БЖДБЭ-ийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хийж, ашиглалтын талаарх 3 шатны мониторинг зохион байгуулсан.

ГОЛ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Төслийн зорилтуудын хүрээнд дараах үр дүн, өөрчлөлтүүд бий болжээ.

Хүрэх үр дүн 1: Хэрэгцээ тодорхойлох судалгаагаар БЖДБЭ-ийн 71.7% нь бизнесээ цаашид хөгжүүлэхэд шаардлагатай сургалт, зөвлөх үйлчилгээ авах сонирхолтой байгаа бол 80% нь бизнес, санхүүгийн ямар нэгэн сургалтад хамрагдаагүй байна. Мөн БЖДБЭ-чид хамгийн түрүүнд тоног төхөөрөмж худалдан авах, борлуулалтын сувгаа өргөжүүлэх, танилын хүрээгээ нэмэгдүүлэх, зээл авах, санхүүгийн бүртгэлийг сайжруулах шаардлагатай байгаа гэжээ. БЖДБЭ-ийн дөнгөж 7.2% нь шинэ тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Бизнесийн менежментийн одоогийн чадамжийг 6 үзүүлэлтээр тодорхойлсон. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад санхүү менежмент 10.5%, хүний нөөцийн менежмент 13.3%, удирдлага, зохион байгуулалт 4.4%, борлуулалтын суваг 1.9%, мэдээллийн технологийн ашиглалт, хэрэглээ болон бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийн үзүүлэлтүүд 0.9%-аар нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарсан.

Хүрэх үр дүн 2: Төслийн баг нийтдээ 105 удаагийн чадавх бэхжүүлэх сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бөгөөд давхардсан тоогоор 1357 хүнийг хамруулсны 81% нь эмэгтэйчүүд байв. Үүнээс чадавх бэхжүүлэх 84 удаагийн сургалтыг төлөвлөсний дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор 1004 бизнес эрхлэгч хамрагдсан. Түүнчлэн, 44 бизнес эрхлэгчийг 3 сэдвээр сургагч багшаар бэлтгэлээ. Төслийн хүрээнд сургалтаас гадна 229 бизнес, аж ахуйн нэгжид ганцаарчилсан болон бүлгээр зөвлөгөө, менторын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Оролцогчдын сургалтын өмнөх мэдлэгийн үнэлгээний дунджийг сургалтын дараах үнэлгээтэй харьцуулахад 2.58—4.06 болж нэмэгдсэн нь сургалт, зөвлөгөөний үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэнийг харуулж байна.

Эцсийн судалгааны үр дүнгээр үр бизнес эрхлэгчид сургалтын үйл ажиллагаанд хамрагдсанаар бизнесээ улам өргөжүүлэх хүсэл, сонирхол нэмэгдсэн, танилын хүрээгээ өрсөлтөгсөн, өөртөө итгэх итгэл, харилцааны ур чадвар сайжирсан, бизнесийн эрхлэгч хамт олны нэг хэсэг болсон, өөрийгөө танин мэдэх болон стресс менежмент хийх ур чадвар сайжирсан,

маркетинг хийх аргачлалууд, бүтээгдэхүүнээ сурталчлах ур чадвар нэмэгдсэн, санхүүгийн төлөвлөлт сайжирсан, төсөл хэрхэн бичих, стратеги төлөвлөлт хийх зэрэг баримт бичгийн ур чадвар сайжирсан, бизнес эрхлэхтэй холбоотой татвар, НД зэрэг хууль тогтоомжтой холбоотой зүйлийн талаарх мэдлэг сайжирсан, санхүүгийн орлого, зарлагын бүртгэл, хөтөлөлтийн мэдлэг, ур чадвартай болсноор бизнестээ ашиглах байдал дээшилсэн байна. Сургалтад хамрагдсан оролцогчдын 72% нь сургалтын үйл ажиллагаанаас сурсан зүйлсээ бизнесийнхээ үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.



Хүрэх үр дүн 3: Төслийн баг хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд илэрсэн мэдээлэлд тулгуурлан боловсруулсан ТЭЗҮ-д үндэслэн 4 шатны шалгаруулалтаар 77 үр шим хүртэгчийг сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор 446 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий 341 ширхэг тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж олгосон.

Үр шим хүртэгчид сонгон шалгаруулалтын бүхий л үйл явцыг бодитой, шударга байсан гэж 95%-иас дээш үнэлж байна. Тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан үр шим хүртэгчдийн хэлж байгаагаар тэдний бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их гарч буй өөрчлөлт нь 62.7% нь борлуулалтын орлого өссөн, 59.7% нь үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдсэн, 53.7% нь ажлын бүтээмж нэмэгдэж, цаг хугацаа хэмнэж байгаа, 52.2%-д нь ажлын байр нэмэгдсэн, 52.6% нь бүтээгдэхүүний чанар, үзэмж сайжирсан гэж үзсэн. Тоног төхөөрөмжийн дэмжлэг хүртэгчид цаашид тоног төхөөрөмжөө ашиглан бизнесээ өргөжүүлэх, дараагийн түвшинд гаргах төлөвлөгөөтэй байгаа нь төслийн үндсэн зорилгод нийцэж байна.

Дэд төвд байрлах бизнес инкубаторын төвийг цаашид энэ хэвээр нь БЖДБЭ-дэд чиглэсэн идэвхтэй, тогтмол үйл ажиллагаатай байхыг оролцогч талууд хүсэж байна. Дэд төвүүд нь сургалт, сүлжээгээ өргөтгөх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг бизнесийг дэмжих таатай орчныг бүрдүүлдэг боловч эдгээр дэд төвүүдийн чадавх болон төсөв хэт хязгаарлагдмал байна. Тиймээс цаашид олон улсын хөгжлийн байгууллагууд болон төрийн холбогдох байгууллагууд дэд төвүүдийг хөгжүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд бизнесийн сургалт, зөвлөгөө өгөх боловсон хүчнийг нэмэгдүүлэх, БЖДБЭ-дэд жижиг болон томоохон тоног төхөөрөмж байршуулан үйл ажиллагаа явуулах зэрэг хувилбарт ажлын байр түрээслэх, хүүхэд харах үйлчилгээг давхар зохион байгуулах нь гэр хороололд ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарах асуудлууд болж байна.



ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ (BEST) ХӨТӨЛБӨРИЙН ДУНД ШАТНЫ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧ

- Хөгжлийн шийдэл ТББ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО


АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн өнгөрсөн 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төлөвлөсөн болон төлөвлөөгүй үр дүнг үнэлэх, хөтөлбөрт цаашид тусгах шаардлагатай санал, зөвлөмж боловсруулахад оршиж байна.



2022 10-р сар

2023 3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Жижиг Дунд Бизнесийн тогтвортой хөгжил, ил тод байдлыг сайжруулах (BEST) хөтөлбөр нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн санхүүжилтэйгээр 2019-2024 он хүртэл нийт таван жилийн хугацаанд хэрэгжинэ. Энэхүү хөтөлбөр нь Жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөх замаар эдийн засгийн сайн засаглалыг бий болгох, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах үндсэн зорилготой. Хөтөлбөрийн дизайн, хэрэгжилт нь дараах үндсэн таван зорилтоос бүрдэнэ. Үүнд:

1. ЖДБ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх,
2. ЖДБ-ийн компанийн засаглалыг сайжруулах,
3. Монголын байгууллагуудын чадавхыг сайжруулах,
4. Стратегийн суралцахуйн аналитик хөтөлбөрийг баримтлах,

5. Нөөц бололцоо багатай ч чадвар сайтай ЖДБ эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох.

Дунд шатны үнэлгээ нь эдгээр 5 зорилтын хүрээнд гарсан үр дүнг үнэлж, цаашид анхаарах санал, зөвлөмжийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдэд өгөх юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээнд OECD-DAC-ийн үнэлгээний зургаан шалгуурыг ашиглахаас гадна BEST хөтөлбөрийн үр дүнгийн хүрээ, гүйцэтгэлийн хяналтын төлөвлөгөө (PMP) болон үр дүнд чиглэсэн үнэлгээний гол асуултаудад төвлөрсөн.

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ холбогдох баримт бичгүүдэд өргөн хүрээний шинжилгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч болон хамтран ажиллагч 16 төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлагаар нэмэлт мэдээллийг цуглуулсан. Үр шим хүртэгчдийг хамруулахдаа статистикийн хувьд төлөөлөх чадвар бүхий нийт 400 гаруй хөтөлбөрийн оролцогчдоос асуумж судалгаа авч, мөн 5 фокус бүлгийн хэлэлцүүлэг, 5 кейс судалгаа зохион байгуулсан.

ГОЛ ҮР ДҮН

BEST хөтөлбөр нь БЖДБ эрхлэгчдийн бизнесийг чадавхжуулахад чиглэсэн Монголд хэрэгжиж буй хамгийн том, цогц хөтөлбөр юм. Энэ утгаараа BEST хөтөлбөрийн гүйцэтгэсэн үүрэг ЖДҮ-ийг орон нутгийн болон үндэсний хэмжээнд хөгжүүлэхэд илүү таатай эдийн засаг, зах зээлийн орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж чаджээ.

Хөтөлбөрийг цогцоор нь төлөвлөж, хэрэгжүүлсэн нь орон нутагт ЖДҮ-ийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна. Үүнд:

- ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Засаглалыг сайжруулах,
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах,
- Ингэхдээ нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад нөлөөлөх,
- Санхүүгийн эх үүсвэрт хамрагдах боломжгүй шинэлэг санал, санаачилгыг тэтгэлэгт хамруулах зэргээр цогцоор нь төлөвлөж, хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Мөн уг хөтөлбөрийн үр дүнд, бизнесүүдийн санхүүгийн боловсрол, бизнесийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, албан ёсны бүртгэлтэй болгосноор цаашид төрөөс хэрэгжүүлж буй зээл, төсөл хөтөлбөрт хамрагдах, тендерт оролцох, хамтран ажиллах олон боломжууд бий болж байгаа нь үнэлгээний үр дүнгээс харагдлаа.

Мөн зөвхөн бизнес эрхлэгчид чиглээд зогсохгүй төрийн бус байгууллагуудын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаанууд хэрэгжүүлсэн нь үр дүнтэй болжээ. Тодруулбал, BEST хөтөлбөр нь бизнес эрхлэгчдийг чадавхжуулахаас гадна ЖДҮ-н салбарын шийдвэр гаргагчид болон ТББ, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх, тогтмолжуулахад гүүр болж чадсан. Ингэснээр хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагаа, төлөвлөсөн үр дүнд хүрэхэд итгэлцлийг бий болгоход эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Хөтөлбөр нь 2024 он хүртэл үргэлжлэх бөгөөд дунд шатны үнэлгээ нь төслийн амжилттай хэрэгжүүлж дуусахад анхаарах шаардлагатай мэдээллээр хангаж чадсан гэж итгэж байна.

МОНГОЛЫН ХӨДӨӨ ОРОН НУТАГ ДАХЬ ХӨДӨЛГӨӨНТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧ

- Spirit of America төрийн бус байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төсөл нь дараах үндсэн хоёр зорилготой:

- Монголын хөдөөгийн хүн амын АНУ-ын талаарх өнөөгийн хандлагыг тодорхойлох
- Viral студиэс авч хэрэгжүүлсэн хэвлэл мэдээллийн кампанит ажлын үр нөлөөг хэмжих.




2022

10-р сар

2023

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, урьдчилсан үзлэгт хамруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх болон эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхийн тулд төрөөс нийтийн эрүүл мэндийн явуулын үйлчилгээг бий болгосон. Энэ ажлын хүрээнд Мянганы хөгжлийн сорилтын сангийн төслийн хүрээнд 2009 онд Монгол Улсын 21 аймагт шинэ автомашин (Toyota Landcruiser 76) олгож, явуулын эрүүл мэндийн үйлчилгээг амжилттай хүргэх боломжийг олгосон юм.

Тэдгээр автомашинуудаас 9 нь зорилтот эрүүл мэндийн үйлчилгээгээ одоогоор тогтмол хүргэж байгаа бөгөөд ялангуяа COVID-19-ийн дэгдэлтийн үед тандалт судалгаа хийх болон вакцинжуулалт явуулах зорилгоор түлхүү

ашиглаж байсан. Гэвч техникийн нөхцөл байдлын улмаас 4 автомашин ашиглалтаас гараад байгаа ба хэрвээ шаардлагатай засвар үйлчилгээг хийвэл цаашид ч ашиглах боломжтой байсан юм. Тиймээс энэхүү 4 автомашиныг засварлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулах ажлыг ЭМЯ болон Spirit of America ТББ хамтран хэрэгжүүллээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн үндсэн 2 зорилгыг хангахын тулд дараах арга зүйгээр зайнаас мэдээлэл цуглуулав.

ГОЛ ҮР ДҮН

Энэхүү төслийн эцсийн үр дүн энэ хугацаанд бэлтгэгдэж байгаа ба хараахан эцэслэгдээгүй байна.

Үндсэн сэдвүүд	Мэдээллийн эх сурвалж	Арга хэрэгсэл
1.1 Монголын хөдөөгийн хүн амын АНУ-д хандах өнөөгийн хандлага		
- Ерөнхий хандлага: - Бусад хөтөлбөр/интервенцийн талаарх мэдлэг	Зорилтот таван бүсийн хүн ам	Асуумж- 600
1.2 Хэвлэл, мэдээллийн хэрэглээ		
- Мэдээллийн эх сурвалж - Түлхүү үздэг/хэрэглэдэг сувгууд	Зорилтот таван бүсийн хүн ам	Асуумж- 600
2.1 Хамаарал, Үр дүнтэй байдал, Нөлөөлөл (анхны)		
- Интервенцэд нөлөөлсөн гадаад/дотоод хүчин зүйлс (Landcruiser-н засвар үйлчилгээ ба кампанит ажил) - Хүлээгдэж буй болон гэнэтийн үр дүн - Төслийн үр нөлөөтэй холбоотой түүх/кейсүүд	- Төслийн тайлангууд - Орон нутгийн бодлого, эрүүл мэндийн статистик - Оролцогч талууд - Үр шим хүртэгчид	- Бичиг баримт хянах - Ганцаарчилсан ярилцлага- 10

ЖЕНДЭР БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ЖЕНДЕРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



САНХҮҮЖҮҮЛЭГЧ

- “Монгол Улс: Институтийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл

ЗАХИАЛАГЧ

- Уул уурхай хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг үнэлгээ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 5-р сарын А/114 тушаалаар батлагдсан Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд төсөл хэрэгжиж буй аж ахуй нэгж, орон нутгийн бодит жишээнд түшиглэн үнэлгээ өгөх, сайжруулах зөвлөгөө өгөх зорилготой. Энэхүү зорилгод хүрэхийн тулд ажлын даалгаварт тусгагдсан дараах үндсэн 5 зорилтуудыг ханган ажиллаа. Үүнд:

1. Бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар ХШҮ-ний тайлан, холбогдох баримт бичигтэй танилцаж дүн шинжилгээ хийх;
2. Хэрэгжилтийн талаар ярилцлага хийх;
3. Салбарын жендерийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн бодит байдлыг салбар яам, агентлаг, аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын жишээн дээр судалж, дүгнэлт гаргах;
4. Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжүүдийг салбарын болон жендерийн мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэх;
5. Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжүүдийг тусгасан тайлан гаргах.




2022

11-р сар

2023

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) нь [Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлогыг нь 2019-2026 он](#) хүртэл 2 үе шаттайгаар (2019-2022, 2023-2026) хэрэгжүүлэх бөгөөд эхний үе шат нь 2022 онд дуусгавар болсон. Тус бодлогыг салбар яам, Жендерийн үндэсний хороо (ЖҮХ), салбарын агентлагууд, хөрөнгө оруулагч, хандивлагч байгууллагууд, орон нутгийн байгууллагууд, төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэхээр заасан.

Энэхүү үнэлгээний ажил нь салбарын жендерийн бодлогод УУХҮЯ-ны манлайлал, санаачилга дор салбарын жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх чухал үүрэгтэй ажил болж байгаа юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү үнэлгээний ерөнхий объект нь 'Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2019-2026), түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Тиймээс энэхүү үнэлгээг гүйцэтгэх нарийвчилсан арга зүй, хамрах хүрээг боловсруулах ажил нь уг бодлогын

хүрээнд дэвшүүлсэн 4 зорилт, 8 хүлээгдэж буй үр дүн болон түүнд хүрэх 29 үйл ажиллагаанд суурилан боловсруулагдсан. Мөн уг бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хэрэгжүүлэгч болон оролцогч талуудыг бүрэн хамруулсан.

Уг хөндлөнгийн үнэлгээг Монгол Улсын засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан гүйцэтгэв. Үнэлгээний мэдээлэл цуглуулалтыг баримт бичгийн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлага, кейс, асуумж зэрэг тоон, чанарын 4 төрлийн судалгааны аргыг хослуулан гүйцэтгэсэн.

ГОЛ ҮР ДҮН

Уг үнэлгээний ажлын хүрээнд 'Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого (2019-2026)'-ыг үнэлэхдээ i) үр дүнтэй, ii) тодорхой үр дүнд хүрсэн, iii) эрчимжүүлэх шаардлагатай, iv) үр дүнгүй гэсэн 4 түвшинд үнэлсэн. Үнэлгээнээс дараах гол үр дүнгүүд гарсан.

Ач холбогдолтой/Нийцтэй байдал: Бодлого нь ач холбогдолтой хэвээр байна. Уг бодлого нь дараах баримт бичгүүдтэй нийцэж байна. Үүнд:

- Монгол Улсын хөгжлийн дунд болон урт хугацааны бодлогууд,
- жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031) болон шинэчилсэн хуулиудтай нийцэж байна.

Бодлогыг танилцуулах ажил 2019 онд зохион байгуулагдсанаас хойш оролцогч талуудад дахин таниулах ажил явагдаагүй тул бодлогын талаарх мэдээлэл, ойлголт салбарын яам, агентлагаас бусад талуудад сул байна. Яам дотроо удирдлагын түвшинд ойлголт, дэмжлэг сул, манлайлал хангалтгүй байна. Салбарын хувьд жендерийн бодлогыг чухалчилсан нотолгоо байхгүй, төсөвт суулгадаггүй, хамгийн түрүүнд “хэмнэлтээр” хасах хандлагатай байна (зөвхөн нэг салбараар хязгаарлагдахгүй, бусад салбарт мөн ажиглагдаж байна). Салбар дундын хамтын ажиллагаа, санаачилга байхгүй байна.

Үр ашиг, үр нөлөөтэй байдал: Салбарын жендерийн мэдрэмжтэй, нарийвчлалтай тоо мэдээлэл хангалтгүй хэвээр, тайлагнах аргачлал боловсруулагдаж тархаагдаагүй байна. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал байхгүй, тайлагналт хангалтгүй. Зохион байгуулсан сургалтуудын эргэх холбоо, үр дүнд хийсэн үнэлгээ байхгүй. Олон улсын байгууллага, гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс бүрэн хамааралтай тул тогтмол байлгаж чадаагүй. Мөн сургагч багш нар бэлтгэх ажлын үр дүнгийн дүгнэлт олдоогүй, хязгаарлагдмал тоогоор жилдээ бэлддэг тул цаашид ч бодлогын хүлээгдэж буй үр дүндээ хүрэхгүй байх магадлал өндөр.

Бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайлан огт байхгүй байгаа нь энэ хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангуудыг баталгаажуулах боломжгүй байна. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд салбарын олон мянган ААН-дэд бууж хэрэгжсэн гэх мэдээлэл байхгүй байна. ЖҮХ болон яам, ААН-үүд, орон нутагт хүрч ажиллаж чадахгүй байгаадаа өөрсдөө шүүмжлэлтэй хандсан байна.

Бодитой хэрэгжихүйц байдал: Бодлогын 4 зорилтыг дагах 8 багц үр дүн нь бүгд шалгуур үзүүлэлтгүй, хэмжигдэхүйц бус. 29 үйл ажиллагаа тус бүрд шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон хэдий ч зорилт, үйл ажиллагааны суурь хүрэх түвшнийг тодорхойлж, төлөвлөөгүй. Энэ нь бодлогын үр дүнг үнэлэх, гарсан өөрчлөлт, шаталсан ахицыг хэмжих боломжийг хязгаарлаж байна.

Хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хийгдсэн байна. Дотоодын санхүүжилтийн тоо баримттай мэдээлэл байгаагүй.

Жишиг болох бодитой төсөвлөж хэрэгжүүлсэн жишээ олдсонгүй.

Бодлогын хэрэгжилтэд гарч буй дэвшил, сорилт болон ил тод байдал, хариуцлагыг өндөржүүлэхийн тулд цахим хуудсаар олон нийтэд танилцуулах ажлыг Жендерийн салбар зөвлөл хариуцна гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Тогтвортой байдал: Салбарын бодлого тогтвортой цаашид хэрэгжих хууль тогтоомжийн нөхцөл бүрдсэн хэдий ч бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай салбарын удирдлагын манлайлал сул, олон улсын байгууллага, гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд хэрэгжилтийг орхисон, өөрсдийн үүргийн хүрээнд хангалттай санхүүжилт тусгаагүй байна. Салбар дундын хамтын ажиллагааны платформ байгүй, мэдээлэл солилцоо хомс байгаа нь тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Мөн салбарын төрийн болон хувийн ААН-д бодлого хүрч нөлөөлж хэрэгжсэн нь тодорхойгүй, мэдээлэл байхгүй байгаа нь тогтвортой хэрэгжилтэд эргэлзээ төрүүлж байна.

Бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зөвлөмжүүд: Бодлогыг хэрэгжүүлэх үүднээс үйл ажиллагааны түвшиндээ олон санал, санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн боловч үр дүнг хэмжих түвшинд хараахан хүрч амжаагүй, мөн зарим төлөвлөсөн үр дүнгүүд хэмжигдэхүйц бус байна. Иймд бодлогын баримт бичгийн хэрэгжихүйц байдлыг сайжруулах үүднээс одоо байгаа суурь түвшин болон хүрэх түвшнийг тодорхойлж, тэдгээрээс хүлээгдэж буй үр дүнгүүдээ хэмжигдэхүйц болгох шаардлагатай. Ингэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Алсын хараа-2050, Салбар дундын стратеги төлөвлөгөө зэрэг эрх зүйн баримт бичгүүдтэй уялдуулах нь зүйтэй. Нэмэлт өөрчлөлт оруулахдаа төрийн албан хаагчдад чиглэсэн болон салбарын хэмжээнд гэж 2 салгаж үзэх, эхлүүлсэн сайн санал, санаачилгаа тууштай үргэлжлүүлэх саналыг оруулсан. Мөн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагаа, эрх үүргийн матриц, үр өгөөжийн зураглал гараагүй тул цаашид бодлогод бүх талуудын үүргийг тодорхой болгож үүрэгжүүлэх шаардлагатай байна.

Ийнхүү бодлогын баримт бичгийг сайжруулах, бодитой хэрэгжихүйц, үр дүнг нь хэмжигдэхүйц болгох асуудлыг яам болон ЖҮХ, мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн ажлын хэсэг гарган гүйцэтгэхийг зөвлөж байна.



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС



ЗАХИАЛАГЧ

- Сүхбаатар аймгийн ИТХ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төсөл нь дараах үндсэн хоёр зорилготой:

Сүхбаатар аймагт үйлдэгдэж буй гаралт өндөртэй 5 бүлэг зөрчил, гэмт хэргүүдийг сонгон, эдгээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үүнээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах зорилготой. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралтад нөлөөлж буй суурь шалтгаануудыг тодруулах
2. Сонгосон 5 бүлэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, тэдгээрийн гаралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах
3. Аймгийн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг хэмжих



2021

12-р сар

2022

3-р сар

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Сүхбаатар аймгийн бүх сумд: Баруун-Урт, Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Халзан, Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт, Баяндэлгэр, Сүхбаатар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2019 оны 12 сарын 04-ны өдрийн тогтоолоор “Аймгийн хөгжлийн зорилт 2020-2028” хэтийн зорилтын баримт бичгийг баталсан. Уг хэтийн зорилтын 4 тэргүүлэх чиглэлийн 4-т: Үр нөлөөтэй, хүртээмжтэй, хариуцлагатай, тэгш оролцоо бүхий нээлттэй, ардчилсан засаглалтыг төлөвшүүлж, иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ’ гэж тодорхойлж, энэ хүрээнд ‘Зорилт 10.1 Бүх нийтийн эрхзүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах замаар амар тайван амьдрах нөхцөлийг бий болгох’ зорилтыг хэрэгжүүлэхээр заажээ. Тиймээс аймгийн хэмжээнд гэмт, хэрэг, зөрчлийг бууруулахын тулд тэдгээрийн шалтгаан нөхцөлийн судалгааг хийж, урьдчилан сэргийлэх ажлыг илүү үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх гол суурь болох юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Гэмт хэрэг гэх ойлголтод олон төрлийн гэмт хэргүүдийг агуулж байдаг тул энэхүү судалгаанд Сүхбаатар аймгийн хэмжээнд хамгийн өндөр гаралттай 5 бүлэг гэмт хэрэг, зөрчлийг авч үзлээ.

Судалгааг туршилтын бус, хөндлөн үргэлжлэх судалгааны дизайн ашиглан, тухайн нэг цаг үед олон талбарт тоон болон чанарын аргаар мэдээлэл цуглуулж, нэгтгэн дүгнэх юм.

Туршилтын бус: Судалгаанд ямар нэг хяналтын харьцуулах бүлэг байхгүй бөгөөд Сүхбаатар аймгийн нийт иргэд болон орон нутгийн ИТХ-ын дарга, хэсгийн төлөөлөгчдийг олонлог

болгон сонгосон.

Хөндлөн үргэлжлэх: Судалгаагаар нэг цаг хугацаанд олон оролцогчдоос мэдээлэл цуглуулах ба тодорхой үе шаттай давтаж хийхээр төлөвлөөгүй.

Тодорхойлох: Тухайн нөхцөл байдал, түүний шалтгаан, хандлага болон хэв загварыг тодорхойлон дүрсэлнэ. Тиймээс эдгээрийн учир шалтгааны холбоог нарийвчлан судална.

ГОЛ ҮР ДҮН

Сүхбаатар аймгийн хэмжээнд хамгийн өндөр гаралттай дараах 5 бүлэг гэмт хэргүүдийн статистик мэдээллийг харьцуулж, шинжлэхдээ сүүлийн 4 жил буюу 2018-2021 оны хоорондох мэдээлэлд дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчил
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил
- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчил
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил

Сүхбаатар аймгийн гэмт хэрэг, зөрчлийн ерөнхий нөхцөл байдлыг дүгнэвэл гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс 5 дахин их байна. Ахуйн хүрээнд гарч буй гэмт хэрэг, зөрчил сүүлийн хоёр жилд нэмэгдсэн нь цар тахлын хязгаарлалтууд гэмт хэрэг, зөрчлийн гаралтад ихээр нөлөөлснийг харууллаа.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг: Сүхбаатар аймгийн хэмжээнд хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн 1.6%, бүсийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн 24.3%-ийг эзэлж байна. Гэмт хэргийн гаралтад инфляц, боловсролын түвшин, ажилгүйдлээс гадна ахуйн хүрээний архидалт нөлөөлж байна. Энэ төрлийн гэмт хэрэг гарах магадлал төв суурин болон хөдөө гэдгээс үл хамааран нийт нутаг дэвсгэрт үйлдэгдэх магадлал өндөр байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн ихэнх нь согтуугаар үйлдэгдсэн байгаа нь архидалт үндсэн нөлөөлөх хүчин зүйл болж байна. Хохирогч болон гэмт хэрэг, зөрчил үйлдэгчдийн дийлэнх нь залуучууд эзэлж байгаа ба бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой иргэд байна. Мөн ажил хийх боломж хомс, чөлөөт цаг өнгөрөөх орчин нөхцөл байхгүйгээс зорилгогүй архидан согтуурч, гарч буй аливаа зөрчил, маргааныг зөв аргаар шийдэх мэдлэг, боловсрол дутмагаас үүдэн нэгнийхээ эрүүл мэндэд хохирол учруулж байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт гэр бүлийн хүрээний архидалт, хардалтаас үүдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргүүд түгээмэл үйлддэг байна. Гэвч торгох, цөөн хоногоор хорих зэрэг үүнд авч буй арга хэмжээ нь эргээд хүчирхийлэлд өртөх магадлалыг нэмэгдүүлж байдаг. Ялангуяа хөдөө орон нутагт гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал хэлбэртэй байна. Тиймээс боловсрол, ажил эрхлэлт, орлого зэрэг нь гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн үр нөлөөг багасгах, суурь арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Аймгийн хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг өсөж, 18 насанд хүрээгүй хүүхдүүд хохирогч болж байна. Үүнд эцэг эхийн хараа хяналт сул, хүүхдээ энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт, дадал байхгүй байгаа нь нөлөөлж байна. Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг сумдад илүү бүртгэгдэж, үүнийг гол төлөв залуучууд үйлдэж байна. Үүнд боловсролын түвшин болон хүйсийн харьцаа нөлөөлж байна. Насанд хүрсэн залуу эмэгтэйчүүд боловсрол эзэмшихээр төв суурин газар бараадаж, залуучууд гол төлөв мал маллаж үлддэг байдал нь өсвөр насны охид тэдгээр залуучуудын хараанд өртөж, гэмт хэргийн хохирогч болох нөхцөл бүрддэг байна. Ихэнх хэргүүд ойр дотнын танилын хүрээнд үйлдэгддэг тул хэргийг илрүүлэх боломж бага байдаг ба тэд хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлөх оролдлого их байна. Хэрэг илэрч буй тохиолдол нь жирэмсэлсэн болон БЗХӨ авсан тохиолдолд сургууль, эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл ирж бүртгэгддэг байна. Тиймээс бусад тохиолдолд далд хэлбэртэй байгаа хэргийг илрүүлэх боломж

бага байна. Тиймээс эрсдэл өндөртэй бүлгүүдийг мэдлэг мэдээллээр хангаж, өөрсдийгөө хамгаалах мэдлэгийг төлөвшүүлэх нь чухал байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчил: Сүхбаатар аймгийн цагдаагийн газраас ирүүлсэн мэдээллээс харвал хөдөө орон нутагт мал хулгайлах болоод эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг зонхилох хандлагатай байна.

Судалгаанаас харахад иргэд өөрийн өмч хөрөнгөдөө тавих хяналт сул, иргэдийн аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй, хууль, хяналтын байгууллага гэмт хэргийг шалгах, илрүүлэх тал дээр хангалтгүй ажилладаг зэрэг нь гэмт гарахад нөлөөлдөг бөгөөд гэмт хэргийг ихэвчлэн гаднын хүмүүс, хохирогчийн таньдаггүй, насны хувьд залуу хүмүүс үйлдэжээ. Мөн хохирогчийн эд хөрөнгөө харж хандах хамгаалах хүч чадалгүй, хүн бүл муутай болон сул дорой байдлыг далимдуулж, өмчлөх эрхэд нь халдах тохиолдол түгээмэл байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гарахад ажилгүйдэл, ядуурал суурь шалтгаан болдог ч хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагаа сул, гэмт хэргийг түргэн шуурхай шалгаж, илрүүлдэггүй, гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлага, шалгуур сул, мөн гэрэлтүүлэг, камержуулалт, дэд бүтцийн хөгжил муу байгаа нь нөлөөлж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил: Замын хөдөлгөөний гэрэлтүүлэг болон тэмдэглэгээ хүртээмжгүй байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гол шалтгаан нь согтуугаар жолоо барих, үнэмлэхгүй болон насанд хүрээгүй хүүхэд жолоо барих, суудлын бүсээ зүүхгүй байх, гэрэл шилжүүлэхгүй байх зэрэг нөхцөл байдлаас үүджээ.

Энэ төрлийн зөрчилд зарим тохиолдолд хариуцлага хүлээлгэхгүйгээр сануулах, зөвлөх зэргээр өнгөрүүлж байгаа нь зөрчил дахин үйлдэх, цаашлаад хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд боловсролын түвшнийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох зэрэг суурь хүчин зүйлсийг сайжруулах нь гэмт хэргийн гаралтыг бууруулахад нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

БУСАД ТӨСЛҮҮД

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТЭД НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ АШИГЛАХ НЬ СУРГАЛТ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар манай байгууллага нь “Зэрлэг амьтан судлах хамгаалах төв”, “АНУ-ын Ойн албаны олон улсын хөтөлбөр”, “Олон улсын тогоруу хамгаалах сан”, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-тэй хамтран тус сургалтыг зохион байгууллаа. Сургалтын зорилго нь байгаль орчны салбарын мэргэжилтнүүдэд нийгмийн судалгааны арга зүй, онолын үндэс, практик туршлага олгох явдал байв.

Сургалтад БОАЖЯ-ны харьяа болон аймгуудын Байгаль орчин аялал жуулчлалын газрууд, Усны сав газрын захиргаад, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад, Усны газрын мэргэжилтнүүдээс хамрагдсан. Сургалтын үр дүнд оролцогчдын нийгмийн судалгааны талаарх ойлголт мэдлэг болон ур чадварын түвшний дундаж үнэлгээ өссөн байсан ба сургалтад оролцогчид цаашид нийгмийн судалгааны чиглэлээр илүү нарийвчилсан мэдлэг, чадварт суралцах сонирхол өндөр байгаа нь харагдсан.

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХОЛБООДЫН ЗӨВЛӨЛ - СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН СУРГАЛТ

Архангай аймаг 2023 оныг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй жил болгохоор төлөвлөж буйтай холбоотойгоор Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хэмжээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр” боловсруулах бэлтгэл ажил явагдаж байна. Уг санаачилгын хүрээнд дэд хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, нэн тэргүүний зорилтуудыг судалгаанд үндэслэж төлөвлөх зорилгоор аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоодын Зөвлөлийн гишүүдэд судалгааны арга зүйн суурь мэдлэг, практик ур чадвар олгох сургалтыг 2022 оны 04-р сарын 7-оос 13-ны өдрүүдэд зохион байгуулсан.

ОЛОН НИЙТИЙН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА 2022

Уг судалгаагаар улс оронд тулгамдаж буй нийгмийн нэн тэргүүний асуудлууд, ардчилал, хүний эрх, сонгуулийн тогтолцоо, улс төрийн нам болон бусад институтууд зэрэг сэдвээр иргэдийн санал бодол, тэдгээрийн оролцоо, байр суурийг тоймлон хүргэдэг билээ. Энэхүү судалгааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” (SWYEPPM) хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн нь IRIM судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэв. Санал асуулгад Монгол Улсын 18 ба түүнээс дээш насны 2500 иргэнийг олон шатлал санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулж үндэсний хэмжээнд зохион байгуулсан. IRIM судалгааны хүрээлэнгийн дуудлагын төвийг ашиглан утсаар (CATI)-ийн аргаар мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 3 сараас 4 сарын хооронд хийж гүйцэтгэв.

2022 онд гүйцэтгэсэн үр дүнгийн танилцуулгатай дараах холбоосоор нэвтэрч танилцах боломжтой.

Холбоос: [Public-Opinion-Poll-PUBLIC-MON-20220808.pdf \(iri.org\)](https://iri.org/public-opinion-poll-public-mon-20220808.pdf)

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗРЫН 2021-2025 ОНЫ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ

Дэлхийн байгаль хамгаалах сан (ДБХС)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захиалгаар тэдний зарим үйл ажиллагаанд хүний эрхийн магадлан шинжилгээг IRIM судалгааны хүрээлэн “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН хамтран 2022 оны 10 сараас 11 сар хүртэл 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. Үнэлгээг дараах бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой оролцогч талуудад үүсэж болох хүний эрхийн сөрөг нөлөөллийг тодорхойлох, эрэмбэлэх болон эрсдэлийг бууруулах, арилгахтай холбоотой хүний эрхийн асуудлыг магадлан шинжилсэн. Үүнд:

- ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын стратеги төлөвлөгөө (2021-2025 он),
- Амар мөрний эко бүс нутаг (Хэнтий, Сүхбаатар, Дорнод)-ийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2021-2026 он),
- Алтай Соёны эко бүс нутаг (Увс, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий)-ийн байгаль хамгааллын стратеги (2021-2030 он)

МОНГОЛ УЛСАД ЦОЧРОЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧАДАВХЫН ХЭРЭГЦЭЭ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

IRIM судалгааны хүрээлэн нь Эдийн засгийн бодлогын судалгааны хүрээлэн (EPRI), НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар Монгол Улсад “Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын чадавхын хэрэгцээ тодорхойлох, улмаар чадавхыг бэхжүүлэх багц боловсруулах” төслийн хүрээнд нийгмийн хамгааллын чиглэлээр ажилладаг яам, түүний харьяа агентлаг болон орон нутгийн газрууд болон донор байгууллагын нийт 58 холбогдох мэргэжилтнийг хамруулан цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлж, цаашид энэ чиглэлээр чадавхжих хэрэгцээ шаардлагын талаарх мэдээллийг цуглуулж, хүлээлгэн өгсөн. Мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 08 сараас 2022 оны 12-р сарын хооронд гүйцэтгэсэн ба үр дүнд тулгуурлан төслийг хэрэгжүүлэгчид үндэсний болон орон нутгийн түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчдын цочролд хариу үйлдэл үзүүлэх нийгмийн хамгааллыг бэхжүүлэх ерөнхий чадавхыг нэмэгдүүлэх сургалтын багц боловсруулж, чадавхжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

“МОНГОЛ НОГОО” ТӨСЛИЙН ДУНД ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, Фермер эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо болон НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага хамтран хэрэгжүүлж буй хүнсний ногооны тариалан эрхлэгчдийн газар тариалангаас олох дундаж орлогын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслийн дунд шатны үнэлгээг IRIM судалгааны хүрээлэн 2022 оны 08-р сараас 09 сарын хооронд хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээ нь төслийн зорилтот үзүүлэлтүүдийн (i) хүнсний ногоо тариаланчдын газар тариалангаас олж буй орлогын хэмжээ болон өрхийн орлогын түвшин, (ii) дотоод үйлдвэрлэсэн хүнсний ногооны талаарх хэрэглэгчдийн үнэ, чанарын талаарх хэмжээг сэтгэл ханамж, (iii) хүнсний ногооны салбарт төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний, үр дүнг тодорхойлж суурь судалгааны үр дүнтэй харьцуулж өөрчлөлтийг хэмжихэд чиглэсэн.

Дунд шатны үнэлгээнд Төв, Дархан-Уул, Орхон, Увс, Сэлэнгэ аймгийн 8 сумын хүнсний ногооны тариалан эрхлэгч 300 өрхийг хамруулсан ба төслийн үр дүнд тэдний хүнсний ногоо, газар тариалангаас олж байгаа дундаж орлогын хэмжээ 13.5%-иар өссөн байна.

